



Нэгдсэн Үндэстний байгууллага

**The United Nations Organization**

Организация объединённых наций (ООН)

(АНУ-ын Нью-Йорк хот, 1945)

# IV БҮЛЭГ

## НҮБ-ЫН БУСАД БАРИМТ БИЧГҮҮД



## 25. Мансууруулах эмийн тухай нэгдсэн Конвенц

1.а. Гэрээний нэр англиар:	The Single Convention on Narcotic Drugs
1.б. Гэрээний нэр оросоор:	Единая Конвенция о наркотических средствах
2. Гэрээ байгуулагдсан огноо, улс, хот:	1961-03-30. АНУ-ын Нью-Йорк хот - (New York, The USA)
3. Гэрээ хүчин төгөлдөр болсон огноо:	1964-12-13 (1972 оны Протокол нь 1975-08-08-ны өдөр хүчин төгөлдөр болсон)
4. Хэлэлцэн тохирогч Талын тоо:	2018 оны байдлаар: 186
5. Монгол Улс гэрээнд гарын үсэг зурсан, баталсан, соёрхон баталсан, нэгдэн орсон өдөр:	1990-12-06 (Их Хурал)
6. Гэрээ баталсан баримт бичгийг хадгалагч хүлээн авсан огноо:	1991-05-06
7. Монгол Улсын хувьд гэрээ хүчин төгөлдөр болсон өдөр:	(41 дүгээр зүйл: Гэрээ баталсан баримт бичгийг хадгалагч хүлээн авсанаас хойш 30 дахь хоногт)
8. Гэрээнд тайлбар (Reservation) хийсэн байдал:	Тайлбаргүй
9. Гэрээнд нэмэлт өөрчлөлт оруулсан байдал: - 1972 оны 3 дугаар сарын 25-ны өдрийн Протоколоор нэмэлт оруулсан. Энэ Протокол нь 1975 оны 8 дугаар сарын 8-ны өдөр хүчин төгөлдөр болсон. Энэ Протоколд Монгол Улс 1990-12-06-нд нэгдэн орсон.	
10. Монгол Улсын холбогдох хууль тогтоомжоос: - (Энэ конвенцийг Монгол Улс баталсан, соёрхон баталсан буюу нэгдэн орсон тухай үндсэн баримт бичгийг олоогүй)	

### Гэрээтэй холбогдсон бусад мэдээлэл:

**Narcotic** (*наркωτικός*) гэдэг үг нь явцуу утгаараа морфинтой төстэй үйлчилгээтэй, сэтгэцэд нөлөөт химийн аливаа нэгдлүүдэд хамааралтай. Грекийн эмч Гален гэгч мэдээ алдуулдаг, саатал үүсгэдэг, бие хөшөөх буюу үхлүүт байдалд оруулдаг бодисуудад тийм нэр хайрласан гэдэг. *Ναρκωσις* (narcosis) хэмээх грек үгнээс үүдэлтэй дээрх нэр томъёог Гиппократууд (Hippocrates) бие мах бод бадайрах буюу хөшсөн тохиолдолд хэрэглэж байжээ. Жишээ болгож Гален мандракийн үндэс (mandrake root), алтеркийн үр (altercus (eclata) seeds), опиумын намуу цэцгийн шүүс (poppy juice (opium)) зэргийг дурджээ. Өргөн утгаараа, "narcotic" гэдэг үг марихуан, кокаин зэрэг хууль бусаар олж авсан хар тамхийг илэрхийлдэг байна. Гэвч эдгээр бодисууд нь эмнэлгийн үүднээс хар тамхи биш юм. НҮБ-ийн системд хар тамхины талаар бодлого боловсруулагч төв байгууллага нь Мансууруулах эмийн асуудал эрхэлсэн Комисс (Commission on Narcotic Drugs) бөгөөд "мансууруулах эм" гэж албан ёсоор Мансууруулах

эмийн тухай нэгдсэн Конвенцийн 1, 2 дугаар жагсаалтад орсон байгалийн болоод нийлэг бодисуудыг ойлгож байна.

Мансууруулах эмийн тухай нэгдсэн Конвенц нь эмчилгээ, судалгааны ажилд хэрэглэхээс бусад тохиолдолд мансууруулах эм (каннабис - марихуан, гашиш, г.м., кокаин - бусад экогнины эфируудийн хамт, опиум - морфин, героин, кодеин, г.м.)-ийн үйлдвэрлэл, нийлүүлэлтийг хориглосон олон улсын гэрээ болно (Конвенцийн 1, 2, 4, 9, 12, 19 дүгээр зүйлд зааснаар энэ Конвенцид заасан мансууруулах эмийг эмчийн зөвшөөрөлтэй (рецепт буюу жороор олгож), бүртгэлтэй, бусад хязгаарлалттайгаар эмчилгээний зориулалтаар, мөн судалгааны зорилгоор хэрэглэж болно. Мөн Конвенцийн 49 дүгээр зүйлд зааснаар кокийн навч зажлах, опиум татах зэрэг уламжлалт хэрэглээг цаашид үе шаттайгаар халах зорилготойгоор зөвшөөрсөн байдаг). Уг Конвенцид 1931 оны 7 дугаар сарын 13-ны өдрийн Конвенцоос хойшхи 30 жилийн хугацаанд нийлэг аргаар гаргаж авсан метадон, петидин, морфинан зэрэг опиумын

төрлийн нийлэг бодисуудыг хамааруулжээ. Өмнөх гэрээнүүдээр зөвхөн опиум, кока, тэдгээрээс гаргаж авдаг морфин, героин, кокаин зэргийг хянаж байжээ. Иймээс 1961 оны нэгдсэн Конвенц нь өмнөх гэрээнүүдийг хамтатган, үйлчлэх хүрээг өргөжүүлэн, мөн каннабис зэрэг бодисуудыг нэмж багтаажээ. Ингэснээр 2005 оны 3 дугаар сарын байдлаар уг Конвенцоор 116 төрлийн мансууруулах эмэнд хяналт тавьж байна.

Мансууруулах эмийн асуудал эрхэлсэн Комисс болон Дэлхийн эрүүл мэндийн байгууллага (World Health Organization) уг Конвенцийн хавсралт жагсаалтуудад нэмэлт өөрчлөлт оруулах, өөрөөр хэлбэл, уг жагсаалтуудад шинэ бодис нэмэх, уг жагсаалтаас тодорхой бодисыг хасах, олон улсын хяналтанд байгаа тодорхой нэг бодисыг нэг жагсаалтаас нөгөө жагсаалтад шилжүүлэх эрхтэй байна. Харин Хар тамхинд хяналт тавих олон улсын байгууллага (The International Narcotics Control Board) нь хар тамхины үйлдвэрлэл, олон улсын худалдаа, түгээлтэд тавих хяналтыг удирдан зохион байгуулдаг байна. Хар тамхи, гэмт хэргийн асуудал эрхэлсэн НҮБ-ын Алба нь (The United Nations Office on Drugs and Crime (UNODC)) улс орнуудын байдлыг хянах, 1961 оны Конвенцийн хэрэгжилтийг хангуулах үүднээс үндэсний албадуудтай хамтран ажиллах зэргээр Хар тамхинд хяналт тавих олон улсын байгууллагын өдөр тутмын ажлыг гардан гүйцэтгэдэг байна.

Конвенцийн 36 дугаар зүйлд зааснаар Талууд уг Конвенцийг зөрчиж мансууруулах эм тариалах, үйлдвэрлэх, бэлтгэх, хадгалах, санал болгох, худалдах, түгээх, нийлүүлэх, худалдан авах, зуучлах, тээвэрлэх, импортлох, экспортлох, дамжуулан өнгөрүүлэх үйл ажиллагаа, түүнчлэн олон улсын хэмжээнд түүнтэй холбоотой гэмт хэрэгт оролцох, тийм гэмт хэрэг үйлдэхээр хуйвалдах, завдах үйл ажиллагаа, мөн холбогдох санхүүгийн операцид ял шийтгэл ногдуулах тухай заасан (Article 36 requires Parties to criminalize "cultivation, production, manufacture, extraction, preparation, possession, offering, offering for sale, distribution, purchase, sale, delivery on any terms whatsoever, brokerage, dispatch, dispatch in transit, transport, importation and exportation of drugs contrary to the provisions of this Convention," as well as "[i]ntentional participation in, conspiracy to commit and attempts to commit, any of such offences, and preparatory acts and financial operations in connexion with the offences referred to in this article"). Мөн зүйлээр хар тамхины гэмт хэрэгтнийг хүлээлгэн өгөх тухай заасан байдаг (The Article also provides for extradition of drug offenders). Тухайн гэмт

хэргийг эрх бүхий байгууллагаас ноцтой хэрэг гэж үзээгүй тохиолдолд Хэлэлцэн тохирогч аливаа Тал гэмт хэрэгтнийг хүлээлгэн өгөхөөс татгалзах эрхтэй (a Party has a right to refuse to extradite a suspect if "competent authorities consider that the offense is not sufficiently serious").

1971 оны нэмэлтээр мансууруулах эмийг буруугаар хэрэглэгч этгээд (a drug abuser)-ийн хувьд эрүүгийн ял шийтгэлийг "эмчлэн сувилах, соён гэгээрүүлэх, засан хүмүүжүүлэх, дахин нийгэмшүүлэх" (treatment, education, after-care, rehabilitation and social reintegration) арга хэмжээгээр орлуулан гүйцэтгэж болно гэж заасан.

"Буруугаар хэрэглэх" (abuse) гэдэг үгийг Конвенцид тодорхойлоогүй. Ер нь Конвенцоор хориглосон мансууруулах эмийг хэрэглэх нь буруугаар хэрэглэх хэрэг болно.

Энэхүү нэгдсэн Конвенцийг хувь хүмүүс дараах үндэслэлээр эсэргүүцдэг байна:

1. Хүн өөрийнхөө биед юу хэрэглэх нь тухайн хүний асуудал гэсэн хүний эрх чөлөөний үндсэн зарчим байдаг (It is a fundamental principle of human liberty that what you do to your own body is your own responsibility)

2. Аливаа зүйлийг хориглох нь гэмт хэрэг үйлдэх үүд хаалгыг нээдэг (Prohibition leads to crime )

3. Каннабис гэсэн жагсаалтад орсон олон мансууруулах эмийг согтууруулах ундаа болон тамхитай харьцуулбал тийм ч их хор хөнөөлтэй биш (Many of the drugs scheduled like cannabis are not that harmful, especially compared to alcohol and tobacco)

4. Хар тамхийг буруугаар хэрэглэх явдлыг ямагт эмнэлгийн асуудал гэж үзвэл зохино (Drug addiction should always be treated as a medical problem).

Энэ конвенц нь дараах 4 жагсаалттай:

**Жагсаалт I:** Жагсаалт II-т зааснаас бусад, энэхүү конвенцид хамаарах бүх эмийн жагсаалт;

**Жагсаалт II:** Опиум, түүний дотор кодеин зэрэг арай зөөлөн үйлчилгээтэй эмийн жагсаалт;

**Жагсаалт III:** Жагсаалт I, II-т орсон кодеин, ибупрофен зэрэг зарим эмийн бэлдмэл. Эдгээрт тавих хяналтыг арай зөөлөн байхаар зохицуулсан;

**Жагсаалт IV:** Энэ нь нэлээд хатуу хяналт тогтоосон, эмчилгээний зорилгоор хэрэглэж болохгүй гэж үзсэн эмийн жагсаалт бөгөөд энэ нь Жагсаалт I-ийн нэг хэсэг болно.

**Хүснэгт 22.** Хар тамхины ангилал, төрлүүд

	Байгалийн гаралтай эм (Natural Drugs- Натуральные лекарства)	Нийлэг эм Synthetic Drugs - Синтетические лекарства)	
Төв мэдрэлийн системийн үйл ажиллагааг доройтуулагч, тайвшруулагч (Depressants - депрессанты)	Опиум болон түүний төрлийн бодисууд (Opioids) - Опиум (Opium) - Морфин (Morphine) - Герион (Heroin) - Гидроморфин - Кодеин (Codeine)	- Декстроморамид - Метадон <b>Барбитуратын эмүүд:</b> - Амобарбитал - Аprobарбитал - Барбитал - Бутабарбитал - Винбарбитал - Гептабарбитал - Гексетал - Тиопентал Барбитуратын бус эмүүд: Тайвшруулагч эмүүд (Tranquillizers): - Бензодиацепин (Хлордиазепоксид, Диацепам) - Мепробомат - Метиприлон	- Норметадон - Петидин - Диаллибарбитулын хүчил - Метилфенобарбитал - Пентобарбитал - Секобарбитал - Талбутал - Циклобарбитал - Фенобарбитал Тайвшруулагч бусад эмүүд (Sedatives): - Глутетимид - Метаквалон Нойрсуулагч эмүүд (Hypnotics): - Этинамат г.м.
Төв мэдрэлийн системийн у/а-г сэдээгч (Stimulants - стимулянт)	- Кокийн навч (Coca leaf) - Кокаин (Cocaine) - Хат (Khat) - Кратом (Kratom)	Фенамин (Амфетамин)-ы эмүүд: - Амфетамин - Дексамфетамин (Декстра-) - Метамфетамин (Метил-)/ СПИД Сэдээгч бусад эмүүд: - Диэтилпропион - фентермин	- Дринамил - Метилфенидат - Фенметрацин - Эфедрин
Хий юм үзэгдүүлэгч сонсогдуулагч (Hallucinogens - галлюциногены)	- Пейот (Peyotl) (Мескалин-Mescaline) - Галлюнацын үйлчилгээ бүхий бодис агуулагч Мөөгнүүд (Псилоцибин-Psilocybin) - Диметилтриптамин (DMT-DMT) - "Үүрийн туяа" ургамлын үр (Morning Glory seeds)	- Диметилтриптамин (DMT-DMT) - Диэтилтриптамин (ДЭТ-DET) - Лизергиний хүчлийн диэтилаид (ЛСД-LSD) - Диметоксиметамфетамин (СТФ-STR) - Метилэндооксиамфетамин (МДА-MDA) - Фенциклидин (ПЦП-PCP)	
Каннабис (Cannabis)	- Цэцэгт орой - Навч - Давирхай (Азид: Ganja, charas, bhang) Ойрх Дорнодод: Hashish Хойд Африкт: Kif Европ, Хойд Америкт: - Hashish- зөвхөн давирхай - Marijuana, pot, grass, weed, tea, г.м. - навч болон орой)	- Тетрагидроканнабинол (ТГК- THC)	



## 26. Сэтгэгцэд нөлөөт бодисын тухай Конвенц

1.а. Гэрээний нэр англиар:	Convention on Psychotropic Substances
1.б. Гэрээний нэр оросоор:	Конвенция о психотропных веществах
2. Гэрээ байгуулагдсан огноо, улс, хот:	- 1971-02-21. Австри Улсын Вена хот - (Vienna, Austria)
3. Гэрээ хүчин төгөлдөр болсон огноо:	1976-08-16
4. Хэлэлцэн тохирогч Талын тоо:	2018 оны байдлаар: 184
5. Монгол Улс гэрээнд гарын үсэг зурсан, баталсан, соёрхон баталсан, нэгдэн орсон өдөр:	1999-04-22 (Их Хурал)
6. Гэрээ баталсан баримт бичгийг хадгалагч хүлээн авсан огноо:	1999-12-15
7. Монгол Улсын хувьд гэрээ хүчин төгөлдөр болсон өдөр:	(26 дугаар зүйл: Гэрээ баталсан баримт бичгийг хадгалагч хүлээн авсанаас хойш 90 дэх хоногт)
8. Гэрээнд тайлбар (Reservation) хийсэн байдал:	Тайлбаргүй
9. Гэрээнд нэмэлт өөрчлөлт оруулсан байдал:	
10. Монгол Улсын холбогдох хууль тогтоомжоос:	- (Энэ конвенцийг Монгол Улс баталсан, соёрхон баталсан буюу нэгдэн орсон тухай үндсэн баримт бичгийг олоогүй)

### Гэрээтэй холбогдсон бусад мэдээлэл:

НҮБ-ын энэ Конвенцоор 1960-аад оны үед элбэг олдцотой байсан амфетамин, барбитуратын эмүүд, психеделикүүд (psychedelics - галлюциноген (ухаан, мэдрэл гажуудуулах)-ий үйлчилгээтэй LSD г.м. бодисууд) зэрэг сэтгэгцэд нөлөөт үйлчилгээтэй эмүүд (psychoactive drugs)-д хяналт тавих асуудлыг зохицуулсан. Ингэх болсон шалтгаан нь дээрх бодисын хэрэглээ нь зөвхөн хүний эрүүл мэндэд хор хөнөөл учруулаад зогсохгүй бас тэдний оюун санаа, ёс суртахууныг доройтуулж байна гэж үзсэн. Мансууруулах эмийн тухай 1961 оны нэгдсэн Конвенцийн үйлчлэх хүрээ зөвхөн каннабис, кок, опиумын үйлчилгээтэй эмүүдээр хязгаарлагдсан учир сэтгэгцэд нөлөөт үйлчилгээтэй шинээр нээгдсэн өдий төдий тооны бодисуудыг хорьж чадахгүй байсан. Тиймээс 1971 оны энэ Конвенцоор хүний сэтгэц, мэдрэлийг гажуудуулах үйлчилгээтэй гэсэн бараг бүх төрлийн бодисыг хяналтанд авч, түүний импорт, экспорт болон хэрэглээг зөвхөн эмнэлгийн болон эрдэм шинжилгээний зориулалтаар хязгаарласан.

Засгийн газрууд энэ Конвенцийн хариуцлага хүлээлгэх тухай заалтуудыг хэрэгжүүлэхдээ сэтгэгцэд нөлөөт бодисыг буруугаар хэрэглэгч этгээдийг хорьж, саатуулахын оронд түүнийг “эмчлэн сувилах, соён гэгээрүүлэх, засан хүмүүжүүлэх, дахин нийгэмшүүлэх” (treatment, education, after-care, rehabilitation and social reintegration) арга хэмжээ авахыг зөвшөөрсөн (22 дугаар зүйл). Ингэснээр хар тамхины эсрэг дайнд хүний эрх чөлөөг хязгаарлан

боогдуулах (incarceration) арга хэмжээг эмчлэн сувилах, урьдчилан сэргийлэх (treatment and prevention) арга хэмжээгээр солих нөхцөл бүрдсэн (20 дугаар зүйл).

Энэ конвенц нь дараах 4 жагсаалттай:

**Жагсаалт I:** Нийтийн эрүүл мэндэд ноцтой эрсдэл учруулна гэж үзсэн бөгөөд эмчилгээнд хэрэглэхийг одоогоор хүлээн зөвшөөрөөгүй эмийн жагсаалт. Энэ жагсаалтад каннабис, нийлэг психоделик (тухайлбал, LSD) болон байгалийн гаралтай психоделик (зарим төрлийн орлуулагч триптамин), мөн амфетамины төрлийн стимулянтууд (катинон, MDA, MDMA (экстази)) хамаарна;

**Жагсаалт II:** Эмчилгээнд хэрэглэдэг амфетамины төрлийн стимулянтууд (дельта-9-THC (түүний дотор дронабинол, түүний нийлэг хэлбэр), амфетамин, метилфенидат);

**Жагсаалт III:** Түргэн болон дундаж үйлчилгээтэй барбитуратын бүтээгдэхүүн (эдгээрийг эмчилгээний хувьд үр дүнтэй гэх боловч буруугаар маш их хэрэглэдэг), хэт тайвшруулах (мэдээ алдуулагч) үйлчилгээтэй бензодиазепин (тухайлбал, флунизепам), өвчин намдаагч (мэдээ алдуулагч) зарим эм (бупренорфин), мөн амфетамины төрлийн ганц стимулянт - катин;

**Жагсаалт IV:** Зарим сул үйлчилгээтэй барбитуратууд (фенобарбитал, г.м.), бусад гипноз (ховсдох)-ийн үйлчилгээтэй эмүүд, зарим нэг сул үйлчилгээтэй стимулянтууд (модафинил, армодафинил, г.м.).



## 27. Мансууруулах эм, сэтгэцэд нөлөөт бодисын хууль бус эргэлтийн эсрэг НҮБ-ын Конвенц (Венийн Конвенц)

1.а. Гэрээний нэр англиар:	The UN Convention Against Illicit Traffic in Narcotic Drugs and Psychotropic Substances
1.б. Гэрээний нэр оросоор:	Конвенция Организации Объединенных Наций о борьбе против незаконного оборота наркотических средств и психотропных веществ
2. Гэрээ байгуулагдсан огноо, улс, хот:	- 1988-12-20. Австри Улсын Вена хот - (Vienna, Austria)
3. Гэрээ хүчин төгөлдөр болсон огноо:	1990-11-11
4. Хэлэлцэн тохирогч Талын тоо:	2018 оны байдлаар: 190
5. Монгол Улс гэрээнд гарын үсэг зурсан, баталсан, соёрхон баталсан, нэгдэн орсон өдөр:	2001-01-25 (Их Хурал)
6. Гэрээ баталсан баримт бичгийг хадгалагч хүлээн авсан огноо:	2003-06-25
7. Монгол Улсын хувьд гэрээ хүчин төгөлдөр болсон өдөр:	(29 дүгээр зүйл: Гэрээ баталсан баримт бичгийг хадгалагч хүлээн авсанаас хойш 90 дэх хоногт)
8. Гэрээнд тайлбар (Reservation) хийсэн байдал:	Тайлбаргүй
9. Гэрээнд нэмэлт өөрчлөлт оруулсан байдал:	
10. Монгол Улсын холбогдох хууль тогтоомжоос:	- (Энэ конвенцийг Монгол Улс баталсан, соёрхон баталсан буюу нэгдэн орсон тухай үндсэн баримт бичгийг олоогүй)

### Гэрээтэй холбогдсон бусад мэдээлэл:

Энэ Конвенц нь хар тамхинд хяналт тавих 3 гол Конвенцийн нэг юм. Энэ Конвенцоор Мансууруулах эмийн тухай 1961 оны нэгдсэн Конвенц, Сэтгэцэд нөлөөт бодисын тухай 1971 оны Конвенцийг сахиулах эрх зүйн нэмэлт механизмуудыг заасан.

Энэ Конвенц батлагдсанаар хар тамхины эсрэг дайнд дэвшил гарсан. Энэ Конвенцийн Тэргүүн хэсэгт өмнө нь авч хэрэгжүүлж ирсэн хууль сахиулах арга хэмжээний үр дүнгээс харахад хар тамхины хэрэглээ бүрэн зогсоогүй болохыг цохон тэмдэглэж (notes that previous enforcement efforts have not stopped drug use), улмаар мансууруулах болон сэтгэцэд нөлөөт эм, бодисын хууль бус эргэлтэд нийгмийн янз бүрийн давхаргууд аажим аажимаар, улам бүр идэгдэж байгааг анхааруулж (warning of “steadily increasing inroads into various social groups made by illicit traffic in narcotic drugs and psychotropic substances.”), хар тамхины худалдаа, түүнтэй холбогдох үйл ажиллагаа нь улсуудын тогтвортой байдал, аюулгүй байдал, мөн

бүрэн эрхт байдалд аюул занал учруулж (threaten the stability, security and sovereignty of States), хууль ёсны эдийн засгийг эвдэн сүйтгэж (undermine the legitimate economies) байгааг сануулсан. Ялангуяа, хар тамхи хууль бусаар хэрэглэгчдийн зах зээл болсон дэлхийн олон газарт, мөн мансууруулах болон сэтгэцэд нөлөөт эм, бодисын хууль бус үйлдвэрлэл явуулах, тэдгээрийг хууль бусаар түгээх, мөн хууль бусаар худалдаалах зорилгодоо гэм зэмгүй хүүхэд ашиглаж байгаа нь бүр тооцоолохын аргагүй аюултай болохыг дурдсан байдаг (children are used in many parts of the world as an illicit drug consumers market and for purposes of illicit production, distribution and trade in narcotic drugs and psychotropic substances, which entails a danger of incalculable gravity).

Энэ Конвенцийн ихэнх хэсэгт хар тамхитай холбоотой хөрөнгийн эх үүсвэрийг мөрдөн мөшгиж, хураан авахад улс орнууд хамтран ажиллах үүрэг өгөгдөж, зохион байгуулалттай гэмт хэрэгтэй тэмцэх асуудлыг хөндсөн. Тухайлбал, 5 дугаар зүйлд хар тамхитай холбогдсон зөрчил

үйлдэж, (мөнгө угаах байдлаар) олсон орлогыг улсын орлого болгохыг талуудаас шаардсан байдаг. Мөн уг зүйлд талууд банкны, санхүүгийн, эсхүл худалдаа арилжааны бүртгэл мэдээллийг шаардан гаргуулах, эсхүл татан авах эрхийг шүүх буюу эрх бүхий бусад байгууллагад олгох талаар заасан. Цаашилбал, энэ эрхийг хэрэгжүүлэхэд талууд банкны нууцыг хамгаалах үндэслэлээр татгалзахгүй байж болох талаар уг Конвенцид заасан байгаа.

Конвенцийн 6 дугаар зүйлд хар тамхитай холбоотой хэргийн гэмт этгээдийг харилцан шилжүүлэх тухай гэрээ байгуулаагүй улс орнууд

энэ заалтыг үндэслэн солилцох/шилжүүлэн өгөх талаар заасан. Түүнчлэн үзлэг шалгалт хийх, бараа саатуулах (хураан авах), шүүхийн бичиг баримт бүрдүүлэх, г.м. асуудлаар талууд нөгөө талын хүсэлтээр харилцан эрх зүйн туслалцаа үзүүлэхийг уг Конвенцоор шаардсан байдаг.

Конвенцийн 12 дугаар зүйлээр хар тамхи хууль бусаар үйлдвэрлэхэд хэрэглэдэг химийн угтвар бодисууд (controlled illicit drug precursor substances)-д хяналт тавих тухай зааж, хоёр хүснэгт (Table I and Table II) болгон дараах угтвар бодисуудыг жагсаан оруулсан байгаа:

**Хүснэгт 22.** Хар тамхи хууль бусаар үйлдвэрлэхэд хэрэглэдэг химийн угтвар бодисууд

Table I	Table II
Acetic anhydride	Acetone
N-Acetylanthranilic acid	Anthranilic acid
Ephedrine	Ethyl ether
Ergometrine	Hydrochloric acid <sup>a</sup>
Ergotamine	Methyl ethyl ketone
Isosafrole	Piperidine
Lysergic acid	Sulphuric acid <sup>a</sup>
3,4-Methylenedioxyphenyl-2-propanone	Toluene
Norephedrine	
4-Anilino-N-phenethylpiperidine (ANPP)	
N-Phenethyl-4-piperidone (NPP)	
Phenylacetic acid	
<i>alpha</i> -phenylacetonitrile (APAAN)	
1-Phenyl-2-propanone	
Piperonal	
Potassium permanganate	
Pseudoephedrine	
Safrole	

Эдгээр хүснэгтэд жагсаасан бодис давс хэлбээр байж болно.

а - Давсны хүчлийн болон хүхрийн хүчлийн давсыг хүснэгт II-т албаар хамааруулаагүй болно.

Энэ жагсаалтад химийн угтвар бодис шинээр нэмж оруулах эсэх асуудлыг НҮБ-ын Мансууруулах эмийн комисс (the Commission on Narcotic Drugs) шийднэ. Ийнхүү аль нэг хүснэгтэд шинээр бодис нэмж оруулахын тулд (Комиссын гишүүдийн) гуравны хоёрын санал шаардагдана. Хар тамхинд хяналт тавих олон улсын хороо (the International Narcotics Control Board) уг асуудалд шинжлэх ухааны зүгээс хяналт тавин, үнэлэлт дүгнэл өгч ажиллана.

Конвенцийн 3 дугаар зүйлд хувийн хэрэглээний зориулалтаар хар тамхи эзэмших явдлыг хориглож болох талаар дараах байдлаар заасан:

*"Талууд өөрсдийн үндсэн хуулийн зарчим, мөн өөрсдийн эрх зүйн системийн үндсэн концепцийг баримтлан, 1961 оны Конвенц, түүнд оруулсан нэмэлт өөрчлөлт, эсхүл 1971 оны Конвенцийн заалтуудыг олон улсын хэмжээнд зөрчиж, мансууруулах буюу сэтгэцэд нөлөөт эм, бодисыг хувийн хэрэглээний зориулалтаар эзэмших, худалдан авах, эсхүл тарьж ургуулах явдлыг өөрсдийн дотоодын хууль тогтоомжийн дагуу эрүүгийн гэмт хэрэг гэж үзэхэд шаардлагатай байж болох арга хэмжээ авна."*

Хар тамхинд хяналт тавих тухай өмнөх гэрээнүүд хар тамхи хэрэглэгч нарт биш, харин үйлдвэрлэгч, нийлүүлэгч нарт чиглэсэн байдаг. Философын ухааны Доктор David R. Bewley-Taylor болон Философын ухааны Доктор, Профессор Cindy Fazeu нар "Хар тамхийг олон улсын хэмжээнд хянах НҮБ-ын системийн үйлчлэл, хөдөлгөөн" (*The Mechanics and Dynamics of the UN System for International Drug Control*) гэсэн номондоо «1988 оны Конвенц хэрэглэгч болон үйлдвэрлэгч улсуудын улс төрийн тэнцлийг хангах зорилготой. Иймээс, хар тамхины хууль бус нийлүүлэлттэй тэмцэх ёстой үйлдвэрлэгч улсууд (тухайлбал, Ази, Өмнөд Америкийн хөгжиж буй орнууд)-

ын үүрэг байхаас гадна хар тамхины эрэлтийг зогсоох ёстой хэрэглэгч улсууд (тухайлбал, Европ, Хойд Америкийн аж үйлдвэржсэн улсууд)-ын үүрэг байна.» гэж тайлбарласан байдаг. *Гэсэн хэдий ч хар тамхийг хувийн хэрэглээнд хэрэглэх зорилгоор 1961 оны Конвенц, түүнд оруулсан нэмэлт өөрчлөлт, эсхүл 1971 оны Конвенцийн заалтуудыг олон улсын хэмжээнд зөрчих" гэдэг асуудал өнөө хүртэл маргаантай байсаар байна.*

Энэ Конвенцоор бас мансууруулах буюу сэтгэцэд нөлөөт эм, бодисын хууль бус эргэлтийн (наймааны) жинхэнэ эздийг олж тогтоох үүднээс барааг хяналтын дор нийлүүлэх арга (the controlled delivery) хэрэглэхийг зөвшөөрсөн байдаг.





## 28. Дипломат харилцааны тухай Венийн Конвенц

1.а. Гэрээний нэр англиар:	Vienna Convention on Diplomatic Relations
1.б. Гэрээний нэр оросоор:	Венская Конвенция о дипломатических сношениях
2. Гэрээ байгуулагдсан огноо, улс, хот:	- 1961-04-18. Австри Улсын Вена хот - (Vienna, Austria)
3. Гэрээ хүчин төгөлдөр болсон огноо:	1964-04-24
4. Хэлэлцэн тохирогч Талын тоо:	2018 оны байдлаар: 191
5. Монгол Улс гэрээнд гарын үсэг зурсан, баталсан, соёрхон баталсан, нэгдэн орсон өдөр:	1966-11-24 (АИХ)
6. Гэрээ баталсан баримт бичгийг хадгалагч хүлээн авсан огноо:	1967-01-05 (НҮБ)
7. Монгол Улсын хувьд гэрээ хүчин төгөлдөр болсон өдөр:	1967-02-04
8. Гэрээнд тайлбар (Reservation) хийсэн байдал:	-
9. Гэрээнд нэмэлт өөрчлөлт оруулсан байдал:	
10. Монгол Улсын холбогдох хууль тогтоомжоос: - (Энэ конвенцийг Монгол Улс баталсан, соёрхон баталсан буюу нэгдэн орсон тухай үндсэн баримт бичгийг олоогүй)	

### Гэрээтэй холбогдсон бусад мэдээлэл:

#### 1 дүгээр зүйлээс:

- “төлөөлөгчийн газрын тэргүүн” (“head of the mission”) гэж томилогч улсаас энэ албан тушаалд ажиллах үүрэг хүлээлгэсэн хүнийг хэлнэ;
- “төлөөлөгчийн газрын гишүүд” (“members of the mission”) гэж төлөөлөгчийн газрын тэргүүн болон мөн газрын бүрэлдэхүүний гишүүдийг хэлнэ;
- “төлөөлөгчийн газрын бүрэлдэхүүний гишүүд” (“members of the staff of the mission”) гэж төлөөлөгчийн газрын дипломат бүрэлдэхүүн, захиргаа-техникийн бүрэлдэхүүний болон үйлчлэх бүрэлдэхүүний гишүүдийг хэлнэ;
- “дипломат бүрэлдэхүүний гишүүд” (“members of the diplomatic staff”) гэж төлөөлөгчийн газрын дипломат зэрэг дэв бүхий гишүүдийг хэлнэ;
- “дипломат төлөөлөгч” (“diplomatic agent”) гэж төлөөлөгчийн газрын тэргүүн буюу төлөөлөгчийн газрын дипломат бүрэлдэхүүний гишүүнийг хэлнэ;
- “захиргаа-техникийн бүрэлдэхүүний гишүүд” (“members of the administrative and technical

staff”) гэж төлөөлөгчийн газрын захиргааны болон техникийн үйлчилгээг гүйцэтгэгч төлөөлөгчийн газрын бүрэлдэхүүний гишүүдийг хэлнэ;

- “үйлчлэх бүрэлдэхүүний гишүүд” (“members of the service staff”) гэж төлөөлөгчийн газарт үйлчлэх үүрэг гүйцэтгэж байгаа төлөөлөгчийн газрын бүрэлдэхүүний гишүүдийг хэлнэ;
- “гэрийн хувь ажилтан” (“private servant”) гэж төлөөлөгчийн газрын бүрэлдэхүүний гишүүний гэрийн ажлыг хийдэг, томилогч улсын албан хаагч биш хүнийг хэлнэ;
- “төлөөлөгчийн газрын байр” (“premises of the mission”) гэж хэн өмчилж буйг үл харгалзан төлөөлөгчийн газрын тэргүүний өргөөг оролцуулан төлөөлөгчийн газрын зорилгод ашиглаж буй барилга буюу барилгын хэсэг, мөн тухайн барилга буюу барилгын хэсгийн эзэлж буй газрыг хэлнэ.

#### 22 дугаар зүйл:

- Төлөөлөгчийн газрын байр халдашгүй байна (The premises of the mission shall be inviolable). Хүлээн авагч улсын эрх мэдэлтэн (the agents of the receiving State) төлөөлөгчийн газрын

тэргүүний зөвшөөрөлгүйгээр тэрхүү байранд орж үл болно.

2. Хүлээн авагч улс төлөөлөгчийн газрын байранд элдвээр халдах буюу хохирол учруулахаас хамгаалах, төлөөлөгчийн газрын амгалан тайван байдлыг элдвээр алдагдуулах буюу түүний нэр төрийг доромжлохоос урьдчилан сэргийлэх бүхий л арга хэмжээг авах онцгой үүрэг хүлээнэ.
3. Төлөөлөгчийн газрын байр, тавилга, бусад эд хөрөнгө, түүнчлэн төлөөлөгчийн газрын тээврийн хэрэгслийг нэгжих, албадан дайчлах, битүүмжлэх, шийдвэр гүйцэтгэлээс чөлөөлнө (The premises of the mission, their furnishings and other property thereon and the means of transport of the mission shall be immune from search, requisition, attachment or execution).

### **23 дугаар зүйл:**

1. Томилогч улс (the sending State) болон төлөөлөгчийн газрын тэргүүн төлөөлөгчийн газрын өмчилсөн буюу түрээслэсэн байрны тодорхой төрлийн үйлчилгээний төлбөрөөс бусад улс, муж, орон нутгийн аливаа татвар, хураамжаас чөлөөлөгдөнө (shall be exempt from all national, regional or municipal dues and taxes in respect of the premises of the mission, whether owned or leased, other than such as represent payment for specific services rendered).
2. Энэ зүйлд заасан татвар хураамжаас чөлөөлөх нь томилогч улс буюу төлөөлөгчийн газрын тэргүүнтэй гэрээ байгуулагч этгээдэд хүлээн авагч улсын хуулийн дагуу ногдуулах татвар, хураамжид үл хамаарна.

### **24 дүгээр зүйл:**

Төлөөлөгчийн газрын архив, баримт бичиг хэзээ ч, хаана ч халдашгүй байна (The archives and documents of the mission shall be inviolable at any time and wherever they may be).

### **27 дугаар зүйлээс:**

2. Төлөөлөгчийн газрын албан захидал харилцаа халдашгүй байна. Албан захидал харилцаа гэж төлөөлөгчийн газар, түүний чиг үүрэгт хамаарах бүх захидал харилцааг хэлнэ (The official correspondence of the mission shall be inviolable. Official correspondence means all cor-

respondence relating to the mission and its functions).

3. Дипломат шууданг задалж буюу саатуулж үл болно (The diplomatic bag shall not be opened or detained).
4. Дипломат шууданг бүрдүүлж байгаа бүх богц боодол гадна талдаа түүний шинжийг тодорхойлсон үзэгдэхүйц тэмдэгтэй байх бөгөөд түүнд зөвхөн дипломат бичиг баримт болон албан хэрэгцээнд зориулсан эд юмс байж болно.
5. Дипломат элч (the diplomatic courier) өөрийн эрх зүйн байдал, авч яваа дипломат шуудангийн богц боодлын тоог заасан албан баримт бичигтэй байх бөгөөд албан үүргээ гүйцэтгэх үедээ хүлээн авагч улсын хамгаалалтад байна. Тэрбээр хувийн халдашгүй байх бөгөөд түүнийг аливаа хэлбэрээр баривчилж буюу албадан саатуулж үл болно.
6. Томилогч улс буюу төлөөлөгчийн газар дипломат ad hoc элч (diplomatic couriers ad hoc)-ийг томилж болно. Тийм тохиолдолд энэ зүйлийн 5 дахь хэсэгт заасныг мөн баримтлах боловч тэрхүү элч хариуцаж яваа дипломат шуудангаа зохих газарт нь хүргэмэгц дээрх дархан эрх нь дуусгавар болно.
7. Дипломат шууданг нэвтрэн орохыг зөвшөөрсөн буудалд буух иргэний тээврийн нисэх онгоцны даргад хариуцуулан өгч болно. Түүнд хариуцуулсан дипломат шуудангийн богц боодлын тоог заасан албан бичиг олгох боловч түүнийг дипломат элч гэж үзэхгүй. Төлөөлөгчийн газар онгоцны даргаас дипломат шуудангаа шууд саадгүй хүлээн авахаар аль нэг гишүүнээ явуулж болно.

### **28 дугаар зүйл:**

Албан үүргээ гүйцэтгэх явцдаа төлөөлөгчийн газрын ногдуулах төлбөр хураамж бүхий л татвар, хураамжаас чөлөөлөгдөнө (The fees and charges levied by the mission in the course of its official duties shall be exempt from all dues and taxes).

### **29 дүгээр зүйл:**

Дипломат төлөөлөгчийн бие халдашгүй байна. Түүнийг ямар ч хэлбэрээр баривчлах буюу албадан саатуулж үл болно. Хүлээн авагч улс дипломат төлөөлөгчийг зохих ёсоор хүндэтгэж, түүний бие, эрх чөлөө, нэр төрд аливаа ямарваа байдлаар халдахаас

урьдчилан сэргийлэх бүхий л зохистой арга хэмжээ авна (The person of a diplomatic agent shall be inviolable. He shall not be liable to any form of arrest or detention. The receiving State shall treat him with due respect and shall take all appropriate steps to prevent any attack on his person, freedom or dignity).

### 30 дугаар зүйл:

1. Дипломат төлөөлөгчийн хувийн өргөө (The private residence of a diplomatic agent) төлөөлөгчийн газрын байрны нэгэн адил халдашгүй байна.
2. Дипломат төлөөлөгчийн бүх бичиг баримт, захидал харилцаа, 31 дүгээр зүйлийн 3 дахь хэсэгт зааснаас бусад өмч хөрөнгө нь нэгэн адил халдашгүй байна (His papers, correspondence and, except as provided in paragraph 3 of article 31, his property, shall likewise enjoy inviolability).

### 31 дүгээр зүйл:

1. Дипломат төлөөлөгч хүлээн авагч улсын эрүүгийн хэргийн харьяаллаас чөлөөлөгдөх дархан эрх эдэлнэ (A diplomatic agent shall enjoy immunity from the criminal jurisdiction of the receiving State). Мөн дор дурдсанаас бусад тохиолдолд иргэний болон захиргааны хэргийн харьяаллаас чөлөөлөгдөх дархан эрхийг эдэлнэ (He shall also enjoy immunity from its civil and administrative jurisdiction, except in the case of):
  - (a) томилогч улсын өмнөөс төлөөлөгчийн газрын хэрэгцээнд зориулан эзэмшиж байгаагаас бусад хүлээн авагч улсын нутаг дэвсгэр дээр байгаа хувийн үл хөдлөх хөрөнгөд хамаарах эд хөрөнгийн нэхэмжлэл (a real action);
  - (b) дипломат төлөөлөгч гэрээсийг биелүүлэгч, өвлөх эд хөрөнгийг харгалзагч, өвлөгч буюу өв залгамжлагчийн үүргийг томилогч улсын өмнөөс биш, хувь хүний тухайд гүйцэтгэж байгаа өвийн холбогдол бүхий нэхэмжлэл (an action);
  - (c) дипломат төлөөлөгчөөс албан үүргийнхээ хүрээнээс гадна хүлээн авагч улсад хэрэгжүүлж байгаа мэргэжлийн буюу арилжааны аливаа үйл ажиллагаатай холбоотой нэхэмжлэл (an action).
2. Дипломат төлөөлөгч нь гэрчийн хувьд мэдүүлэг өгөх үүрэггүй (A diplomatic agent is not obliged to give evidence as a witness).

3. Энэ зүйлийн 1 дэх хэсгийн (a), (b), (c) дэд хэсэгт хамаарахаас бусад тохиолдолд дипломат төлөөлөгч хүнд ямарваа гүйцэтгэх ажиллагааны арга хэмжээ авч үл болох (no measures of execution may be taken) бөгөөд арга хэмжээ авч болох тохиолдолд түүний бие буюу өргөөний халдашгүй байдлыг зөрчихгүй байна.
4. Дипломат төлөөлөгч хүлээн авагч улсын шүүхийн харьяаллаас чөлөөлөгдөх дархан эрх нь түүнийг томилогч улсын шүүхийн харьяаллаас үл чөлөөлнө (The immunity of a diplomatic agent from the jurisdiction of the receiving State does not exempt him from the jurisdiction of the sending State).

### 34 дүгээр зүйл:

Дипломат төлөөлөгч дор дурдсанаас бусад тохиолдолд хувь хүнд болон эд хөрөнгөнд ногдуулах улс, муж, орон нутгийн бүх татвар, хураамжаас чөлөөлөгдөнө:

- (a) барааны үнэ буюу үйлчилгээний хөлсөнд шингээдэг шууд биш татвар (Indirect taxes of a kind which are normally incorporated in the price of goods or services);
- (b) хүлээн авагч улсын нутаг дэвсгэрт байгаа дипломат төлөөлөгчийн хувийн үл хөдлөх хөрөнгийг томилогч улсын өмнөөс төлөөлөгчийн газрын хэрэгцээнд ашиглаж байгаа биш бол түүнд ногдуулах татвар, хураамж (Dues and taxes on private immovable property situated in the territory of the receiving State, unless he holds it on behalf of the sending State for the purposes of the mission);
- (c) 39 дүгээр зүйлийн 4 дэх хэсэгт заасны дагуу чөлөөлөгдөхөөс бусад өвлөх буюу өв залгамжлах хөрөнгөнд хүлээн авагч улсаас ногдуулдаг татвар, хураамж (Estate, succession or inheritance duties levied by the receiving State, subject to the provisions of paragraph 4 of article 39);
- (d) хүлээн авагч улсад эх сурвалж нь байгаа хувийн орлогоос авах татвар хураамж, мөн хүлээн авагч улсын арилжааны байгууллагад оруулсан хөрөнгөнд ногдуулах татвар, хураамж (Dues and taxes on private income having its source in the receiving State and capital taxes on investments made in commercial undertakings in the receiving State);
- (e) тодорхой төрлийн үйлчилгээнээс авах хураамж (Charges levied for specific services rendered);

(f) 23 дугаар зүйлд заасны дагуу чөлөөлөгдөхөөс бусад үл хөдлөх хөрөнгөнд ногдох бүртгэл, шүүх, цэс дансны болон барьцааны татвар, тэмдэгтийн хураамж (Registration, court or record fees, mortgage dues and stamp duty, with respect to immovable property, subject to the provisions of article 23).

### **36 дугаар зүйл:**

1. Хүлээн авагч улс хадгалах, тээвэрлэх болон адилтгах үйлчилгээний хураамжаас бусад гаалийн бүх татвар, холбогдох төлбөрөөс дор дурдсан эд юмсыг чөлөөлж оруулахыг өөрөө тогтоох хууль, журмын дагуу зөвшөөрнө (The receiving State shall, in accordance with such laws and regulations as it may adopt, permit entry of and grant exemption from all customs duties, taxes, and related charges other than charges for storage, cartage and similar services, on):
  - (a) төлөөлөгчийн газрын албаны хэрэгцээнд зориулсан эд юмс (Articles for the official use of the mission);
  - (b) дипломат төлөөлөгч, түүний хамт амьдран суугаа гэр бүлийн гишүүдийн гэр ахуйд зориулсан эд юмсыг оролцуулан тэдний амины хэрэглээний эд юмс (Articles for the personal use of a diplomatic agent or members of his family forming part of his household, including articles intended for his establishment).
2. Энэ зүйлийн 1 дэх хэсэгт заасны дагуу чөлөөлөхөд үл хамаарагдах эд юмс эсхүл хүлээн авагч улсын хуулиар оруулах, гаргахыг нь хориглосон, буюу хорио цээрийн дүрмээр зохицуулагдах ёстой эд юмс дипломат төлөөлөгчийн хувийн ачаа тээшинд байгаа гэж сэрдэх баттай үндэслэл байхгүй бол уг ачаа тээш үзлэгээс чөлөөлөгдөнө. Тийм үзлэг хийх бол гагцхүү дипломат төлөөлөгч буюу түүний бүрэн эрхт төлөөлөгчийг байлцуулан гүйцэтгэнэ (The personal baggage of a diplomatic agent shall be exempt from inspection, unless there are serious grounds for presuming that it contains articles not covered by the exemptions mentioned in paragraph 1 of this article, or articles the import or export of which is prohibited by the law or controlled by the quarantine regulations of the receiving State. Such inspection shall be conducted only in the presence of the diplomatic agent or of his authorized representative).

### **37 дугаар зүйл:**

1. Дипломат төлөөлөгчийн хамт амьдран суугаа гэр бүлийн гишүүд хүлээн авагч улсын иргэн биш бол 29-36 дугаар зүйлд заасан эрх ямба, дархан эрхийг эдэлнэ.
2. Төлөөлөгчийн газрын захиргаа-техникийн бүрэлдэхүүний гишүүд болон тэдэнтэй хамт амьдран суугаа гэр бүлийн гишүүд хүлээн авагч улсын иргэн биш буюу тэнд байнга оршин суудаггүй бол 29-35 дугаар зүйлд заасан эрх ямба, дархан эрхийг эдэлнэ. Гэхдээ 31 дүгээр зүйлийн 1 дэх хэсэгт заасан иргэний болон захиргааны хэргийн харьяаллаас чөлөөлөгдөх дархан эрх тэдгээр хүмүүсийн албан үүргээ гүйцэтгэхээс гадуур явуулсан үйлдэлд үл хамаарна. Мөн тэдгээр хүмүүс анх төвхнөн суухад холбогдсон эд юмсын тухайд 36 дугаар зүйлийн 1 дэх хэсэгт заасан эрх ямбыг эдэлнэ.
3. Төлөөлөгчийн газрын үйлчлэх бүрэлдэхүүний гишүүд хүлээн авагч улсын иргэн биш буюу тэнд байнга оршин суудаггүй бол албан үүргээ гүйцэтгэх явцад хийсэн үйлдлийнхээ хувьд дархан эрх эдлэж, албан ажлынхаа хөлсөнд авсан цалин нь татвар, хураамжаас чөлөөлөгдөхөөс гадна 33 дугаар зүйлд дурдсан чөлөөлөгдөх эрх эдэлнэ.
4. Төлөөлөгчийн газрын гишүүдийн гэрийн хувь ажилтнууд хүлээн авагч улсын иргэн биш буюу тэнд байнга оршин суудаггүй бол тэдний ажлын хөлсөнд авч байгаа цалин татвар, хураамжаас чөлөөлөгдөнө. Бусад зүйлийн талаар тэдгээр ажилтан зөвхөн хүлээн авагч улсаас тогтоосон хэр хэмжээнд эрх ямба, дархан эрх эдэлнэ. Гэхдээ хүлээн авагч улс төлөөлөгчийн газрын чиг үүргийг хэрэгжүүлэхэд зүй бусаар үл оролцох замаар дээрх хүмүүсийг хуульдаа захируулна.

### **38 дугаар зүйл:**

1. Дипломат төлөөлөгч нь хүлээн авагч улсын иргэн буюу тэнд байнга оршин суудаг хүн байвал хүлээн авагч улсаас олгож болох нэмэгдэл эрх ямба, дархан эрхээс гадна гагцхүү чиг үүргийнхээ дагуу хийсэн албан үйлдлийн тухайд зөвхөн шүүхийн харьяаллаас чөлөөлөгдөх дархан эрх эдэлж, халдашгүй байна.
2. Төлөөлөгчийн газрын бүрэлдэхүүний бусад гишүүн болон гэрийн хувь ажилтнууд хүлээн авагч улсын иргэн буюу тэнд байнга оршин суудаг хүмүүс байвал зөвхөн хүлээн авагч улсаас тогтоосон хэр хэмжээгээр эрх ямба, дархан эрх

эдэлнэ. Гэхдээ хүлээн авагч улс төлөөлөгчийн газрын чиг үүргийг хэрэгжүүлэхэд зүй бусаар үл оролцох замаар дээрх хүмүүсийг хуульдаа захируулна.

### 39 дүгээр зүйл:

1. Эрх ямба, дархан эрх эдлэх эрх бүхий хүн бүр албан тушаалаа хүлээн авахаар очихдоо хүлээн авагч улсын нутагт дэвсгэрт орсон мөчөөс, эсхүл нэгэнт тэр улсын нутаг дэвсгэрт байгаа бол түүний томилогдсон тухай гадаад хэргийн яам буюу хэлэлцэн тохирсон өөр нэг яаманд мэдэгдсэн мөчөөс эхлэн уг эрх ямба, дархан эрхийг эдэлнэ (Every person entitled to privileges and immunities shall enjoy them from the moment he enters the territory of the receiving State on proceeding to take up his post or, if already in its territory, from the moment when his appointment is notified to the Ministry for Foreign Affairs or such other ministry as may be agreed).
2. Эрх ямба, дархан эрх эдлэгч хүний албан үүрэг дуусгавар болоход тэрхүү эрх ямба, дархан эрх уг хүнийг тухайн улсаас гарсан буюу гарч болох боломжийн хугацаа дууссан мөчөөс эхлэн ердийн байдлаар дуусгавар болох бөгөөд харин тэр хүртэл зэвсэгт мөргөлдөөн гарсан ч хүчинтэй хэвээр байна. Гэхдээ уг хүн төлөөлөгчийн газрын гишүүний хувьд үүргээ гүйцэтгэх үед хийсэн үйлдлийн тухайд дархан эрх хэвээр хадгалагдана (When the functions of a person enjoying privileges and immunities have come to an end, such privileges and immunities shall normally cease at the moment when he leaves the country, or on expiry of a reasonable period in which to do so, but shall subsist until that time, even in case of armed conflict. However, with respect to acts performed by such a person in the exercise of his functions as a member of the mission, immunity shall continue to subsist).
3. Төлөөлөгчийн газрын гишүүн нас барсан тохиолдолд эрх ямба, дархан эрх бүхий түүний гэр бүлийн гишүүд хүлээн авагч улсаас гарч явахад шаардагдах боломжийн хугацаа дуустал уг эрх ямба, дархан эрхээ эдэлнэ.
4. Хүлээн авагч улсын иргэн биш буюу тэнд байнга оршин сууж байгаагүй төлөөлөгчийн газрын гишүүн, эсхүл түүний хамт амьдран сууж байсан гэр бүлийн гишүүн нас барвал тухайн улсад худалдан авсан бөгөөд уг хүнийг нас барах үед гадаадад гаргахыг хориглосон аливаа эд

хөрөнгөөс бусад хөдлөх эд хөрөнгийг гаргахыг хүлээн авагч улс зөвшөөрнө. Нас барагчийн гагцхүү төлөөлөгчийн газрын гишүүний хувьд буюу түүний гэр бүлийн гишүүний хувьд хүлээн авагч улсад сууж байсантай шууд холбогдон тэнд байгаа хөдлөх хөрөнгөнд өвийн татвар, өв залгамжлалын хураамж ногдуулахгүй.

### 40 дүгээр зүйл:

1. Дипломат төлөөлөгч албан тушаалдаа орох буюу уг албандаа эргэн очих, эсхүл эх орондоо буцах замдаа шаардлагатай бол виз олгосон гуравдахь улсын нутаг дэвсгэрийг дамжин өнгөрөх буюу уг нутаг дэвсгэрт байхад тэрхүү гуравдахь улс түүнд халдашгүй байх эрхийг эдлүүлэхийн хамт түүний дамжин өнгөрөх буюу буцахад нь шаардагдах бусад дархан эрхийг эдлүүлнэ. Энэ заалт дипломат төлөөлөгчийг дагалдан яваа, эсхүл түүнтэй нийлэхээр буюу эх орондоо буцахаар тусдаа яваа дипломат эрх ямба, дархан эрх бүхий түүний гэр бүлийн аль ч гишүүнд нэгэн адил хамаарна.
2. Энэ зүйлийн 1 дэх хэсэгт заасантай адил нөхцөл байдалд төлөөлөгчийн газрын захиргаа-техникийн буюу үйлчлэх бүрэлдэхүүний гишүүд, тэдний гэр бүлийн гишүүдийг нутаг дэвсгэрээр нь дамжин өнгөрөхөд гуравдахь улс саад хийж үл болно.
3. Гурав дахь улс нутаг дэвсгэрээр нь дамжин өнгөрч байгаа нууц түлхүүртэй буюу шифрлэсэн илгээлтийг оролцуулан албан захидал, бусад албан мэдээг хүлээн авагч улсын нэгэн адил хамгаалж, чөлөөтэй нэвтрүүлнэ. Тэдгээр улс хэрэв шаардлагатай бол виз олгосон дипломат элчид, мөн дамжин өнгөрч байгаа дипломат шууданд хүлээн авагч улсын нэгэн адил халдашгүй байх эрх олгож, хамгаална.
4. Энэ зүйлийн 1, 2, 3 дахь хэсэгт заасны дагуу гуравдахь улсуудын хүлээх үүрэг нь тэдгээрт дурдсан хүмүүс, албан харилцааны мэдээ, дипломат шуудан гуравдахь улсын нутаг дэвсгэрт давагдашгүй хүчин зүйлийн шалтгаанаар нэвтрэн орсон тохиолдолд нэгэн адил хамаарна.



## 29. Консулын харилцааны тухай Венийн Конвенц

1.а. Гэрээний нэр англиар:	Vienna Convention on Consular Relations
1.б. Гэрээний нэр оросоор:	Венская Конвенция о консульских сношениях
2. Гэрээ байгуулагдсан огноо, улс, хот:	- 1963-04-24. Австри Улсын Вена хот - (Vienna, Austria)
3. Гэрээ хүчин төгөлдөр болсон огноо:	1967-03-19
4. Хэлэлцэн тохирогч Талын тоо:	2018 оны байдлаар: 179
5. Монгол Улс гэрээнд гарын үсэг зурсан, баталсан, соёрхон баталсан, нэгдэн орсон өдөр:	1988-06-20 (АИХ)
6. Гэрээ баталсан баримт бичгийг хадгалагч хүлээн авсан огноо:	1989-03-14
7. Монгол Улсын хувьд гэрээ хүчин төгөлдөр болсон өдөр:	1989-04-13
8. Гэрээнд тайлбар (Reservation) хийсэн байдал:	-
9. Гэрээнд нэмэлт өөрчлөлт оруулсан байдал:	
10. Монгол Улсын холбогдох хууль тогтоомжоос:	- (Энэ конвенцийг Монгол Улс баталсан, соёрхон баталсан буюу нэгдэн орсон тухай үндсэн баримт бичгийг олоогүй)

### Гэрээтэй холбогдсон бусад мэдээлэл:

#### 1 дүгээр зүйл. Нэр томъёо

1. Дор дурдсан нэр томъёо нь энэхүү Конвенцид дараах утга илэрхийлнэ:
  - (a) “консулын байгууллага” (“consular post”) гэж аливаа ерөнхий консулын газар, консулын газар, дэд консулын газар буюу консулын төлөөлөгчийн газрыг хэлнэ;
  - (b) “консулын тойрог” (“consular district”) гэж консулын байгууллагад консулын чиг үүрэг гүйцэтгэхэд нь зориулан тогтоосон газар нутгийг хэлнэ;
  - (c) “консулын байгууллагын тэргүүн” (“head of consular post”) гэж энэ албан тушаалд ажиллах чиг үүрэг хүлээсэн хүнийг хэлнэ;
  - (d) “консулын албан тушаалтан” (“consular officer”) гэж консулын байгууллагын тэргүүнийг оролцуулан энэ албан тушаалд консулын чиг үүрэг гүйцэтгэх үүрэг хүлээсэн аливаа хүнийг хэлнэ;
  - (e) “консулын албан хаагч” (“consular employee”) гэж консулын байгууллагад

- захиргаа буюу техникийн үүрэг гүйцэтгэж байгаа аливаа хүнийг хэлнэ;
- (f) “үйлчлэх бүрэлдэхүүний гишүүн” (“member of the service staff”) гэж консулын байгууллагад үйлчлэх үүрэг гүйцэтгэж байгаа аливаа хүнийг хэлнэ;
- (g) “консулын байгууллагын гишүүд” (“members of the consular post”) гэж консулын албан тушаалтан, консулын албан хаагчид болон үйлчлэх бүрэлдэхүүний гишүүдийг хэлнэ;
- (h) “консулын бүрэлдэхүүний гишүүд” (“members of the consular staff”) гэж консулын байгууллагын тэргүүнээс бусад консулын албан тушаалтан, мөн консулын албан хаагч болон үйлчлэх бүрэлдэхүүний гишүүдийг хэлнэ;
- (i) “гэрийн хувь ажилтан” (“member of the private staff”) гэж консулын байгууллагын гишүүнд гагцхүү хувиараа үйлчилж байгаа хүнийг хэлнэ;
- (j) “консулын байр” (“consular premises”) гэж хэн өмчилж буйг үл харгалзан зөвхөн консулын байгууллагын зорилгод ашиглаж байгаа барилга

буюу барилгын хэсэг, мөн тэрхүү барилга буюу барилгын хэсгийн эзэлж буй газрыг хэлнэ;

- (k) “консулын архив” (“consular archives”) гэж консулын байгууллагын бүх баримт бичиг, захидал, ном, дүрс бичлэг, авиа бичлэгийн хальс, данс бүртгэл, шифр, нууц түлхүүр, картын сан болон тэдгээрийг хадгалж хамгаалахад зориулсан аливаа тавилга төхөөрөмжийг хэлнэ.
2. Консулын албан тушаалтан хоёр зэрэглэлтэй байна, тухайлбал орон тооны консулын албан тушаалтан (career con-

sular officers), өргөмжит консулын албан тушаалтан (honorary consular officers) гэж байна. Энэхүү Конвенцийн II бүлгийн заалт орон тооны консулын албан тушаалтны тэргүүлсэн консулын байгууллагад, III бүлгийн заалт өргөмжит консулын албан тушаалтан нарын тэргүүлсэн консулын байгууллагад хамаарна.

3. Консулын байгууллагын гишүүд хүлээн авагч улсын иргэн буюу уг улсад байнга оршин суугч байвал тэдний эрхийн байдлыг энэхүү Конвенцийн 71 дүгээр зүйлд заасны дагуу зохицуулна.

## **I БҮЛЭГ. КОНСУЛЫН ХАРИЛЦААНЫ ТУХАЙ НИЙТЛЭГ ЗААЛТ** (CHAPTER I. CONSULAR RELATIONS IN GENERAL) (2-27 дугаар зүйл)

### **I ДЭД БҮЛЭГ. КОНСУЛЫН ХАРИЛЦАА ТОГТООХ, ХЭРЭГЖҮҮЛЭХ** (SECTION I. ESTABLISHMENT AND CONDUCT OF CONSULAR RELATIONS) (2-24 дүгээр зүйл)

#### **9 дүгээр зүйл. Консулын байгууллагын тэргүүний зиндаа (Classes of heads of consular posts)**

1. Консулын байгууллагын тэргүүнүүдийг дараах дөрвөн зиндаанд хуваана:

- (a) ерөнхий консул (consuls-general);
- (b) консул (consuls);
- (c) дэд консул (vice-consuls);
- (d) консулын төлөөлөгч (consular agents).

### **II ДЭД БҮЛЭГ. КОНСУЛЫН ЧИГ ҮҮРЭГ ДУУСАХ** (SECTION II. END OF CONSULAR FUNCTIONS) (25-27 дугаар зүйл)

## **II БҮЛЭГ. КОНСУЛЫН БАЙГУУЛЛАГА, ОРОН ТООНЫ КОНСУЛЫН АЛБАН ТУШААЛТАН БОЛОН КОНСУЛЫН БАЙГУУЛЛАГЫН БУСАД ГИШҮҮНИЙ ДАВУУ ЭРХ, ЭРХ ЯМБА, ДАРХАН ЭРХ** (CHAPTER II. FACILITIES, PRIVILEGES AND IMMUNITIES RELATING TO CONSULAR POSTS, CAREER CONSULAR OFFICERS AND OTHER MEMBERS OF A CONSULAR POST) (28-57 дугаар зүйл)

### **I ДЭД БҮЛЭГ. КОНСУЛЫН БАЙГУУЛЛАГЫН ДАВУУ ЭРХ, ЭРХ ЯМБА, ДАРХАН ЭРХ** (SECTION I. FACILITIES, PRIVILEGES AND IMMUNITIES RELATING TO A CONSULAR POST) (28-39 дүгээр зүйл)

31 дүгээр зүйл. Консулын байрны халдашгүй байдал

1. Консулын байр энэ зүйлд заасан хэмжээнд халдашгүй байна.
2. Консулын байгууллагын тэргүүн, түүний нэр заасан хүн буюу томилогч улсын дипломат төлөөлөгчийн газрын тэргүүний зөвшөөрөлгүйгээр консулын байрны зөвхөн консулын байгууллагын албан ажилд зориулсан хэсэгт хүлээн авагч улсын эрх бүхий байгууллага нэвтрэх эрхгүй. Гэвч гал түймэр буюу хамгаалах арга хэмжээ хойшлуулашгүй авах шаардлагатай гэнэтийн бусад аюул тохиолдвол консулын байгууллагын тэргүүний зөвшөөрөл байгаа гэж үзэж болно.

3. Хүлээн авагч улс консулын байранд элдвээр халдах буюу хохирол учруулахаас хамгаалах, консулын байгууллагын амгалан тайван байдлыг элдвээр алдагдуулах, нэр төрийг доромжлохоос урьдчилан сэргийлэх зохистой бүхий л арга хэмжээг энэ зүйлийн 2 дахь хэсэгт заасныг баримтлан авах онцгой үүрэг хүлээнэ.

4. Консулын байр, түүн доторх тавилга эд хогшил, консулын байгууллагын эд хөрөнгө болон унаа хөсөг улсын батлан хамгаалах буюу нийгмийн хэрэгцээний ямар нэг дайчилгаанаас чөлөөлөгдөх дархан эрх эдлэнэ. Хэрэв дээр дурдсан зорилгоор байрыг дайчлах шаардлага гарвал консулын үүрэгт ажлаа гүйцэтгэхэд нь саад болохооргүй боломжийн бүх арга хэмжээг авч, томилогч улсад дүйх хэмжээний нөхөн төлбөрийг нэн даруй төлнө

32 дугаар зүйл. Консулын байрыг татвар хураамжаас чөлөөлөх

1. Томилогч улсын буюу түүнийг төлөөлсөн аливаа хүний өмчилсэн буюу түрээсэлсэн консулын байр, консулын байгууллагын орон тооны тэргүүний өргөөг тодорхой төрлийн

үйлчилгээний хөлсөөс бусад улс, муж, орон нутгийн бүх татвар, хураамжаас чөлөөлнө.

2. Энэ зүйлийн 1 дэх хэсэгт заасны дагуу татвар, хураамжаас чөлөөлөх нь томилогч улс буюу түүнийг төлөөлсөн хүнтэй гэрээ байгуулсан хүн хүлээн авагч улсын хуулийн дагуу ногдуулах татвар, хураамжид үл хамаарна.

33 дугаар зүйл. Консулын архив, баримт бичгийн халдашгүй байдал

Консулын архив, бичиг баримт хэдийд ч, хаана ч халдашгүй байна.

39 дүгээр зүйл. Консулын хураамж

1. Консулын байгууллага хүлээн авагч улсын нутаг дэвсгэрт консулын үйлдэл хийхдээ томилогч улсын хууль, журамд заасан төлбөр, хураамж авч болно.

2. Энэ зүйлийн 1 дэх хэсэгт дурдсан төлбөр, хураамжийн хэлбэрээр авсан мөнгө, мөн ийм төлбөр, хураамж авсан баримт нь хүлээн авагч улсын бүх татвар, хураамжаас чөлөөлөгдөнө.

## **II ДЭД БҮЛЭГ. ОРОН ТООНЫ КОНСУЛЫН АЛБАН ТУШААЛТАН, КОНСУЛЫН БАЙГУУЛЛАГЫН БУСАД ГИШҮҮНИЙ ДАВУУ ЭРХ, ЭРХ ЯМБА, ДАРХАН ЭРХ**

(SECTION II. FACILITIES, PRIVILEGES AND IMMUNITIES RELATING TO CAREER CONSULAR OFFICERS AND OTHER MEMBERS OF A CONSULAR POST) (40-57 дугаар зүйл)

50 дугаар зүйл. Гаалийн татвар, үзлэгээс чөлөөлөх

1. Хүлээн авагч улс хадгалах, тээвэрлэх болон адилтгах үйлчилгээний хураамжаас бусад гаалийн бүх татвар, холбогдох төлбөрөөс дор дурдсан эд юмсыг чөлөөлж оруулахыг өөрөө тогтоох хууль, журмын дагуу зөвшөөрнө:

(a) консулын байгууллагын албан хэрэгцээнд зориулсан эд юмс;

(b) консулын албан тушаалтан, түүнтэй хамт амьдран суугаа гэр бүлийн гишүүдийн гэр ахуйд зориулсан эд юмсыг оролцуулан тэдний амины хэрэглээний эд юмс; Хэрэглээний эд юмсын тоо нь холбогдох хүмүүсийн шууд хэрэгцээнд шаардагдах хэмжээнээс хэтрэхгүй байвал зохино.

2. Консулын албан хаагчид энэ зүйлийн 1 дэх хэсэгт заасан эрх ямба, хөнгөлөлтийг анх төвхнөн суурьших үедээ авчирсан эд юмсын тухайд эдэлнэ.

3. Консулын албан тушаалтан, тэдний хамт амьдран суугаа гэр бүлийн гишүүдийн авч яваа хувийн ачаа тээш гаалийн үзлэгээс чөлөөлөгдөнө. Энэ зүйлийн 1 дэх хэсгийн (b) дэд хэсэгт зааснаас өөр эд юмс, эсхүл хүлээн авагч улсын хууль, журмаар оруулах, гаргахыг нь хориглосон буюу хорио цээрийн дүрмээр зохицуулагдах ёстой эд юмс ачаа тээшинд байгаа гэж сэрдэх баттай үндэслэл байгаа тохиолдолд л гаалийн үзлэг хийж болно. Тийм үзлэг хийх бол холбогдох консулын албан тушаалтан буюу түүний гэр бүлийн гишүүнийг байлцуулан гүйцэтгэнэ.

51 дүгээр зүйл. Консулын байгууллагын гишүүн, тэдний гэр бүлийн гишүүдийн өв хөрөнгө

Консулын байгууллагын гишүүн, эсхүл түүнтэй хамт амьдран сууж байсан гэр бүлийн гишүүн нас барсан тохиолдолд хүлээн авагч улс:

(a) хүлээн авагч улсад худалдан авсан бөгөөд



уг хүнийг нас барах үед гадаадад гаргахыг хориглосон түүний аливаа бусад хөдлөх эд хөрөнгийг гаргахыг зөвшөөрнө;

(b) нас барагч гагцхүү консулын байгууллагын гишүүний хувьд буюу түүний гэр бүлийн гишүүний хувьд хүлээн авагч улсад сууж байсантай шууд холбогдон тэнд байгаа хөдлөх эд хөрөнгөнд улс, муж, орон нутгийн өвийн болон өв залгамжлалын ямар нэгэн хураамж, түүнчлэн эд хөрөнгө шилжүүлэх хураамж ногдуулахгүй.

53 дугаар зүйл. Консулын эрх ямба, дархан эрх эдлэж эхлэх, дуусах

1. Консулын байгууллагын гишүүн бүр албан тушаалаа хүлээн авахаар очихдоо хүлээн авагч улсын нутаг дэвсгэрт орсон мөчөөс, эсхүл нэгэнт тэр улсын нутаг дэвсгэрт байгаа бол консулын байгууллагад үүрэгт ажлаа гүйцэтгэж эхэлсэн мөчөөс эхлэн энэхүү Конвенцид заасан эрх ямба, дархан эрхийг эдэлнэ.
2. Консулын байгууллагын гишүүний хамт амьдран суугаа гэр бүлийн гишүүд болон гэрийн хувь ажилтан энэ зүйлийн 1 дэх хэсэгт заасны дагуу уг гишүүнд эрх ямба, дархан эрх олгосон мөчөөс, эсхүл тэд хүлээн авагч улсын нутаг дэвсгэрт орсон буюу уг гишүүний гэр бүлийн гишүүн буюу гэрийн хувь ажилтан болсон мөчөөс эхлэн эдгээрийн аль нь сүүлд тохиолдсоныг харгалзан энэхүү Конвенцид заасан эрх ямба, дархан эрхийг эдэлнэ.

3. Консулын байгууллагын гишүүний албан үүрэг дуусгавар болоход уг хүнийг хүлээн авагч улсын нутаг дэвсгэрээс гарсан буюу гарч болох боломжийн хугацаа дууссан мөчөөс эхлэн эдгээрийн аль нь түрүүнд тохиолдсоныг харгалзан түүний эрх ямба, дархан эрх, мөн түүнтэй хамт амьдран суугаа гэр бүлийн гишүүд, гэрийн хувь ажилтны эрх ямба, дархан эрх ердийн байдлаар дуусгавар болох бөгөөд харин тэр хугацааг дуусах хүртэл зэвсэгт мөргөлдөөн гарсан ч эрх ямба, дархан эрх хүчинтэй хэвээр байна. Энэ зүйлийн 2 дахь хэсэгт дурдсан хүмүүсийн тухайд гэвэл тэд консулын байгууллагын гишүүний гэр бүлийн гишүүн байхаа больсон буюу уг гишүүнд хувиар үйлчлэхээ больсон мөчөөс эрх ямба, дархан эрх эдлэх нь дуусгавар болно, гэхдээ тэдгээр хүн хүлээн авагч улсаас боломжийн хугацаанд гарах гэж байгаа бол тэднийг явах хүртэл эрх ямба, дархан эрх нь хүчинтэй хэвээр байна.
4. Харин консулын албан тушаалтан буюу консулын албан хаагчид үүрэгт ажлаа гүйцэтгэх үед хийсэн үйлдлийн тухайд шүүхийн харьяаллаас чөлөөлөгдөх дархан эрх нь хугацаагүй хэвээр байна.
5. Консулын байгууллагын гишүүн нас барсан тохиолдолд түүнтэй хамт амьдран сууж байсан гэр бүлийн гишүүд нь хүлээн авагч улсаас гарч явах буюу гарах боломжийн хугацаа дуусах мөч хүртэл эдгээрийн аль нь түрүүнд тохиолдохыг харгалзан, олгогдсон эрх ямба, дархан эрхээ хэвээр эдэлнэ.

### III БҮЛЭГ. ӨРГӨМЖИТ КОНСУЛЫН АЛБАН ТУШААЛТАН, ТЭДНИЙ ТЭРГҮҮЛСЭН КОНСУЛЫН БАЙГУУЛЛАГАД ХАМААРАХ ДЭГЛЭМ

(CHAPTER III. REGIME RELATING TO HONORARY CONSULAR OFFICERS AND CONSULAR POSTS HEADED BY SUCH OFFICERS) (58-68 дугаар зүйл)

58 дугаар зүйл. Давуу эрх, эрх ямба, дархан эрхэд холбогдох нийтлэг заалт 1. 28, 29, 30, 34, 35, 36, 37, 38, 39 дүгээр зүйл, 54 дүгээр зүйлийн 3 дахь хэсэг, 55 дугаар зүйлийн 2, 3 дахь хэсгийн заалт өргөмжит консулын албан тушаалтны тэргүүлсэн консулын байгууллагад хамаарна. Мөн ийм консулын байгууллагын давуу эрх, эрх ямба, дархан эрхийг 59, 60, 61, 62 дугаар зүйлээр зохицуулна.

2. 42, 43 дугаар зүйл, 44 дүгээр зүйлийн 3 дахь хэсэг, 45, 53 дугаар зүйл, 55 дугаар зүйлийн

1 дэх хэсгийн заалт өргөмжит консулын албан тушаалтанд хамаарна. Мөн тэдгээр албан тушаалтны давуу эрх, эрх ямба, дархан эрхийг 63, 64, 65, 66, 67 дугаар зүйлээр зохицуулна.

3. Энэхүү Конвенцид заасан эрх ямба, дархан эрх өргөмжит консулын албан тушаалтны гэр бүл буюу өргөмжит консулын албан тушаалтны тэргүүлсэн консулын газарт ажилладаг консулын албан хаагчийн гэр бүлийн гишүүдэд хамаарахгүй.

62 дугаар зүйл. Гаалийн татвараас чөлөөлөх (зохиогчийн засварыг *italic*-аар тусгав)

Хүлээн авагч улс өргөмжит консулын албан тушаалтны тэргүүлсэн консулын байгууллагын гагцхүү албан хэрэгцээний дараах эд юмсыг хадгалах, тээвэрлэх болон адилтгах үйлчилгээний хураамжаас бусад гаалийн бүх татвар, хураамж, холбогдох төлбөрөөс чөлөөлж оруулахыг өөрөө тогтоох хууль, журмын дагуу зөвшөөрнө: тухайн консулын байгууллагад томилогч улсаас нь нийлүүлсэн, эсхүл тухайн консулын байгууллага томилогч

улсынхаа шаардлагаар авсан төрийн сүлд, далбаа, хаяг, тамга, тэмдэг, ном, албаны хэвлэмэл материал, бичиг хэргийн (албан өрөөний/албан тасалгааны) тавилга, бичиг хэргийн (албан өрөөний/албан тасалгааны) тоног хэрэгсэл болон тэдгээртэй адилтгах бусад эд зүйл (coats-of-arms, flags, signboards, seals and stamps, books, official printed matter, office furniture, office equipment and similar articles supplied by or at the instance of the sending State to the consular post).

#### **IV БҮЛЭГ. НИЙТЛЭГ ЗААЛТУУД**

(CHAPTER IV. GENERAL PROVISIONS) (69-73 дугаар зүйл)

69 дүгээр зүйл. Консулын байгууллагын тэргүүн биш консулын төлөөлөгч (Consular agents who are not heads of consular posts)

70 дугаар зүйл. Дипломат төлөөлөгчийн газар консулын чиг үүрэг гүйцэтгэх (Exercise of consular functions by diplomatic missions)

#### **V БҮЛЭГ. ТӨГСГӨЛИЙН ЗААЛТ**

(CHAPTER V. FINAL PROVISIONS) (74-79 дүгээр зүйл)



### 30. Олон улсын хэмжээнд бараа худалдах, худалдан авах гэрээний тухай НҮБ-ын Конвенц

1.а. Гэрээний нэр англиар:	The UN Convention on Contracts for International Sale of Goods
1.б. Гэрээний нэр оросоор:	Конвенция о договорах международной купли-продажи товаров
2. Гэрээ байгуулагдсан огноо, улс, хот:	- 1980-04-11. Австри Улсын Вена хот - (Vienna, Austria)
3. Гэрээ хүчин төгөлдөр болсон огноо:	1988-01-01
4. Хэлэлцэн тохирогч Талын тоо:	2018 оны байдлаар: 89
5. Монгол Улс гэрээнд гарын үсэг зурсан, баталсан, соёрхон баталсан, нэгдэн орсон өдөр:	1997-07-09
6. Гэрээ баталсан баримт бичгийг хадгалагч хүлээн авсан огноо:	1997-12-31
7. Монгол Улсын хувьд гэрээ хүчин төгөлдөр болсон өдөр:	1999-01-01
8. Гэрээнд тайлбар (Reservation) хийсэн байдал:	-
9. Гэрээнд нэмэлт өөрчлөлт оруулсан байдал:	
10. Монгол Улсын холбогдох хууль тогтоомжоос: - (Энэ конвенцийг Монгол Улс баталсан, соёрхон баталсан буюу нэгдэн орсон тухай үндсэн баримт бичгийг олоогүй)	

#### Гэрээтэй холбогдсон бусад мэдээлэл:

Энэ конвенцийг ерөнхийдөө “Бараа худалдах-худалдан авах олон улсын гэрээний тухай конвенц” гэж орчуулсан байгаа.

#### I ХЭСЭГ. ХАМРАХ ХҮРЭЭ БА НИЙТЛЭГ ҮНДЭСЛЭЛ

(PART I - Sphere of Application and General Provisions - Часть I. Сфера применения и общие положения) (1-13 дугаар зүйл)

I бүлэг. ХАМРАХ ХҮРЭЭ (Chapter I - Sphere of Application - Глава I. Сфера применения) (1-6 дугаар зүйл): Энэ Конвенцийг бизнес эрхэлдэг газар нь өөр өөр улсад байгаа талуудын хооронд байгуулсан бараа худалдах, худалдан авах гэрээнд дараах тохиолдолд мөрдөнө (to contracts of sale of goods between parties whose places of business are in different States - к договорам купли-продажи товаров между сторонами, коммерческие предприятия которых находятся в разных государствах):

(a) холбогдох Улсууд нь энэ Конвенцийн Хэлэлцэн тохирогч Талууд байх (when the States are Contracting States - когда эти государства являются Договаривающимися государствами); эсхүл

(b) олон улсын хувийн эрх зүйн хэм хэмжээний дагуу Хэлэлцэн тохирогч аль нэг Талын дотоодын хууль тогтоомж мөрдөхөөр бол (when the rules of private international law lead to the application of the law of a Contracting State - когда, согласно нормам международного частного права, применимо право Договаривающегося государства).

Талуудын бизнес эрхэлдэг газар өөр өөр улсад байгаа гэдэг нь холбогдох гэрээнээс, эсхүл уг гэрээг байгуулахаас өмнө буюу байгуулах үед тогтсон ажил хэргийн харилцаа, эсхүл мөн хугацаанд тэдний хооронд дамжуулсан мэдээллээс харагдахгүй бол уг шаардлагыг авч хэрэгсэхгүй.

Энэ Конвенцийг мөрдөх эсэх асуудлыг шийдэхэд гэрээ байгуулсан талуудын иргэний харъяалал (иргэншил), эсхүл тэдгээр талуудын нийгмийн байдал, худалдаа эрхлэх эрх хэмжээ, эсхүл холбогдох гэрээний тийм шинж байдлыг харгалзан үзэхгүй.

Энэ Конвенц дараах худалдаанд хамаарахгүй:

- (a) барааг хувийн, гэр бүлийн, эсхүл айл өрхийн хэрэглээний зориулалтаар худалдан авсан болохыг худалдагч тухайн гэрээ байгуулахаас өмнө буюу байгуулах үед мэдэж байсан, эсхүл мэдэх боломжтой байснаас бусад тохиолдолд тийм зориулалттай бараа худалдан авсан (sale of goods bought for personal, family or household use - продажа товаров, которые приобретаются для личного, семейного или домашнего использования);
- (b) дуудлагын худалдаа (sale by auction - продажа с аукциона);
- (c) тогтоол гүйцэтгэлийн журмаар буюу хуулийн хүчээр албадан хийгдсэн худалдаа (sale on execution or otherwise by authority of law - продажа в порядке исполнительного производства или иным образом в силу закона);
- (d) үнэт цаас, хувьцаа, хөрөнгө оруулалтын эрхийн бичиг, банкны эргэлтийн бичиг баримт, эсхүл мөнгөн хөрөнгийн худалдаа/арилжаа (sale of stocks, shares, investment securities, negotiable instruments or money - продажа фондовых бумаг, акций, обеспечительных бумаг, оборотных документов и денег);
- (e) завь, усан онгоц, агаарт хөвөх хэрэгсэл, нисэх онгоцны худалдаа (sale of ships, vessels, hovercraft or aircraft - продажа судов водного и воздушного транспорта, а также судов на воздушной подушке);
- (f) цахилгаан эрчим хүчний худалдаа (sale of electricity - продажа электроэнергии).

## **II БҮЛЭГ. НИЙТЛЭГ ҮНДЭСЛЭЛ**

(Chapter II - General Provisions - Глава II. Общие положения) (7-13 дугаар зүйл)

## **II ХЭСЭГ. ГЭРЭЭ БАЙГУУЛАХ**

(PART II - Formation of the Contract - Часть II. Заключение договора) (14-24 дүгээр зүйл)

## **III ХЭСЭГ. БАРАА ХУДАЛДАХ-ХУДАЛДАН АВАХ**

(PART III - Sale of Goods - Часть III. Купля-продажа товаров) (25-88 дугаар зүйл)

### **I БҮЛЭГ. НИЙТЛЭГ ҮНДЭСЛЭЛ**

(Chapter I - General Provisions - Глава I. Общие положения) (25-29 дүгээр зүйл)

### **II БҮЛЭГ. ХУДАЛДАГЧИЙН ҮҮРЭГ**

(Chapter II - Obligations of the Seller - Глава II. Обязательства продавца) (30-52 дугаар зүйл)

#### **I дэд бүлэг.** Барааг нийлүүлэх, бичиг баримт хүргүүлэх

(Section I - Delivery of the goods and handing over of documents - Раздел I. Поставка товара и передача документов) (31-34 дүгээр зүйл)

**II дэд бүлэг.** Барааг гэрээнд нийцсэн гэж үзэх тохиолдол ба гуравдагч этгээдийн (оюуны өмчийн эрхтэй холбогдсон) гомдол/нэхэмжлэл (Section II - Conformity of the goods and third party claims - Раздел II. Соответствие товара и права третьих лиц) (35-44 дүгээр зүйл)

**III дэд бүлэг.** Худалдагч гэрээ зөрчсөн тохиолдолд хэрэглэх эрх зүйн хамгаалалт (Section III - Remedies for breach of contract by the seller - Раздел III. Средства правовой защиты в случае нарушения договора продавцом) (45-52 дугаар зүйл)

### **III БҮЛЭГ. ХУДАЛДАН АВАГЧИЙН ҮҮРЭГ**

(Chapter III - Obligations of the Buyer - Глава III. Обязательства покупателя) (53-65 дугаар зүйл)

#### **I дэд бүлэг.** Үнэ төлөх/төлбөр хийх

(Section I - Payment of the price - Раздел I. Уплата цены) (54-59 дүгээр зүйл)

**II дэд бүлэг.** Нийлүүлэлтийг/барааг хүлээн авах

(Section II - Taking delivery - Раздел II. Принятие поставки) (60 дугаар зүйл)

**III дэд бүлэг.** Худалдан авагч гэрээ зөрчсөн тохиолдолд хэрэглэх эрх зүйн хамгаалалт (Section III - Remedies for breach of contract by the buyer - Раздел III. Средства правовой защиты в случае нарушения договора покупателем) (61-65 дугаар зүйл)

#### **IV БҮЛЭГ. ЭРСДЭЛ ШИЛЖИХ**

(Chapter IV - Passing of Risk- Глава IV. Переход риска) (66-70 дугаар зүйл)

#### **V БҮЛЭГ. ХУДАЛДАГЧ БОЛОН ХУДАЛДАН АВАГЧИЙН ҮҮРГИЙН ТАЛААРХИ НИЙТЛЭГ ЗААЛТ**

(Chapter V - Provisions Common to the Obligations of the Seller and of the Buyer - Глава V. Положения, общие для обязательств продавца и покупателя) (71-88 дугаар зүйл)

**I дэд бүлэг.** Гэрээний заалт зөрчигдөх нь тодорхой болох тохиолдол ба барааг хэсэгчлэн нийлүүлэх гэрээ

(Section I - Anticipatory breach and instalment contracts - Раздел I. Предвидимое нарушение договора и договоры на поставку товаров отдельными партиями) (71-73 дугаар зүйл)

**II дэд бүлэг.** Хохирол (Section II - Damages - Раздел II. Убытки) (74-77 дугаар зүйл)

**III дэд бүлэг.** Хүү (Section III - Interest - Раздел III. Проценты) (78 дугаар зүйл)

**IV дэд бүлэг.** Хариуцлагаас чөлөөлөх (Section IV - Exemptions - Раздел IV. Освобождение от ответственности) (79, 80 дугаар зүйл)

**V дэд бүлэг.** Гэрээ цуцалсны үр дагавар (Section V - Effects of avoidance - Раздел V. Последствия расторжения договора) (81-84 дүгээр зүйл)

**VI дэд бүлэг.** Барааны бүрэн бүтэн байдлыг хадгалах (Section VI - Preservation of the goods - Раздел VI. Сохранение товара) (85-88 дугаар зүйл)

#### **IV ХЭСЭГ. ТӨГСГӨЛИЙН ЗААЛТУУД**

(PART IV - Final Provisions - Часть IV. Заключительные положения) (89-101 дүгээр зүйл)



### 31. Барааны хилийн хяналтын үйл ажиллагааг уялдуулах тухай олон улсын конвенц (Женевийн Конвенц)

1.а. Гэрээний нэр англиар:	International Convention on the Harmonization of Frontier Controls of Goods (Geneva Convention)
1.б. Гэрээний нэр оросоор:	Международная Конвенция о согласовании условий проведения контроля грузов на границах
2. Гэрээ байгуулагдсан огноо, улс, хот:	- 1982-10-21. Швейцарь Улсын Женев хот - (Geneva, Switzerland)
3. Гэрээ хүчин төгөлдөр болсон огноо:	1985-10-15
4. Хэлэлцэн тохирогч Талын тоо:	2016 оны байдлаар: 58
5. Монгол Улс гэрээнд гарын үсэг зурсан, баталсан, соёрхон баталсан, нэгдэн орсон өдөр:	2007-05-04 (УИХ)
6. Гэрээ баталсан баримт бичгийг хадгалагч хүлээн авсан огноо:	2007-11-02
7. Монгол Улсын хувьд гэрээ хүчин төгөлдөр болсон өдөр:	2008-02-02
8. Гэрээнд тайлбар (Reservation) хийсэн байдал:	
9. Гэрээнд нэмэлт өөрчлөлт оруулсан байдал:	
10. Монгол Улсын холбогдох хууль тогтоомжоос:	
-	“Ачааг хилээр нэвтрүүлэхэд хийх хяналт, шалгалтын нөхцөлийг уялдуулах тухай олон улсын конвенц”-д нэгдэн орсныг соёрхон батлах тухай 2007 оны 5 дугаар сарын 4-ний өдрийн хууль

#### Гэрээтэй холбогдсон бусад мэдээлэл:

Энэ конвенцийг анхлан “Ачааг хилээр нэвтрүүлэхэд хийх хяналт, шалгалтын нөхцөлийг уялдуулах тухай олон улсын конвенц” гэж орчуулсан байгаа.

Уг Конвенцоор хилийн хяналтын байгууллагууд бие биенийхээ ажлын чиг үүрэгт саад бололгүйгээр хилийн хяналтаа уялдуулан зохион байгуулах асуудлыг зохицуулсан. Дараах 8 хавсралттай:

Хавсралт 1: Гаалийн хяналт болон бусад хяналтыг уялдуулах

(Harmonization of Customs Controls and Other Controls)

Хавсралт 2: Эмнэлэг, эрүүл ахуйн хяналт (Medico-Sanitary Inspection)

Хавсралт 3: Мал эмнэлгийн хяналт (Veterinary Inspection)

Хавсралт 4: Ургамал, хорио цээрийн хяналт (Phytosanitary Inspection)

Хавсралт 5: Техникийн стандартад нийцсэн байдлын хяналт

(Control of Compliance with Technical Standards)

Хавсралт 6: Чанарын хяналт (Quality Control)

Хавсралт 7: Энэ Конвенцийн 22 дугаар зүйлд заасан Зохицуулах хорооны дотоод дүрэм

(Rules of Procedure of the Administrative Committee Referred to in Article 22 of this Convention)

Хавсралт 8: Олон улсын авто тээврийн хил нэвтрэх горимыг хөнгөвчлөх

(Facilitation of Border Crossing Procedures for International Road Transport)

8 дугаар хавсралтын зүүлт 1 (Appendix 1 to Annex 8 to the Convention)

ТЕХНИКИЙН ҮЗЛЭГИЙН ОЛОН УЛСЫН ГЭРЧИЛГЭЭ

(INTERNATIONAL TECHNICAL INSPECTION CERTIFICATE)

8 дугаар хавсралтын зүүлт 2 (Appendix 2 to Annex 8 to the Convention)

ТЭЭВРИЙН ХЭРЭГСЛИЙН ЖИН ТОДОРХОЙЛОХ ОЛОН УЛСЫН ГЭРЧИЛГЭЭ (INTERNATIONAL VEHICLE WEIGHT CERTIFICATE)



**32. Соёлын үнэт зүйлсийн (соёлын өвийн) хууль бус экспорт, импорт, түүнчлэн өмчлөх эрхийг шилжүүлэхийг хориглох, тэдгээрээс урьдчилан сэргийлэх арга хэмжээний тухай ЮНЕСКО-гийн Конвенц**

1.a. Гэрээний нэр англиар:	The UNESCO Convention on the Means of Prohibiting and Preventing the Illicit Import, Export and Transfer of Ownership of Cultural Property
1.б. Гэрээний нэр оросоор:	Конвенция о мерах, направленных на запрещение и предупреждение незаконного ввоза, вывоза и передачи права собственности на культурные ценности
2. Гэрээ байгуулагдсан огноо, улс, хот:	- 1970-11-14, Франц Улсын Парис хот (Paris, France)
3. Гэрээ хүчин төгөлдөр болсон огноо:	1972-04-24
4. Хэлэлцэн тохирогч Талын тоо:	
5. Монгол Улс гэрээнд гарын үсэг зурсан, баталсан, соёрхон баталсан, нэгдэн орсон өдөр:	1991-01-04
6. Гэрээ баталсан баримт бичгийг хадгалагч хүлээн авсан огноо:	1991-05-23
7. Монгол Улсын хувьд гэрээ хүчин төгөлдөр болсон өдөр:	1991-08-23
8. Гэрээнд тайлбар (Reservation) хийсэн байдал:	-
9. Гэрээнд нэмэлт өөрчлөлт оруулсан байдал:	
10. Монгол Улсын холбогдох хууль тогтоомжоос: - (Энэ конвенцийг Монгол Улс баталсан, соёрхон баталсан буюу нэгдэн орсон тухай үндсэн баримт бичгийг олоогүй)	

**Гэрээтэй холбогдсон бусад мэдээлэл:**

Энэ Конвенцийн 1 дүгээр зүйлд зааснаар, “соёлын үнэт зүйл/соёлын өв” гэдэг нь аливаа Улс шашны буюу шашны бус үндэслэлээр (on religious or secular grounds) археологи (archaeology), түүхийн өмнөх үе (prehistory), түүхэн үе (history), уран зохиол (literature), урлаг (art), шинжлэх ухаан (science)-ы ач холбогдолтой гэж онцгойлон авч үзэж, дор дурдсан аль нэг ангилал (categories)-д хамааруулсан өмч (үнэт зүйл/өв хөрөнгө)-ийг илэрхийлнэ:

- (a) ургамал, амьтан, эрдэс, анатомын ховор дээжис, цуглуулга болон палеонтологийн ач холбогдолтой үнэт зүйлс (rare collections and specimens of fauna, flora, minerals and anatomy, and objects of palaeontological interest);
- (b) түүхийн үнэт зүйлс, тухайлбал, шинжлэх ухаан болон техникийн түүх, дайн болон нийгмийн түүх, түүнчлэн үндэсний нэрт зүтгэлтэн, сэтгэгчид, эрдэмтэд, жүжигчид болон үндэсний томоохон үйл явдалд холбоотой үнэт зүйлс (property relating to history, including the history of science and technology and military and social history, to the life of national leaders, thinkers, scientists and artist and to events of national importance);
- (c) археологийн (ердийн болон нуугдмал) олдворууд буюу археологийн нээлтүүд (products of archaeological excavations (including regular and clandestine) or of archaeological discoveries);
- (d) урлагийн болон түүхийн хөшөө дурсгал, археологийн ач холбогдол бүхий газрын бүрэлдэхүүн хэсгүүд (elements of artistic or historical monuments or archaeological sites which have been dismembered);
- (e) 100 жилээс өмнөх үеийн бичээс, цутгамал, зоос, тамга тэмдэг зэрэг хуучны эд юмс (antiquities more than one hundred years old, such as inscriptions, coins and engraved seals);
- (f) угсаатны зүйн материалууд (objects of ethnological interest);

(g) урлагийн дараах үнэт зүйлс (property of artistic interest, such as):

- (i) аливаа эд зүйл дээр юугаар үйлдсэнийг үл харгалзан бүхэлд нь гараар үйлдсэн бүх төрлийн зураг, уран зураг, зураасан зураг (барааны тэмдэг болон гараар үйлдсэн үйлдвэрийн бүтээгдэхүүнийг оруулахгүй) (pictures, paintings and drawings produced entirely by hand on any support and in any material (excluding industrial designs and manufactured articles decorated by hand));
  - (ii) аливаа эдээр хийсэн баримал, уран баримлын эх бүтээлүүд (original works of statuary art and sculpture in any material);
  - (iii) сийлбэр, бар, цутгамлын эх бүтээлүүд (original engravings, prints and lithographs);
  - (iv) аливаа эдээр хийсэн уран сайхны сонгомж, эвлүүлэг (original artistic assemblages and montages in any material);
- (h) ховор гар бичмэлүүд, хэвлэмэл зүйлс, эртний ном судар, баримт бичиг болон (түүх, уран сайхан, шинжлэх ухаан, уран зохиол зэрэг) онцгой сонирхол татаж байгаа дангаараа буюу цуглуулгаараа байгаа хэвлэмэл бүтээл (rare manuscripts and incunabula, old books, documents and publications of special interest (historical, artistic, scientific, literary, etc.) singly or in collections);
- (i) дангаараа буюу цуглуулгаараа байгаа шуудангийн марк, татварын буюу түүнтэй адилтгах марк (postage, revenue and similar stamps, singly or in collections);
  - (j) дууны бичлэг, гэрэл зураг болон киноны архивуудыг оролцуулан бусад төрлийн архив (archives, including sound, photographic and cinematographic archives);
  - (k) 100 жилээс өмнөх үеийн эртний модон тавилга болон хөгжмийн эртний зэмсгүүд (articles of furniture more than one hundred years old and old musical instruments).

Энэхүү Конвенцийн 4 дүгээр зүйлд зааснаар, дор дурдсан зүйлс нь Улс бүрийн соёлын үнэт зүйлсэд хамаарна:

- (a) тухайн улсын харьяат этгээдийн дангаараа буюу бусад этгээдтэй хамтран бүтээсэн соёлын үнэт зүйлс, мөн тухайн улсын нутаг дэвсгэрт оршин суугаа гадаадын иргэд буюу харьяалалгүй хүмүүсийн хийж бүтээсэн тухайн улсад чухал ач холбогдолтой соёлын үнэт зүйлс;
- (b) үндэсний нутаг дэвсгэрт олдсон соёлын үнэт зүйлс;
- (c) соёлын үнэт зүйлсийн гарлын улсын эрх бүхий байгууллагын зөвшөөрөлтэйгээр археологи, угсаатны зүй, байгалийн шинжлэх ухааны экспедицүүдийн олсон соёлын үнэт зүйлс;
- (d) сайн дурын солилцоогоор олж авсан соёлын үнэт зүйлс;
- (e) соёлын үнэт зүйлсийн гарлын улсын эрх бүхий байгууллагын зөвшөөрөлтэйгээр бэлгэнд, эсхүл хууль ёсоор худалдан авсан соёлын үнэт зүйлс.

Энэ Конвенцийн дагуу түүний Хэлэлцэн тохирогч Тал болсон Улсуудаас батласан журмыг зөрчин соёлын үнэт зүйлсийг импортлох, экспортлох, өмчлөх эрхийг шилжүүлэхийг хууль бус гэж үзнэ (3 дугаар зүйл).

Энэхүү Конвенцийн 6 дугаар зүйлд зааснаар, түүний Хэлэлцэн тохирогч Тал болсон Улсууд дараах үүрэг хүлээнэ:

- (a) экспортлогч улс соёлын нэг буюу хэд хэдэн үнэт зүйлийг экспортлох зөвшөөрөл олгосноо батлах гэрчилгээ бий болгох. Уг гэрчилгээг журмын дагуу экспортлогдож буй нэг буюу соёлын хэд хэдэн үнэт зүйлд хавсаргана;
- (b) дээр дурдсан экспортын гэрчилгээг хавсаргаагүй соёлын үнэт зүйлсийг өөрийнхөө нутгаас экспортлохыг хориглох;
- (c) олон нийтэд, ялангуяа соёлын үнэт зүйлсийг экспортлох, импортлох боломжтой хүмүүст энэхүү хоригийг зохих хэлбэрээр танилцуулсан байх.

Конвенцийн 11 дүгээр зүйлд зааснаар, аливаа улсыг гадаад улс эзлэн түрэмгийлсний шууд буюу шууд бус уршгаар соёлын үнэт зүйлсийг хууль бусаар экспортолж, түүнийг өмчлөх эрхийг хүчээр шилжүүлсэн бол тэдгээр үйлдлийг мөн хууль бус гэж үзнэ.



Энэ Конвенцийн Хэлэлцэн тохирогч Талууд хууль тогтоомжийнхоо дагуу дараах арга хэмжээ авна (13 дугаар зүйл):

- (a) соёлын үнэт зүйлсийг хууль бусаар импортлох буюу экспортлоход хүргэх уг үнэт зүйлсийн өмчлөлийн эрхийг шилжүүлэх явдлаас зохих бүхий л аргаар урьдчилан сэргийлэх;
- (b) хууль бусаар экспортлосон соёлын үнэт зүйлсийг аль болох богино хугацаанд хууль ёсных нь өмчлөгчдөд буцааж өгөхийн тулд өөрсдийн эрх бүхий байгууллагуудын хамтын ажиллагааг хангах;
- (c) алдагдсан буюу хулгайлагдсан соёлын үнэт зүйлсийг эгүүлэн өгүүлэх талаар хууль ёсны өмчлөгч болон түүний нэрийн өмнөөс зарга мэдүүлэх эрхийг зөвшөөрөх;
- (d) энэхүү Конвенцид оролцогч улс бүр соёлын үнэт зүйлсийнхээ заримыг бусдад шилжүүлэхгүй гэж ангилан зарлаж, *ipso facto* (ийнхүү) экспортлохгүй байх салшгүй эрхийг хүлээн зөвшөөрөх бөгөөд хэрэв соёлын тийм үнэт зүйлс өмнө нь экспортлогдсон бол тэдгээрийг холбогдох улсуудад буцааж өгөхөд туслалцаа үзүүлэх.

Оюуны үнэт зүйл, соёлын өвийг хамгаалах талаар гарсан өөр бусад Конвенц, протоколоос дурдвал:

- 1. “Зэвсэгт мөргөлдөөний үед оюуны өмчийг хамгаалах тухай” 1954 оны Конвенц, түүнийг хэрэгжүүлэх регламент (Конвенция 1954 г. «О защите культурных ценностей а случае вооруженного конфликта» и Исполнительный регламент);
- 2. “Зэвсэгт мөргөлдөөний үед оюуны өмчийг хамгаалах тухай” Конвенцийн 1 дүгээр Протокол (1954 онд байгуулсан) (Первый протокол 1954 г. к Конвенции «О защите культурных ценностей а случае вооруженного конфликта»);
- 3. “Зэвсэгт мөргөлдөөний үед оюуны өмчийг хамгаалах тухай” Конвенцийн 2 дугаар Протокол (1999 онд байгуулсан) (Второй протокол 1999 г. к Конвенции «О защите культурных ценностей а случае вооруженного конфликта»);

- 4. “Дэлхийн байгалийн болон соёлын өвийг хамгаалах тухай” 1972 оны Конвенц (Конвенция 1972 г. «Об охране всемирного культурного и природного наследия»);
- 5. “Европын уран барилгын өвийг хамгаалах тухай” 1985 оны Европын Конвенц (Европейская Конвенция 1985 г. «Об охране архитектурного наследия Европы»);
- 6. “Археологийн өвийг хамгаалах тухай” 1992 оны Европын Конвенц (шинэчлэн найруулсан) (Европейская Конвенция (пересмотренная) 1992 г. «Об охране археологического наследия»);
- 7. “Хулгайлсан болон хууль бусаар гаргасан соёлын үнэт зүйлийн тухай” 1995 оны УНИДРУА-гийн Конвенц (Конвенция УНИДРУА 1995 г. «О похищенных и незаконно вывезенных культурных ценностях»);
- 8. “Далай, тэнгисийн усанд байгаа соёлын өвийг хамгаалах тухай” 2001 оны Конвенц (Конвенция 2001 г. «Об охране подводного культурного наследия»);
- 9. “Материаллаг бус соёлын өвийг хамгаалах тухай” 2003 оны Конвенц (Конвенция 2003 г. «Об охране нематериального культурного наследия»);
- 10. “Соёлын илэрхийллийн хэлбэрийг хамгаалах, хөхүүлэн дэмжих тухай” 2005 оны Конвенц (Конвенция 2005 г. «Об охране и поощрении форм культурного самовыражения»).



### 33. Хуурай боомтын тухай Засгийн газар хоорондын хэлэлцээр (АНДЭЗНК-ын хэлэлцээр)

1.а. Гэрээний нэр англиар:	Intergovernmental Agreement on Dry Ports
1.б. Гэрээний нэр оросоор:	Межправительственное соглашение о сухих портах
2. Гэрээ байгуулагдсан огноо, улс, хот:	- 2013-05-01. Таиландын Вант Улсын Бангкок хот - (Bangkok, Thailand)
3. Гэрээ хүчин төгөлдөр болсон огноо:	2016-04-23
4. Хэлэлцэн тохирогч Талын тоо:	2016 оны байдлаар: 12 (Хавсралт 1-д 2018 оны байдлаар 27 улсын хуурай боомтын жагсаалт байгаа)
5. Монгол Улс гэрээнд гарын үсэг зурсан, баталсан, соёрхон баталсан, нэгдэн орсон өдөр:	2013-11-07-ны өдөр гарын үсэг зурсан 2016-02-05-ны өдөр соёрхон баталсан
6. Гэрээ баталсан баримт бичгийг хадгалагч хүлээн авсан огноо:	2016-06-30
7. Монгол Улсын хувьд гэрээ хүчин төгөлдөр болсон өдөр:	2016-07-30
8. Гэрээнд тайлбар (Reservation) хийсэн байдал:	Тайлбаргүй
9. Гэрээнд нэмэлт өөрчлөлт оруулсан байдал:	
10. Монгол Улсын холбогдох хууль тогтоомжоос:	- Хуурай боомтын тухай засгийн газар хоорондын хэлэлцээрийг соёрхон батлах тухай 2016 оны 2 дугаар сарын 5-ны өдрийн хууль

#### Гэрээтэй холбогдсон бусад мэдээлэл:

Энэ хэлэлцээрийг НҮБ-ын Ази, Номхон далайн Эдийн засаг, нийгмийн комисс (ESCAP)-ын ивээл дор байгуулж, уг Комиссын 2013 оны 5 дугаар сарын 1-ний өдрийн 69/7 тоот тогтоолоор Таиландын Вант Улсын нийслэл Бангкок хотноо баталсан байна.

Энэ хэлэлцээр нь Ази, Номхон далайн бүсийн орнуудын уг хэлэлцээрийн 1 дүгээр хавсралтад дурдсан хуурай замын (автотээврийн) боомтыг олон улсын хэмжээнд хүлээн зөвшөөрөх, тэдгээрийн дэд бүтцийг хөгжүүлэх, үйл ажиллагааг шуурхай болгох, хүчин чадлыг дээшлүүлэх, мөн хөрөнгө оруулалтыг хөнгөвчлөх зорилготой.

Энэ хэлэлцээрийн 1 дүгээр хавсралтад орсон зарим улсын автотээврийн боомтыг дурдвал:

#### Монгол Улс:

- Алтанбулаг
- Сайншанд
- Улаанбаатар
- Замын-Үүд
- [Чойбалсан]

#### Хятад Улс:

- Чанчунь Синглунг дэх олон улсын логистикийн боомт, Чанчунь
- Эрээн хотын өмнөд олон улсын логистикийн төв, Эрээн хот
- Харбин дахь хурдны тээвэр зуучийн төв, Харбин Лонгюн логистикийн парк, Харбин хот
- Хэкоу боомтын тээврийн логистикийн парк, Хэкоу
- Хоргос олон улсын логистикийн парк, Хоргос

- Хүнчунь олон улсын логистикийн парк, Хүнчунь
- Жингхун Мэнган олон улсын логистикийн худалдааны төв, Жингхун
- Каши олон улсын логистикийн парк, Каши
- Тэнгжун олон улсын хуурай боомт, Куньмин
- Манжуурын шинэ олон улсын тээвэр зуучийн газар, Манжуур
- Наньнин дахь логистикийн төв, Наньнин
- Пингсиан хилийн худалдааны логистикийн төв (Иоу и гуан)
- Руили ачаа тээврийн төв, Руили
- Суйфэнхэ ачаа тээврийн төв, Суйфэнхэ
- Шинжааны төмөр замын олон улсын логистикийн парк, Үрэмч
- И ву гүний боомт, И ву
- Жангму боомтын агуулах логистик худалдааны төв, Жангму

**ОХУ:**

- Янино логистикийн парк, Санкт-Петербург
- “Ростов боомт” холимог тээврийн логистикийн цогцолбор, Ростов-на-Дону
- “Балтын” зогсоол, логистикийн төв, Ленинград
- “Клешчеха” зогсоол, логистикийн төв, Новосибирск
- “Доскино” зогсоол, логистикийн төв, Доод Новгород,
- [Дмитровскийн холимог тээврийн төв, Москва]
- [Калининград]
- [Казань]
- [“Өмнөд Приморскийн зогсоол” холимог тээврийн логистикийн цогцолбор, Приморский]
- [Свияжскийн холимог тээврийн логистикийн төв, Татарстан]
- [“Приморскийн” зогсоол, логистикийн төв, Уссурийск, Приморский]
- [“Таманскийн” зогсоол, логистикийн төв, Краснодар]
- [“Белый Раст” зогсоол, логистикийн төв, Москва]
- [Волгоград]
- [Екатеринбург]

Энэ хэлэлцээрийн 2 дугаар хавсралтад хуурай боомтыг байгуулж, ажиллуулахад мөрдөх үндсэн зарчим (чиг үүрэг, зохион байгуулалт, захиргаа, зохицуулалтын орчин, зураг төсөл, төлөвлөлт, хүчин чадал, дэд бүтэц, байгууламж, тоног төхөөрөмж)-ыг заасан байгаа.



### 34. Ази, Номхон далайн (бүс нутгийн орнуудын) хил дамнасан цаасгүй худалдааг хөнгөвчлөх тухай ерөнхий хэлэлцээр (АНДЭЗНК-ын хэлэлцээр)

1.а. Гэрээний нэр англиар:	Framework Agreement on Facilitation of Cross-Border Paperless Trade in Asia and the Pacific
1.б. Гэрээний нэр оросоор:	Рамочное соглашение об упрощении процедур трансграничной безбумажной торговли в Азиатско-Тихоокеанском регионе
2. Гэрээ байгуулагдсан огноо, улс, хот:	- 2016-05-19. Тайландын Вант Улсын Бангкок хот (Bangkok, Thailand)
3. Гэрээ хүчин төгөлдөр болсон огноо:	Хүчин төгөлдөр болоогүй
4. Хэлэлцэн тохирогч Талын тоо:	
5. Монгол Улс гэрээнд гарын үсэг зурсан, баталсан, соёрхон баталсан, нэгдэн орсон өдөр:	
6. Гэрээ баталсан баримт бичгийг хадгалагч хүлээн авсан огноо:	
7. Монгол Улсын хувьд гэрээ хүчин төгөлдөр болсон өдөр:	
8. Гэрээнд тайлбар (Reservation) хийсэн байдал:	
9. Гэрээнд нэмэлт өөрчлөлт оруулсан байдал:	
10. Монгол Улсын холбогдох хууль тогтоомжоос:	

#### Гэрээтэй холбогдсон бусад мэдээлэл:

Энэ хэлэлцээрийг НҮБ-ын Ази, Номхон далайн эдийн засаг, нийгмийн комисс (ESCAP)-ын ивээл дор байгуулж, уг Комиссын 2016 оны 5 дугаар сарын 19-ний өдрийн 72/4 тоот тогтоолоор Таиландын Вант Улсын нийслэл Бангкок хотноо баталсан байна.

Энэ хэлэлцээр нь худалдааг хөнгөвчлөх дижитал арга хэмжээ (digital trade facilitation measures) авч хэрэгжүүлэх үйл явцыг хурдасгах замаар ДХБ-ын Худалдааг хөнгөвчлөх хэлэлцээрийн хэрэгжилтэд тус дөхөм үзүүлэх, хил дамнасан цахим худалдааг хөнгөвчлөх зорилготой болно. Энэ хэлэлцээрийн 1 дүгээр зүйлд зааснаар, уг хэлэлцээрийн зорилт нь дүрэм журам дагаж мөрдөх явдлыг дээшлүүлэхийн зэрэгцээ олон улсын худалдааны хэлцлүүдийг илүү эрчимтэй, илүү ил тод болгох зорилгоор худалдааны холбогдолтой мэдээлэл, бичиг баримтыг цахим хэлбэрээр солилцож, харилцан хүлээн зөвшөөрөх нөхцөлийг бүрдүүлэх, мөн үндэсний болон дэд бүсийн нэг цонхны системүүд болон/эсхүл цаасгүй худалдааны бусад системүүд хоорондоо харилцан үйлчлэх явдлыг хөнгөвчлөх замаар хил дамнасан цаасгүй худалдааг хөхүүлэн дэмжих явдал юм.

Энэ Хэлэлцээрийн 3 дугаар зүйлд дараах тодорхойлолтууд өгөгдсөн байна:

- (a) “Хил дамнасан цаасгүй худалдаа” (cross-border paperless trade) гэж худалдааны холбогдолтой мэдээлэл, бичиг баримтыг цахим хэлбэрээр солилцох зэрэг цахим захидал харилцаанд суурилж бараа худалдаалах, түүний дотор бараа оруулах, гаргах, дамжуулан өнгөрүүлэх, мөн тэдгээртэй холбоотой үйлчилгээ үзүүлэх явдлыг хэлнэ;
- (b) “цахим захидал харилцаа” (electronic communication) гэж худалдаанд оролцогч талууд дата мессаж дамжуулах арга замаар үйлдсэн аливаа захидал харилцааг хэлнэ;
- (c) “дата мессеж” (data message) гэж цахим (электрон), соронзон, оптик, эсхүл тэдгээртэй адилтгах өөр бусад аргаар боловсруулсан, илгээсэн, хүлээн авсан, эсхүл хадгалсан мэдээллийг хэлнэ. Үүнд мэдээллийг цахимаар харилцан солилцох (electronic data interchange) явдал хамаарна, гэхдээ түүгээр хязгаарлагдахгүй;
- (d) “худалдааны холбогдолтой мэдээлэл” (trade-related data) гэж худалдааны холбогдолтой ямар нэг бичиг баримтад

тусгагдсан, эсхүл түүгээр хүргүүлсэн мэдээллийг хэлнэ;

- (e) “худалдааны холбогдолтой бичиг баримт” (trade-related documents) гэж арилжааны хэлцэл гүйцэтгэхэд шаардлагатай, арилжааны болон дүрэм журмын аль алиных нь холбогдолтой бичиг баримтыг хэлнэ;
- (f) “арилжааны хэлцэл” (commercial transactions) гэж өөр өөр нутаг дэвсгэрт үйл ажиллагаа явуулдаг талуудын хооронд бараа худалдахтай холбогдсон хэлцлийг хэлнэ;
- (g) “харилцан хүлээн зөвшөөрөх” (mutual recognition) гэж хоёр буюу түүнээс дээш улсын хооронд хил дамнуулан солилцсон, худалдааны холбогдолтой цахим хэлбэрийн мэдээлэл, бичиг баримт хүчин төгөлдөр болохыг харилцан хүлээн зөвшөөрөхийг хэлнэ;
- (h) “нэг цонхны систем” (single window) гэж худалдааны хэлцэлд оролцогч талууд бараа оруулах, гаргах болон дамжуулан өнгөрүүлэхтэй холбогдсон дүрэм журмын бүх шаардлагыг хангах үүднээс мэдээлэл, бичиг баримтыг нэвтрэх нэг сувгаар (нэг цэгээр) дамжуулан гаргаж өгөх боломж олгосон механизмыг хэлнэ;
- (i) “харилцан үйлчлэх” (interoperability) гэж хоёр буюу түүнээс дээш (цахим) систем буюу бүрдэл хэсэг нь хоорондоо мэдээлэл солилцох, мөн солилцсон мэдээллийг ашиглах боломжтой (чадвартай) байхыг хэлнэ.

Энэ хэлэлцээрийн 5 дугаар зүйлд энэ хэлэлцээрийг хэрэгжүүлэхэд мөрдлөг болгон ажиллавал зохих дараах ерөнхий зарчмуудыг заасан:

- (a) Цахим бичиг баримтыг цаасан бичиг баримтай адилтган үзэх зарчим (functional equivalence);
- (b) Цахим захидал харилцаа ашигласан явдлыг (цахимаар харилцсан бичиг захидлыг) үл ялгаварлах зарчим (non-discrimination of the use of electronic communications);
- (c) Технологиос үл хамаарах (тодорхой нэг төрлийн технологи ашиглахыг шахаж

шаардахгүй, эсхүл ялгаварлан гадуурхахгүй байх) зарчим (technological neutrality);

- (d) Худалдааны цахим системүүд (түүний дотор нэг цонхны системүүд) хоорондоо харилцан үйлчлэх боломжтой байх явдлыг хөхүүлэн дэмжих зарчим (promotion of interoperability);
- (e) Худалдааг хөнгөвчлөх болон дүрэм журам мөрдөн сахих явдлыг боловсронгуй болгох зарчим (improved trade facilitation and regulatory compliance);
- (f) Төр болон хувийн хэвшил хоорондоо хамтран ажиллах зарчим (cooperation between the public and private sectors);
- (g) Хил дамнасан итгэл үнэмшлийн орчинг (нэг нь нөгөөдөө итгэх явдлыг) боловсронгуй болгох зарчим (improving transboundary trust environment).

Энэ хэлэлцээрийн 11 дүгээр зүйлийн дагуу НҮБ-ын Ази, Номхон далайн эдийн засаг, нийгмийн комисс нь энэ хэлэлцээрийн ажлын албаны үүргийг гүйцэтгэхийн зэрэгцээ, Цаасгүй худалдааны зөвлөл байгуулна. Уг зөвлөлд Хэлэлцэн тохирогч тал бүрээс өндөр түвшний нэг этгээд төлөөлөн сууна. Зөвлөл нь жилд нэгээс доошгүй удаа хуралдана. Зөвлөл нь Байнгын хороотой байна. Байнгын хороо нь ахлах мэргэжилтнүүдээс бүрдэнэ. Байнгын хороо нь ажлын хэсгүүд байгуулж болно.

Байнгын хороо нь Цаасгүй худалдааны зөвлөлийн хяналтын дор үйл ажиллагааны төлөвлөгөө боловсруулж ажиллана. Талууд худалдааны холбогдолтой мэдээлэл, бичиг баримтыг цахим хэлбэрээр солилцох төслүүдийг санаачлан, энэ хэлэлцээрийн дагуу байгуулагдсан байгууллагуудаар дамжуулан хэрэгжүүлэхийг эрмэлзэнэ. Талууд мөн эдгээр байгууллагаар дамжуулан чадавхийг бэхжүүлэх чиглэлээр техникийн дэмжлэг, туслалацаа үзүүлж болно. Ингэхдээ буурай хөгжилтэй болон далайд гарцгүй хөгжиж буй орнуудыг хүсэлтийг илүүтэй авч үзнэ.

Уг хэлэлцээрт АНДЭЗНК-ын гишүүн 5 улс (Армен, Бангладеш, Камбоди, Хятад, Исламын БН Иран улс) 2017 онд гарын үсэг зурсан бөгөөд Азербайжан 2018 онд Филиппин 2019 онд соёрхон батлаад байна. Уг хэлэлцээр АНДЭЗНК-ын гишүүн 5 улс баталсны дараа 90 хоног болоод хүчин төгөлдөр болно.





Дэлхийн оюуны өмчийн байгууллага

**The World Intellectual Property Organization**

**Всемирная организация интеллектуальной собственности (ВОИС)**

(Швейцарь Улсын Женев хот, 1893, НҮБ-ын төрөлжсөн байгууллага)

## **V БҮЛЭГ**

# ДЭЛХИЙН ОЮУНЫ ӨМЧИЙН БАЙГУУЛЛАГЫН БАРИМТ БИЧГҮҮД

- Оюуны өмчийн эрхийг хамгаалах асуудлыг зохицуулсан бөгөөд Монгол Улсын нэгдэн орсон 14 Конвенц байдаг.
- Оюуны өмчийн эрхийн худалдаатай холбогдсон асуудлын тухай ДХБ-ын Хэлэлцээр (TRIPS)-ийг энэ бүлэгт оруулав.

1.а. Гэрээний нэр англиар:	Paris Convention on Industrial Property (Paris Convention)
1.б. Гэрээний нэр оросоор:	Парижская Конвенция по охране промышленной собственности
2. Гэрээ байгуулагдсан огноо, улс, хот:	- 1883-3-20. Франц Улсын Парис хот - (Paris, France)
3. Гэрээ хүчин төгөлдөр болсон огноо:	1884-07-07
4. Хэлэлцэн тохирогч Талын тоо:	2018 оны байдлаар: 177
5. Монгол Улс гэрээнд гарын үсэг зурсан, баталсан, соёрхон баталсан, нэгдэн орсон өдөр:	1984-11-13
6. Гэрээ баталсан баримт бичгийг хадгалагч хүлээн авсан огноо:	1985-01-16
7. Монгол Улсын хувьд гэрээ хүчин төгөлдөр болсон өдөр:	1985-04-21
8. Гэрээнд тайлбар (Reservation) хийсэн байдал:	Конвенцийн 24 дүгээр зүйлийн заалтууд "Колончлогдсон улс орон, ард түмэнд тусгаар тогтнол олгох тухай тунхаглал" (НҮБ-ын Ерөнхий Ассамблейн тогтоол 1514/XV)-тай зөрчилдөж байгааг мэдэгдсэн байдаг.
9. Гэрээнд нэмэлт өөрчлөлт оруулсан байдал:	- Брюссель (Brussels, Belgium) хотноо 1900-12-14-нд, Вашингтон (Washington, United States) хотноо 1911-06-02-нд, Гаага (The Hague, The Netherlands) хотноо 1925-11-06-нд, Лондон (London, United Kingdom) хотноо 1934-06-02-нд, Лиссабон (Lisbon, Portugal) хотноо 1958-10-31-нд, Стокгольм (Stockholm, Sweden) хотноо 1967-07-14-нд тус тус шинэчлэгдсэн. Стокгольмын шинэчлэгдсэн хувилбар 1970- 04-26 (эсхүл 1970-05-19)-ний өдөр хүчин төгөлдөр болсон. Түүнд 1979-09-28-нд нэмэлт өөрчлөлт оруулсан.
10. Монгол Улсын холбогдох хууль тогтоомжоос:	- (Энэ конвенцийг Монгол Улс баталсан, соёрхон баталсан буюу нэгдэн орсон тухай үндсэн баримт бичгийг олоогүй)

### Гэрээтэй холбогдсон бусад мэдээлэл:

Энэ Конвенц нь оюуны өмчийн асуудлаар байгуулагдсан олон улсын анхны гэрээнүүдийн нэг. Энэ Конвенц байгуулагдсанаар Хэлэлцэн тохирогч нэг Талын иргэд Хэлэлцэн тохирогч нөгөө Талын нутаг дэвсгэрт оюуны өмчийн эрхээ эдлэх, хамгаалуулах боломжтой болсон.

Энэ Конвенц аж үйлдвэрийн өмчийг өргөн утгаар нь авч үзсэн бөгөөд түүнд дараах зүйлс хамаарна (Конвенцийн 1.2):

- **патент (patents):** шинэ бүтээл, бүтээгдэхүүний загварыг зохиогч нь тодорхой хугацаанд өмчлөх онцгой эрхтэй болохыг хүлээн зөвшөөрч төрийн эрх бүхий байгууллагаас олгосон баримт бичиг;
- **барааны тэмдэг (trademarks);**

- **бүтээгдэхүүний загвар (industrial designs);**
- **ашигтай загвар (utility models):** зарим орны хуулинд заасан "жигжгэн патент" (a kind of "small patent" provided for by the laws of some countries);
- **үйлчилгээний тэмдэг (service marks);**
- **худалдааны нэр/нэршил/аж ахуйн нэгжийн нэр (trade names):** аливаа үйлдвэрлэл, худалдааны үйл ажиллагаа эрхлэн явуулахад хэрэглэдэг нэр (designations under which an industrial or commercial activity is carried on);
- **газар зүйн заалт (geographical indications):** тухайн барааны чанар, нэр хүнд, онцлог бусад шинж чанар нь түүний газар зүйн гарал үүсэлтэй салшгүй холбоотойг



илэрхийлсэн, тус барааг үйлдвэрлэсэн улс, бүс, газар нутгийн газар зүйн нэр буюу эх сурвалж/эх үүсвэр болон гарал үүслийн газрын нэр, нэрийн заалт (indications of source and appellations of origin);

- шударга бус өрсөлдөөнийг таслан зогсоох (the repression of unfair competition).

Энэ Конвенцоор Парисын Холбоо (The Paris Union буюу Аж үйлдвэрийн өмчийг хамгаалах Холбоо - a Union for the protection of industrial property) (цаашид "Холбоо" гэх) үүсгэн байгуулагдсан. Энэ Конвенцийг мөрдөж буй бүх улс орон Холбооны Гишүүн болно (Конвенцийн 1.1). Холбоо нь Ассамблей болон Гүйцэтгэх хороотой байна. 1967 оны Стокгольмын баримт бичгийн ядаж захиргааны асуудал хөндсөн заалтууд болон төгсгөлийн заалтуудыг мөрддөг Холбооны Гишүүн улс орон бүр Ассамблейн Гишүүн байна. Гүйцэтгэх хорооны Гишүүдийг Холбооны Гишүүдээс сонгоно. Швейцарь Улс *ex officio* (өөрийн статус буюу бүрэн эрхийнхээ хүрээнд) Гүйцэтгэхийн хорооны байнгын Гишүүн байна.

Энэ Конвенцийн материаллаг заалтууд дараах гурван хэсэгт хуваагдана:

- (1) үндэсний зарчим мөрдөх (national treatment): Конвенцийн 2 дугаар зүйлд зааснаар, Холбооны Гишүүн нэг орон Холбооны Гишүүн нөгөө орны иргэдийн хувьд үндэсний зарчим мөрдөнө. Өөрөөр хэлбэл, аж үйлдвэрийн өмчийн эрхийг хамгаалах тал дээр, тэднийг өөрийн улсын иргэний адил авч үзнэ. Харин Холбооны Гишүүн бус орны иргэний хувьд үндэсний зарчим мөрдөхийн тулд тухайн иргэн Холбооны аль нэг улсын нутаг дэвсгэрт байнга оршин суудаг (to be domiciled), эсхүл тэнд байнгын үйлдвэрлэл, эсхүл худалдаа эрхэлдэг бодит компани (салбар компани) байгуулсан байх ёстой (to have real and effective industrial or commercial establishments in the territory of one of the countries of the Union) (3 дугаар зүйл);
- (2) давуу эрх буюу давамгайлах эрхтэй байх (a right of priority): Үүнийг "Конвенциор олгогдсон давуу эрх буюу давамгайлах эрх" ("Convention priority right"), эсхүл "Парисын Конвенцоор олгогдсон давуу эрх" ("Paris Convention priority right"), эсхүл "Холбооны давуу эрх" ("Union priority right") гэдэг. Энэ эрхийнхээ дагуу, Хэлэлцэн тохирогч аль нэг Талд анх мэдүүлэг өгсөн/өргөдөл гаргасан этгээд (applicant) түүнээс хойш 6 сарын дотор (бүтээгдэхүүнийн загвар болон барааны тэмдгийн хувьд - for in-

dustrial designs and trademarks), эсхүл 12 сарын дотор (патент болон ашигтай загварын хувьд - for patents and utility models) Хэлэлцэн тохирогч нөгөө Талуудад дахин мэдүүлэг өгөх/өргөдөл гаргахдаа, тийнхүү анх мэдүүлэг өгсөн/өргөдөл гаргасан хугацаагаа ашиглах боломжтой (4 дүгээр зүйл). Энэ эрхийн практик ач холбогдол бүхий хамгийн давуу тал нь тухайн мэдүүлэг өгсөн/өргөдөл гаргасан этгээд Хэлэлцэн тохирогч бүх улсуудад нэгэн зэрэг материалаа явуулалгүйгээр, эхний удаа Хэлэлцэн тохирогч (Холбооны Гишүүн) аль нэг Улсад бүртгүүлж, хугацаа хожиход оршино. Үүнээс хойш тухайн этгээд дээр заасан хугацаанд бусад улс орнуудад дахин бүртгүүлбэл, тэр нь дээрх хугацаанд бүртгүүлсэн ижил төрлийн аж үйлдвэрийн өмчийн бүртгэлүүдээс хугацааны хувьд түрүүлж бүртгүүлсэнд тооцогдоно.

- (3) нийтлэг дүрэм (common rules): Конвенцид Хэлэлцэн тохирогч бүх Талууд нэгэн адил дагаж мөрдөх нэлээд хэдэн дүрэм тусгагдсан. Тухайлбал:

(a) Патентын хувьд (Конвенцийн 5.A.):

- Нэг төрлийн шинэ бүтээлд Хэлэлцэн тохирогч хэд хэдэн улсад олгосон патентыг тус тусад нь авч үзнэ (they are independent). Нэг улсад патент олгосон байх нь тийм патентыг нөгөө улс заавал олгох үндэслэл болохгүй. Нэг улсад патент олгохоос татгалзсан, патентыг хүчингүй болгосон, эсхүл патентын хугацаа дууссан бол нөгөө улс түүнийг үндэслэн патент олгохоос татгалзаж, патентыг хүчингүй болгож, эсхүл патентын хугацааг дууссанд тооцож болохгүй.
- Патенттай бараа (the patented product), эсхүл патент бүхий технологиор үйлдвэрлэсэн бараа (a product obtained by means of the patented process)-ны худалдааг дотоодын хууль тогтоомжоор хязгаарласан гэсэн үндэслэлээр патент олгохоос татгалзаж, эсхүл патентыг хүчингүй болгож болохгүй.
- Шинэ бүтээлийн эзэн шинийг бүтээгч (the inventor) гэсэн нэр алдраа патентад тусгах эрхтэй.
- Патентаар олгогдсон онцгой эрх (the exclusive rights)-ийг буруугаар ашиглаж болзошгүй байдлаас сэргийлэх үүднээс албадан лиценз (compulsory licenses) олгох талаар хуулиндаа заах Хэлэлцэн тохирогч Тал түүнийг зөвхөн тодорхой хязгаарлалттай хийнэ (Конвенцийн 5.A.2). Тухайлбал, патент эзэмшигч шинэ бүтээлээ ашиглахгүй,

эсхүл дутуу дульмаг ашигласан байдлаар 3-4 жил болсон бол албадан лиценз олгож болно (өөр хэлбэл, уг лицензийг патент эзэмшигч олгохгүй, харин холбогдох төрийн байгууллага хүсэлтийн дагуу олгоно). Хэрэв патент эзэмшигч ийм эс үйлдлээ хүндтэй шалтгаанаар тайлбарлаж чадвал холбогдох төрийн байгууллага тийм лиценз олгохоос татгалзана. Түүнээс гадна, хэрэв албадан лиценз олгох асуудал онцгой эрхээ буруугаар ашиглах явдлыг зогсоож чадахгүй бол тийнхүү албадан лиценз анх олгосноос хойш 2 жил өнгөрсний дараа патентыг хураан авч болно (Конвенцийн 5.A.3).

**(b) Барааны тэмдгийн хувьд:**

- Барааны тэмдэг бүртгүүлэх нөхцлийг Конвенцид заагаагүй бөгөөд түүнийг дотоодын хууль тогтоомжоор зохицуулна (Конвенцийн 6.1.). Хэлэлцэн тохирогч аль нэг улсын хэн нэгэн иргэний барааны тэмдгийг Хэлэлцэн тохирогч нөгөө улс гарал үүслийн улс нь түүнийг бүртгэж аваагүй, эсхүл шинэчлэн сунгаагүй гэсэн шалтгаанаар бүртгэхгүй байж болохгүй (Конвенцийн 6.2). Барааны тэмдгийг Хэлэлцэн тохирогч аль нэг улс нэгэнт бүртгэсэн бол түүнийг тусад нь авч үзэх (it is independent) бөгөөд тэр нь Хэлэлцэн тохирогч өөр улсад, түүнчлэн гарал үүслийн улсад дахин бүртгүүлэхэд саад болохгүй. Барааны тэмдгийн бүртгэлийг аль нэг улсад хүчингүй болгох нь нөгөө улсад байгаа бүртгэлд нөлөөлөхгүй (Конвенцийн 6.3.).
- Гарал үүслийн улсдаа зохих ёсоор бүртгүүлсэн барааны тэмдгийг Хэлэлцэн тохирогч бусад талууд хүсэлтийн дагуу анхны хэлбэрээр нь бүртгэж авах ёстой. Гэхдээ, уг барааны тэмдэг гуравдагч талын/улсын олдмол эрх (acquired rights of third parties)-ийг зөрчсөн, онцгой ялгарах шинжгүй, нийгмийн ёс зүй, хэв журамд харш, иргэдийг хууран мэхэлсэн/залилангийн шинжтэй г.м. хууль тогтоомжид заасан тодорхой үндэслэлээр түүнийг бүртгэхээс татгалзаж болно (Конвенцийн 6<sup>5</sup>.B.).
- Хэрэв Хэлэлцэн тохирогч тухайн улс зөвхөн бүртгүүлсэн барааны тэмдэг хэрэглэхийг шаарддаг бол түүний бүртгэлийг тодорхой хугацаа өнгөртөл, эсхүл зөвхөн эзэмшигч

нь өөрийнхөө эс үйлдлийн шалтгааныг тодорхой зааж чадахгүй байх тохиолдолд цуцалж болно (Конвенцийн 5.C.1).

- Хэлэлцэн тохирогч бүх Тал энэ Конвенцийн дагуу эрхээ эдэлж буй этгээдийн нэрд гарсан барааны тэмдгийг дахин бүтээх (a reproduction), дууриан хийх (imitation), эсхүл орчуулан хэрэглэх (translation) замаар, мөн холбогдох нэг төрлийн буюу ижил төрлийн бараанд ашиглах замаар аливаа будлиан, төөрөгдөл үүсгэх барааны тэмдгийг бүртгэхгүй бөгөөд хэрэглэхийг зөвшөөрөхгүй байна (Конвенцийн 62 дугаар зүйл).
  - Хэлэлцэн тохирогч бүх Тал мөн дээрхйн адил Хэлэлцэн тохирогч Талуудын зөвшөөрөлгүйгээр тэдний төрийн сүлд, албан ёсны зурлага, бэлгэ тэмдэг (armorial bearings, State emblems and official signs and hallmarks of contracting states) ашигласан барааны тэмдгийг бүртгэхгүй бөгөөд хэрэглэхийг зөвшөөрөхгүй байна. Энэ нь засгийн газар хоорондын зарим олон улсын байгууллагын сүлд, лого, далбаа, нэр болон нэрийн товчлолд нэгэн адил хамаарна. Энэ талаар Дэлхийн оюуны өмчийн байгууллагын Олон улсын товчоо (the International Bureau of WIPO)-нд мэдэгдэнэ (Конвенцийн 63 дугаар зүйлийн 6 дахь заалт).
  - Барааны хамтын эзэмшлийн тэмдэг (collective marks) оюуны өмчийн эрхээр хамгаалагдана (Конвенцийн 7<sup>2</sup> дугаар зүйл).
- (c) Бүтээгдэхүүний загварын хувьд** (Конвенцийн 5.B.):
- Талууд бүтээгдэхүүний загварыг хамгаална. Түүний бүрдэл хэсгүүдийг тухайн улсад үйлдвэрлээгүй гэсэн үндэслэлээр уг загварыг хамгаалахаас татгалзахгүй байвал зохино (protection may not be forfeited on the ground that the articles incorporating the design are not manufactured in that State).
- (d) худалдааны нэр/нэршил/аж ахуйн нэгжийн нэр** (Конвенцийн 8 дугаар зүйл):
- Талууд худалдааны нэрийг заавал бүртгэхгүйгээр хамгаалах арга хэмжээ авна.
- (e) Газар зүйн заалтын хувьд** (Конвенцийн 10, 10<sup>3</sup> дугаар зүйл):

- Талууд барааны гарал үүсэл буюу эх сурвалж, үйлдвэрлэгч, эсхүл борлуулагчийг шууд буюу шууд бус байдлаар худал заахыг хориглоно.
- (f) Шударга бус өрсөлдөөний хувьд (Конвенцийн 10<sup>2</sup> дугаар зүйл):
  - Талууд шударга бус өрсөлдөөнөөс хамгаалах тухай хуультай байна.

хүн буюу хуулийн этгээдийн хүсэлтээр, дотоодын хууль тогтоомжийн дагуу явагдана (Конвенцийн 9.1-9.3).

Дамжин өнгөрөх барааг хураан авахгүй (Конвенцийн 9.4).

Хэрэв тухайн улсын хууль тогтоомжоор барааг хил дээр хураах боломжгүй бол импортыг хориглох, эсхүл дотоодын зах зээлээс хураах арга хэмжээ авна (Конвенцийн 9.5).

Хэрэв дээр дурдсан аль ч арга хэмжээг авах боломжгүй бол холбогдох этгээд тухайн улсын иргэний адил эрхээ хамгаалуулах боломжтой байна (Конвенцийн 9.6).

Барааны тэмдэг, эсхүл худалдааны нэр хуулиар хамгаалагдсан бол түүнийг хууль бусаар хэрэглэсэн барааг Холбооны Гишүүн улсууд руу импортлох үед нь хураан авна. Тийнхүү хураан авах ажиллагаа прокурорын, эсхүл эрх бүхий өөр бусад байгууллагын, эсхүл сонирхсон хувь

### 36. Утга зохиол болон уран сайхны бүтээлийг хамгаалах тухай Бернийн конвенц (Бернийн Конвенц)

1.a. Гэрээний нэр англиар:	The Berne Convention for the Protection of Literary and Artistic Works (The Berne Convention)
1.б. Гэрээний нэр оросоор:	Бернская Конвенция об охране литературных и художественных произведений
2. Гэрээ байгуулагдсан огноо, улс, хот:	- 1886-09-09. Швейцарь Улсын Берн хот (The Berne, Switzerland) 1896-05-04-нд Парис хотноо эцэслэсэн.
3. Гэрээ хүчин төгөлдөр болсон огноо:	1887-12-05
4. Хэлэлцэн тохирогч Талын тоо:	2018 оны байдлаар: 179
5. Монгол Улс гэрээнд гарын үсэг зурсан, баталсан, соёрхон баталсан, нэгдэн орсон өдөр:	1997-01-09
6. Гэрээ баталсан баримт бичгийг хадгалагч хүлээн авсан огноо:	1997-12-12
7. Монгол Улсын хувьд гэрээ хүчин төгөлдөр болсон өдөр:	1998-03-12
8. Гэрээнд тайлбар (Reservation) хийсэн байдал:	1971 оны Парисын актын хавсралт (зүүлт)-ын I, II зүйлд заасан хөнгөлөлт эдлэх мэдэгдлийг эх хадгалагчид 2004 оны 6 дугаар сарын 25-ны өдөр гардуулсан. Уг мэдэгдэл нь 2004 оны 10 дугаар сарын 10-ны өдөр хүчин төгөлдөр болж, 2014 оны 10 дугаар сарын 10-ны өдөр дуусгавар болсон.
9. Гэрээнд нэмэлт өөрчлөлт оруулсан байдал:	- Берлин хотноо 1908-11-13-нд шинэчилж, 1914-03-20-нд Берн хотноо эцэслэсэн. Дараа нь Ром хотноо 1928-6-2-нд, Брюссель хотноо 1948-6-26-нд, Стокгольм хотноо 1967-07-14-нд, Парис хотноо 1971-7-24-нд тус тус шинэчилсэн. Парисын шинэчилсэн хувилбар (Paris Act, UCC Paris) нь 1974-07-10-ны өдөр хүчин төгөлдөр болсон бөгөөд түүнд 1979-09-28-нд нэмэлт өөрчлөлт оруулсан.
10. Монгол Улсын холбогдох хууль тогтоомжоос:	- Конвенцид нэгдэн орох тухай 1997 оны 1 дүгээр сарын 9-ний өдрийн хууль

#### Гэрээтэй холбогдсон бусад мэдээлэл:

Энэ Конвенц нь:

- (1) 3 үндсэн зарчим,
- (2) зохиогчийн эрхийг хамгаалах наад захын стандарт бүхий заалтууд, мөн
- (3) түүнийг дагаж мөрдөхийг хүссэн хөгжиж буй орнуудад хамаарах тусгай заалтуудаас тус тус бүрдэнэ.

(1) Энэ Конвенцид дараах гурван үндсэн зарчим тусгагдсан:

(a) Бернийн Холбооны Гишүүн Хэлэлцэн тохирогч нэг улсаас гаралтай, өөрөөр хэлбэл, зохиогч нь тухайн улсын иргэн байх, эсхүл тухайн улсад анх гарсан байх бүтээлийг Бернийн Холбооны Гишүүн Хэлэлцэн тохирогч бусад улсууд өөрсдийн иргэдийн бүтээлийн адил хамгаалалтад авах ёстой (“үндэсний зарчим” - principle of “national treatment”).

(b) Уг бүтээлийг албан ёсны ямар нэгэн болзол нөхцөл тавилгүйгээр, өөрөөр хэлбэл, ямар нэгэн бүртгэлгүйгээр, шууд хамгаалалтад авах ёстой (“автоматаар” хамгаалалтад авах зарчим - principle of “automatic” protection).

(c) Уг бүтээлийг гарал үүслийн улсад хамгаалсан эсэхээс үл хамааран хамгаалалтад авна. (хамгаалалт нь “бие даасан байх” зарчим - principle of the “independence” of protection). Харин тухайн улс аливаа бүтээлийг энэ Конвенц болон гарал үүслийн улсын хуулинд зааснаас урт хугацаагаар хамгаалдаг хуультай бөгөөд үүний улмаас уг бүтээлийг гарал үүслийн улсад хамгаалах хугацаа дууссан бол тухайн улс өөрийн хамгаалалтыг түүнтэй нэгэн адил хугацаанд дуусгавар болгоно.

Оюуны өмчийн эрхийн худалдаатай холбогдсон асуудлын тухай Хэлэлцээр (ТРИПС-ын Хэлэлцээр)-ийн дагуу “үндэсний зарчим”, “автоматаар хамгаалалтад авах зарчим”, “хамгаалалт нь бие даасан байх зарчим”-ыг Бернийн Конвенцийн Гишүүн биш боловч ДХБ-ын Гишүүн орон дагаж мөрдөнө. Түүнээс гадна ДХБ-ын аль нэгэн Гишүүн улсаас өөр нэг улсад үзүүлдэг “нэн тааламжтай зарчим” (the most-favored-nation treatment) ДХБ-ын Гишүүн бусад бүх оронд хамаарна. Мөн ТРИПС-ын Хэлэлцээрийн заалтыг хойшлуулан мөрдөх боломж үндэсний зарчим болон нэн тааламжтай зарчимд үл хамаарна.

(2) Зохиогчийн эрхийн хамгаалалтын наад захын стандарт заалт (minimum standards of protection), хугацаа:

(a) “Утга зохиол, урлагийн бүтээл” гэдэгт “утга зохиол, шинжлэх ухаан (эрдэм шинжилгээ), урлагийн салбарт гаргасан

бүх бүтээл, тэдгээрийн төрөл, хэлбэрээс үл хамааран багтана (Конвенцийн 2(1)).

(b) Конвенцийн зарим заалтад тайлбар хийх эрх (reservations), Конвенцид заасан зарим нэг хязгаарлалт (restrictions), мөн Конвенцид үл хамаарах асуудал (exemptions)-аас гадна зохиогчийн онцгой эрх байдлаар хүлээн зөвшөөрвөл зохих эрхүүдээс дурдвал:

- орчуулсан бүтээлийн эрх (the right to translate),

- товчлон хялбарчилсан, аранжировка хийсэн/найруулан тавьсан бүтээлийн эрх (the right to make adaptations and arrangements of the work),

- нийтийн хүртээл болсон жүжиг, хөгжимт жүжиг, хөгжмийн бүтээлийг тоглох эрх (the right to perform in public dramatic, dramatico-musical and musical works),

- нийтийн хүртээл болсон утга зохиолоос иш татах эрх (the right to recite in public literary works),

- дээрх бүтээлүүдийг олон нийтэд хүртээх эрх (the right to communicate to the public the performance of such works),

- радио, телевизээр дамжуулах эрх (энэ тохиолдолд Хэлэлцэн тохирогч аль нэг Тал зөвшөөрөл олгох эрхийг зохих шан хөлс авах/нэхэх энгийн эрхээр орлуулан хуульчлах боломжтой байх) (the right to broadcast (with the possibility of a contracting State to provide for a mere right to equitable remuneration instead of a right of authorization)),

- бүтээлийг аливаа арга, хэлбэрээр дахин бүтээх эрх (ийнхүү дахин бүтээсэн бүтээл нь эх бүтээлийг ашиглах хэвийн ажиллагаанд саад тотгор болохгүй байх, зохиогчийн хууль ёсны ашиг сонирхолд зүй бус хохирол учруулахгүй байх зарим нэг онцгой тохиолдолд Хэлэлцэн тохирогч аль нэг Тал холбогдох бүтээлийг зохиогчоос нь зөвшөөрөл авалгүйгээр дахин бүтээхийг зөвшөөрөх, мөн дуу хөгжмийн бичлэгийн хувьд Хэлэлцэн тохирогч аль нэг Тал зохих шан хөлс авах/нэхэх эрхийг хуульчлан тогтоох боломжтой байх) (the right to make

reproductions in any manner or form (with the possibility of a contracting State to permit, in certain special cases, reproduction without authorization provided that the reproduction does not conflict with the normal exploitation of the work and does not unreasonably prejudice the legitimate interests of the author, and with the possibility of a contracting State to provide, in the case of sound recordings of musical works, for a right to equitable remuneration)),

- тухайн бүтээлийг дуу, дүрс бүхий бүтээлд ашиглах эрх, уг дуу, дүрс бүхий бүтээлийг дахин бүтээх, түгээх, нийтэд зориулан тоглох, дамжуулах эрх (ТРИПС-д зааснаар, түрээслэх онцгой эрхийг компьютерийн програм, тодорхой тохиолдолд дуу, дүрс бичлэг бүхий бүтээлийн хувьд хүлээн зөвшөөрөх ёстой) (the right to use the work as a basis for an audiovisual work, and the right to reproduce, distribute, perform in public or communicate to the public that audiovisual work)(Under the TRIPS Agreement, an exclusive right of rental must be recognized in respect of computer programs and, under certain conditions, audiovisual works).

Уг Конвенцид бас “ёс зүйн эрх” (moral rights) буюу тухайн бүтээлийн зохиогч болохоо баталгаажуулах эрх (the right to claim authorship of the work), мөн зохиогчийн алдар, нэр хүндэд хохиролтой байдлаар бүтээлийг гажуудуулсан, сэвтүүлсэн, өөр бусад байдлаар хувиргасан, эсхүл бусад хэлбэрээр гутаасан үйлдлийг эсэргүүцэх эрхийн талаар заасан (the right to object to any mutilation or deformation or other modification of, or other derogatory action in relation to, the work which would be prejudicial to the author’s honor or reputation).

- (c) Эрхийг хамгаалах хугацаа нь ердийн журмаар тухайн зохиогчийн нас барснаас хойш 50 жил байна. Зохиогч нь тодорхой бус, эсхүл нэрээ нууцалсан бүтээл (anonymous or pseudonymous works)-ийг түүнийг хуулийн дагуу нийтийн хүртээл болгосноос хойш 50 хугацаанд хамгаална.

Энэ хугацаанд зохиогч нь тодорсон бол ердийн журам мөрдөнө. Дуу, дүрс бичлэг бүхий бүтээл (кино бүтээл - audiovisual or cinematographic works)-ийн хувьд түүнийг нийтэд үзүүлснээс хойш, хэрэв нийтэд үзүүлээгүй бол түүнийг бүтээснээс хойш 50 жилийн хугацаанд хамгаалагдана. Хэрэглээний Хавсрага урлагийн бүтээл болон фото зураг (works of applied art and photographic works)-ийн хувьд тэдгээрийг бүтээснээс хойш 25 жил байна. ТРИПС-ийн Хэлэлцээрт мөн дээрх хугацаанууд заагдсан байдаг байна.

- (3) НҮБ-ын Ерөнхий Ассамблейд тогтсон практикийн дагуу хөгжиж буй улсад хамаарах улс орнууд зарим бүтээлийн хувьд тодорхой болзол нөхцөлтэйгөөр дээрх наад захын стандартаас хазайж болно. Энэ нь бүтээлийг орчуулах болон үйлдвэрлэх эрх (the right of translation and the right of reproduction)-д хамаарна.

Энэ Конвенцоор Бернийн Холбоо (The Berne Union) (цаашид “Холбоо” гэх) үүсгэн байгуулагдсан. Энэ Конвенцийг мөрдөж буй бүх улс орон Холбооны Гишүүн болно. Холбоо нь Ассамблей болон Гүйцэтгэх хороотой байна. Стокгольмын баримт бичгийн ядаж захиргааны асуудал хөндсөн заалтууд болон төгсгөлийн заалтуудыг мөрддөг Холбооны Гишүүн улс орон бүр Ассамблейн Гишүүн байна. Гүйцэтгэх хорооны Гишүүдийг Холбооны Гишүүдээс сонгоно. Швейцарь Улс *ex officio* (өөрийн статус буюу бүрэн эрхийнхээ хүрээнд) Гүйцэтгэхийн хорооны байнгын Гишүүн байна.

ДХБ-ын Гишүүн орнууд Бернийн Конвенцийн Хэлэлцэн тохирогч Тал биш ч гэсэн түүний материаллаг заалтуудыг дагаж мөрдөх ёстой. Харин Бернийн Конвенцийн Хэлэлцэн тохирогч Тал биш ДХБ-ын Гишүүн улс уг Конвенцийн “ёс зүйн эрхүүд” -ийн тухай заалтуудыг дагаж мөрдөх албагүй.

Хөгжиж буй орнууд ТРИПС-ын Хэлэлцээрт заасан ихэнх үүргийг 2013 оны 7 дугаар сарын 1 хүртэл хойшлуулж болно (65 дугаар зүйл). Бернийн Конвенцийн Хэлэлцэн тохирогч Талууд уг Конвенцид заасан үүргээ хойшлуулах эрхгүй.

**Зохиогчийн эрхийн тухай дэлхийн конвенц**

(The Universal Copyright Convention - Всемирная Конвенция об авторском праве)

Зохиогчийн эрхийн тухай дэлхийн конвенц нь Женевийн акт (UCC Geneva - Geneva Act) болон Парисын акт (UCC Paris - The Paris Act) гэсэн 2 тусдаас конвенциос бүрдэнэ.

Женевийн акт гэгдэх конвенц нь 1952 оны 9 дүгээр сарын 6-ны өдөр Швейцарь Улсын Женев хотноо байгуулагдаж, 1955 оны 9 дүгээр сарын 16-ны өдөр хүчин төгөлдөр болсон. Хэлэлцэн тохирогч талын тоо: 2018 оны байдлаар 95. Монгол улс нэгдэж ороогүй.

*Энэ Конвенцоор Бернийн Конвенцид зааснаас арай цөөн тооны шаардлага тавигдсан. Бернийн Конвенц болон энэ Конвенцийн аль алиных нь гишүүн улсуудын хувьд энэ хоёр Конвенцийн хооронд зөрчил үүсвэл Бернийн Конвенцид тодорхой зааснаас бусад тохиолдолд энэ конвенцийг баримтална.*

Энэ конвенцид дараах зүйлс тусгагдсан:

1. Талууд өөрийн улсын зохиогч нарт зохиогчийн эрхийн хувьд бусад талуудын зохиогч нараас илүү хөнгөлөлт олгохгүй байх (дотоодын, эсхүл гадаадын зохиогч нарын эрхийг хамгаалах наад захын стандарт тогтоогоогүй)
2. Зохиогчийн эрхийн албан ёсны тэмдэглэгээ бүтээлийн бүх хуулбарууд дээр байна. Үүнд: символ ©, зохиогчийн нэр, нийтэлсэн он;

хэлэлцэн тохирогч аль нэг тал өөр бусад шаардлага тавьж болно, гэхдээ түүгээр өөрийн улсын зохиогчид илүү давуу эрх олгосон байж болохгүй

3. Зохиогчийн эрхийн хугацаа нь зохиогчийн амьд байх хугацаа, мөн түүнээс хойш 25 жил байна (гэрэл зургийн бүтээл болон хавсарга урлагийн бүтээлийн хувьд 10 жил байна).
4. Орчуулах онц эрхийг 7 жилийн хугацаагаар олгоно. Тодорхой тохиолдолд зохиогчийн эрхийн үлдсэн хугацаанд зохиогчийн зөвшөөрлөөр олгоно.

Парисын акт гэгдэх конвенц нь 1971 оны 7 дугаар сарын 24-ний өдөр Франц Улсын Парис хотноо байгуулагдаж, 1994 оны 7 дугаар сарын 10-ны өдөр хүчин төгөлдөр болсон. Хэлэлцэн тохирогч талын тоо: 2018 оны байдлаар 65. Монгол улс нэгдэж ороогүй.

*Энэ конвенц нь орчуулах, хуулбарлах, нийтэд зориулсан тоглолт хийх, радио-телевизээр дамжуулах зэрэг асуудлын хувьд хөгжиж буй орнуудын хэрэгцээ шаардлагыг харгалзан үзэж өмнө дурдсан Бернийн Конвенц болон Женевийн акт хоёрын текстийг шинэчлэн (өөрчлөн) найруулсан хувилбар юм. Чөлөөтэй болгосон зохицуулалтууд нь зөвхөн сургалт, эрдмийн ажил, судалгаанд хамаарна.*

1.a. Гэрээний нэр англиар:	Agreement on Trade Related Aspects of Intellectual Property Rights (TRIPs Agreement) ("Berne & Paris-plus" Agreement)
1.б. Гэрээний нэр оросоор:	Соглашение по торговым аспектам прав интеллектуальной собственности (Соглашение ТРИПС)
2. Гэрээ байгуулагдсан огноо, улс, хот:	- 1994-04-15. Марокко Улсын Марракеш хот - (Marrakesh, Morocco)
3. Гэрээ хүчин төгөлдөр болсон огноо:	1995-01-01
4. Хэлэлцэн тохирогч Талын тоо:	2018 оны байдлаар: 164
5. Монгол Улс гэрээнд гарын үсэг зурсан, баталсан, соёрхон баталсан, нэгдэн орсон өдөр:	1996-12-05 (Хэлэлцээрт нэгдэн орсон) 1996-12-26 (Протокол соёрхон баталсан)
6. Гэрээ баталсан баримт бичгийг хадгалагч хүлээн авсан огноо:	1996-12-30
7. Монгол Улсын хувьд гэрээ хүчин төгөлдөр болсон өдөр:	1997-01-29
8. Гэрээнд тайлбар (Reservation) хийсэн байдал:	Тайлбаргүй
9. Гэрээнд нэмэлт өөрчлөлт оруулсан байдал:	
10. Монгол Улсын холбогдох хууль тогтоомжоос:	<ul style="list-style-type: none"> <li>- Хэлэлцээрүүдийг хүлээн зөвшөөрч тэдгээрт нэгдэн орох тухай Монгол Улсын 1996 оны 12 дугаар сарын 5-ны өдрийн хууль: Тариф, худалдааны тухай 1994 оны Ерөнхий хэлэлцээр болон 1994 оны 4 дүгээр сарын 15-ны өдөр байгуулсан Дэлхийн худалдааны байгууллага байгуулах тухай Хэлэлцээрийг тус тус хүлээн зөвшөөрч, тэдгээрт нэгдэн орсугай;</li> <li>- Протокол соёрхон батлах тухай Монгол Улсын 1996 оны 12 дугаар сарын 26-ны өдрийн хууль: Монгол Улс, дэлхийн худалдааны байгууллагын хооронд 1996 оны 7 дугаар сарын 18-ны өдөр Женев хотноо гарын үсэг зурсан "Дэлхийн худалдааны байгууллага байгуулах Марракешийн Хэлэлцээрт Монгол Улс нэгдэн орох тухай Протокол" (The Protocol for the Accession of Mongolia to the Marrakesh Agreement Establishing the WTO Done at Geneva on 18 July 1996)-ыг соёрхон баталсугай;</li> <li>- ДХБ-д гишүүнээр элссэнтэй холбогдуулан авах арга хэмжээний тухай УИХ-ын 1996 оны 12 дугаар сарын 5-ны өдрийн 71 дүгээр тогтоол;</li> <li>- Монгол Улс Дэлхийн худалдааны байгууллагад нэгдэн орж буйтай холбогдуулан авах арга хэмжээний тухай Засгийн газрын 1997 оны 1 дүгээр сарын 8-ны өдрийн 14 дүгээр тогтоол</li> <li>- Ерөнхий сайдын захирамж -1997, №6</li> </ul>



### Гэрээтэй холбогдсон бусад мэдээлэл:

Энэ хэлэлцээрийг зарим эх сурвалжид “Худалдаанд хамаарах оюуны өмчийн эрхийн тухай хэлэлцээр” гэж орчуулсан байгаа.

Оюуны өмчийн эрхийн худалдаатай холбогдсон асуудлын тухай Хэлэлцээр (ТРИПС) нь ТХЕХ/ДХБ-ын системийн үндсэн зарчмыг тодорхойлж өгөхийн зэрэгцээ оюуны өмчийн асуудлыг олон улсын хэмжээнд зохицуулах эрх зүйн үндсийг бүрдүүлж өгч байна. ДХБ-ын Гишүүн орнууд хэрэв 1967 онд шинэчлэн найруулсан Аж үйлдвэрийн өмчийг хамгаалах тухай Парисын Конвенц, 1971 онд шинэчлэн найруулсан Утга зохиол, урлагийн бүтээлийг хамгаалах тухай Бернийн Конвенц зэрэг оюуны өмчийн асуудал зохицуулсан олон улсын гол гол Хэлэлцээрийн Хэлэлцэн тохирогч Тал биш бол тэдгээр олон улсын гэрээнд ТРИПС-ын дагуу нэгдэн орох үүрэгтэй. Түүнээс гадна, ДХБ-ын Гишүүн орнууд оюуны өмчийн бүх төрлийн эрхийн хувьд ТРИПС-ын хэм хэмжээг дагаж мөрдөх үүрэгтэй. Ингэснээр ДХБ-ын аливаа нэг Гишүүн орон олон улсын холбогдох гэрээний Хэлэлцэн тохирогч Тал мөн бишээс үл хамааран эрх зүйн зохицуулалтын нэгдмэл байдал бий болсон.

ДХБ-ын Гишүүн орнууд ТРИПС-ын хүрээнд дараах асуудалтай холбогдуулан үүрэг амлалт авах ёстой:

- зохиогчийн эрх болон түүнд хамаарах эрх (авторские и смежные права - copyright and related rights);
- барааны тэмдэг (товарные знаки);
- газар зүйн заалт (использование географических названий);
- бүтээгдэхүүний загвар (промышленный дизайн);
- патент (патенты);
- интеграл бүдүүвч/тойм зураг/интеграл микросхемийн байршлын загвар (топология интегральных микросхем - Topology of Integral/Integrated Microschemes);
- мэдээллийн нууцлалыг хамгаалах (защита конфиденциальной информации).

Энэ Хэлэлцээрээр оюуны өмчийн эрхийг хамгаалах эрх зүйн зохицуулалттай холбогдсон хяналтын бүхэл бүтэн системийг бүх түвшинд бий болгох талаар заасан.

Үндэсний түвшинд: улс орнууд дотоодын хууль тогтоомжоор оюуны өмчийн эрхийг хамгаалах

механизм бий болгох үүрэгтэй. Гаалийн байгууллага оюуны өмчийн эрх нь зөрчигдсөн байх үндэслэлтэй гэж үзвэл, эрх эзэмшигчийн хүсэлтээр барааг (жишээ нь, хуурамч барааг) дотоодын хэрэглээнд зориулан оруулахгүй байх механизм бүрдсэн байх ёстой. Үүнээс гадна, энэ Хэлэлцээр шүүхийн системд онцгой анхаарал тавьсан байдаг.

ДХБ-ын түвшинд: Оюуны өмчийн эрхийн худалдаатай холбогдсон асуудал эрхэлсэн Зөвлөлөөр дамжуулан хяналт тавигдана. ДХБ-ын бүх Гишүүн орон энэ Хэлэлцээрийг хэрэгжүүлэх үүднээс гаргасан дотоодын бүх хууль, хуульчилсан акт, горим журмын талаар уг Зөвлөлд мэдээлэл өгөх ёстой.

Хэлэлцээрийн гаалийн холбогдолтой заалтуудаас дурдвал:

#### 51 дүгээр зүйл:

1. Хуурамч барааны тэмдэгтэй буюу зохиогчийн эрх зөрчсөн барааг импортлож байна гэж сэжиглэх (*prima facie*) хангалттай үндэслэл байгаа бол эрх эзэмшигч уг барааг гаалийн байгууллагаар саатуулах тухай өргөдлөө захиргааны буюу шүүхийн байгууллагад бичгээр гаргахыг зөвшөөрсөн журмыг Гишүүн орнууд дор заасны дагуу тогтооно.
2. Эрх зөрчсөн барааны экспортыг гаалийн байгууллага мөн адилаар саатуулах журмыг Гишүүн орнууд тогтоож болно.

#### 52 дугаар зүйл: Өргөдөл гаргасан бол:

- эрх зөрчигдсөнийг гэрчлэх зохих ёсны нотлох баримтыг гаргаж өгөх
- гаалийн байгууллага уг барааг хялбархан танихаар дэлгэрэнгүй тодорхойлж өгөх

**53 дугаар зүйл:** Хариуцагч болон эрх бүхий холбогдох байгууллагыг хамгаалах/өмгөөлөх, эрхийн зөрчлийг арилгахад хангалттай хэмжээний баталгааг өргөдөл гаргагч гаргаж өгөх буюу түүнтэй ижилтгэн үзэх өөр бусад арга хэмжээ авна.

**54 дүгээр зүйл:** Бараа саатуулсан тухай холбогдох импортлогч болон өргөдөл гаргагчид нэн даруй мэдэгдэнэ.

**55 дугаар зүйл:** Хариуцагчаас өөр этгээд шүүх ажиллагааг эхлүүлсэн, эсхүл эрх бүхий байгууллага бараа саатуулах хугацааг түр сунгасан тухай бараа саатуулсан мэдэгдлийг өргөдөл гаргагч хүлээн авснаас хойш ажлын 10 хоногийн дотор гаалийн байгууллага мэдээгүй бол импорт, экспортын бусад шаардлага хангагдсан тохиолдолд уг барааг эзэнд нь олгоно. Зарим тохиолдолд уг хугацааг өшөө ажлын 10 хоногоор сунгаж болно.

**56 дугаар зүйл:** Барааг хууль бусаар саатуулсан, түүний улмаас бараа импортлогч, хүлээн авагч, өмчлөгчид учирсан хохирлыг өргөдөл гаргагч хариуцан барагдуулна.

**57 дугаар зүйл:** Эрх эзэмшигч мэдээллийн нууцад халдалгүйгээр барааг гаалийн байгууллагаар шалгуулах эрхтэй байна. Импортлогч мөн бараагаа шалгуулах боломжтой байна. Эрхийн зөрчил илэрсэн тохиолдолд бараа илгээгч, импортлогч, хүлээн авагчийн нэр, хаяг, барааны тоо хэмжээг эрх эзэмшигчид мэдэгдэнэ.

**58 дугаар зүйл:** Эрх бүхий байгууллага өөрийн санаачилгаар бараа саатуулах эрхтэй байх (*ex officio*) тохиолдолд авах арга хэмжээ:

- холбогдох мэдээллийг эрх эзэмшигчээс аль ч үед гаргуулан авах

- импортлогч, эрх эзэмшигчид бараа саатуулсан тухай мэдэгдэх
- эрх бүхий төрийн байгууллага, төрийн ажилтан зөвхөн эрх зөрчигдсөн нь эерэгээр эргэх тохиолдолд хариуцлагаас мултрах

**59 дүгээр зүйл:**

- эрх бүхий байгууллага 46 дугаар зүйлд заасан зарчмын дагуу барааг устгах, эсхүл захиран зарцуулах шийдвэр гаргана.
- хуурамч барааны тэмдэг бүхий барааг хуульд зааснаас бусад тохиолдолд хэвээр нь буцаан гаргах, эсхүл өөр горимд шилжүүлэхийг үл зөвшөөрнө.

**60 дугаар зүйл:** Зорчигчийн хувийн ачаа, илгээмжид байгаа бага хэмжээтэй (цөөн тооны) бөгөөд арилжааны зориулалтгүй бараанд дээрх журмыг хэрэглэхгүй байж болно.

**69 дүгээр зүйл:** Хуурамч барааны тэмдэгтэй буюу зохиогчийн эрх зөрчсөн барааны худалдаатай холбогдуулан гаалийн байгууллагууд харилцан мэдээлэл солилцох, хамтран ажиллах явдлыг Гишүүн орнууд дэмжинэ.



### 38. Зохиогчийн эрхийн тухай ДОӨБ-ын гэрээ

1.a. Гэрээний нэр англиар:	The World Intellectual Property Organization Copyright Treaty (The WIPO Copyright Treaty)
1.б. Гэрээний нэр оросоор:	Договор ВОИС (Всемирной организации интеллектуальной собственности) по авторскому праву (ДАП) (часто просто Договор по авторскому праву)
2. Гэрээ байгуулагдсан огноо, улс, хот:	- 1996-12-20, Швейцарь Улсын Женев хот - (Geneva, Switzerland)
3. Гэрээ хүчин төгөлдөр болсон огноо:	2002-03-06
4. Хэлэлцэн тохирогч Талын тоо:	2018 оны байдлаар: 100
5. Монгол Улс гэрээнд гарын үсэг зурсан, баталсан, соёрхон баталсан, нэгдэн орсон өдөр:	2002-05-02
6. Гэрээ баталсан баримт бичгийг хадгалагч хүлээн авсан огноо:	2002-07-25
7. Монгол Улсын хувьд гэрээ хүчин төгөлдөр болсон өдөр:	2002-10-25
8. Гэрээнд тайлбар (Reservation) хийсэн байдал:	Тайлбаргүй
9. Гэрээнд нэмэлт өөрчлөлт оруулсан байдал:	-
10. Монгол Улсын холбогдох хууль тогтоомжоос:	- Гэрээнд нэгдэн орох тухай 2002 оны 5 дугаар сарын 2-ны өдрийн хууль

#### Гэрээтэй холбогдсон бусад мэдээлэл:

Энэ гэрээг зохиогчийн эрхээр хамгаалагдсан дижитал орчин дахь материалыг олон улсын хэмжээнд хамгаалах тухай Бернийн Конвенцийн заалтын нэмэлт байдлаар Дэлхийн оюуны өмчийн байгууллагаас боловсруулсан (supplements the provisions of the Berne Convention to provide stronger international protection to copyrighted material

in the digital environment). Уг гэрээний хэрэгжилтэд ДОӨБ хяналт тавин ажилладаг.

Үүний зэрэгцээ “Интернэтийн салбар дахь ДОӨБ-ын гэрээ” (Договор ВОИС в области Интернета), “Гүйцэтгэл болон фонограммын тухай ДОӨБ-ын гэрээ” (Договором ВОИС по исполнению и фонограммам) гэж бий.













## VI БҮЛЭГ

ОЛОН УЛСЫН ШУУДАН ТЭЭВЭР, ОЛОН УЛСЫН УСАН  
ЗАМЫН ТЭЭВЭР, ОЛОН УЛСЫН АГААРЫН ЗАМЫН ТЭЭВЭР,  
ОЛОН УЛСЫН АВТО ЗАМЫН ТЭЭВЭР, ОЛОН УЛСЫН  
ТӨМӨР ЗАМЫН ТЭЭВЭРТ ХОЛБОГДОХ БАРИМТ БИЧГҮҮД

## Олон улсын тээврийн холбогдох байгууллага, тэдгээрийн хүрээнд мөрддөг баримт бичгүүд

ОЛОН УЛСЫН ШУУДАН ТЭЭВЭР	
	<p>Дэлхийн шуудангийн холбоо The Universal Postal Union Всемирный почтовый союз (Швейцарь Улсын Берн хот, 1874) (1948 оноос НҮБ-ын төрөлжсөн байгууллага)</p>
<p>ДШХ нь 1874 оны Бернийн гэрээ (Treaty of Berne)-гээр “General Postal Union” нэртэйгээр байгуулагдсан. 1978 оны Парисын Конгрессоор уг гэрээг “Конвенц” гэж нэрлэхээр болсон. Уг байгууллага 1977 оноос одоогийн нэрээ авсан. 189 гишүүн оронтой. 1964 оны Венын Конгрессоор ДШХ-ны бүх актыг нэгтгэн дараах 4 ангиллаар баталсан:</p> <ul style="list-style-type: none"> <li>• ДШХ-ны 1964 оны Үндсэн хууль (Constitution of the UPU) (1969 оны Токио-гийн, 1974 оны Lausanne-ын, 1984 оны Hamburg-ын, 1989 оны Washington-ы, 1994 оны Seoul-ийн, 1999 оны Beijing-ийн, 2004 оны Bucharest-ын, 2008 оны Geneva-ийн Конгрессоор нэмэлт, өөрчлөлт орсон);</li> <li>• Дэлхийн шуудангийн Конвенц (Universal Postal Convention) (1999 оны Бээжингийн Конгрессоор эцэслэн батлагдсан);</li> <li>• ДШХ-ны ерөнхий журмууд (General Regulations of the UPU) (2004 оны Бухарестын Конгрессоор эцэслэн баталсан);</li> <li>• Нарийвчилсан журмууд (Detailed Regulations).</li> </ul>	
ОЛОН УЛСЫН ДАЛАЙН ТЭЭВЭР	
	<p>Олон улсын далайн (тээврийн) байгууллага The International Maritime Organization (IMO) Международная морская организация (Их Британи ба Умард Ирландын Нэгдсэн Вант Улсын Лондон хот, 1948) (НҮБ-ын төрөлжсөн байгууллага)</p>
<p>ОУДТБ нь анх Далайн тээврийн засгийн газар хоорондын зөвлөлдөх байгууллага (the Inter-Governmental Maritime Consultative Organization - IMCO) нэртэйгээр байгуулагдсан нь 10 жилийн дараа хүчин төгөлдөр болж, 1959 онд анхны хуралдаанаа явуулжээ. 1982 онд шинэ нэртэй болсон байна. Монгол Улс 1996 онд ОУДТБ-ын Гишүүн болж, түүний 18 гэрээ, конвенц, протоколд нэгдэн орсон байна. Уг байгууллага 169 гишүүнтэй. Түүнээс боловсруулан гаргасан зарим баримт бичгээс дурдвал:</p> <ul style="list-style-type: none"> <li>• Далайн тээврийн бичиг баримтын талаар зарим дүрэм журмыг нэг мөр болгох тухай олон улсын Конвенц (Брюссель, 1924) (International Convention for the unification of certain rules of law relating to bills of lading - Конвенция об унификации некоторых правил о коносаменте), түүнд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай 1968 оны Протокол;</li> <li>• Хулгайн зорчигчийн тухай олон улсын Конвенц (Брюссель, 1957)(International Convention relating to stowaways);</li> <li>• Барааг далайгаар тээвэрлэх тухай НҮБ-ын Конвенц (Гамбург, 1978) (1924 оны Конвенцийг орлон гарч ирсэн. 1978 онд хүчин төгөлдөр болсон) (UN Convention on the carriage of goods by sea - Конвенция ООН о морской перевозке грузов);</li> <li>• Зорчигч болон тэдний тээшийг далайгаар тээвэрлэх тухай Афины Конвенц (1974) (Athens Convention relating to the carriage of passengers and their luggage by sea - Афинская конвенция о перевозках морем пассажиров и их багажа), түүнд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай 1990, 2002 оны Протокол;</li> <li>• Зорчигчийн ачаа тээшийг далайгаар тээвэрлэхтэй холбогдсон зарим дүрэм журмыг нэг мөр болгох тухай олон улсын Конвенц (International Convention for the unification of certain rules relating to carriage of passenger luggage by sea and Protocol), түүнд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай Протокол.</li> </ul> <p>Монгол Улс “Далай ашиглах тухай” 1999 оны хуулийг 2007 онд шинэчлэн баталсан, “Усан замын тээврийн тухай” хуулийг 2003 онд баталсан бөгөөд тус хуулийн хүрээнд 4 журам боловсруулан батлуулаад байна.</p>	

ОЛОН УЛСЫН АГААРЫН ЗАМЫН ТЭЭВЭР	
	<p>Олон улсын иргэний агаарын тээврийн байгууллага (Иргэний нисэхийн олон улсын байгууллага) International Civil Aviation Organization (ICAO) Международная организация гражданской авиации (ИКАО) (Канад Улсын Монреаль хот, 1947) (НҮБ-ын төрөлжсөн байгууллага)</p>
	<p>Олон улсын агаарын тээврийн нийгэмлэг International Air Transport Association (IATA) Международная ассоциация воздушного транспорта (ИАТА) (Канад Улсын Монреаль хот, 1947)</p>
<p>ИКАО нь 186 Гишүүнтэй. Монгол Улс 1989 онд нэгдэн орсон. Уг байгууллага дараах үүрэг хүлээсэн:</p> <ul style="list-style-type: none"> <li>• олон улсын иргэний агаарын тээврийг дэлхий дахинд аюулгүй байдлаар төлөвлөгөөтэй хөгжүүлэх явдлыг хангах;</li> <li>• иргэний нисэх онгоц үйлдвэрлэх, ашиглах явдлыг хөхүүлэн дэмжих, агаарын шугам, буудал, чиглүүлэх тоног төхөөрөмж зэргийг олон улсын иргэний нисэхэд зориулан гаргах;</li> <li>• аюулгүй, тогтмол үр ашигтай, арвилан хэмнэлттэй агаарын тээвэрлэлтээр дэлхийн хүн амыг хангах;</li> <li>• гааль, цагаачлал, эрүүл ахуйн зэрэг элдэв ёс дүрмийг багасгах замаар онгоц болон түүний зорчигч, ачаа тээш, экипаж, шууданг олон улсын хилээр агаараар саадгүй гатлан тээвэрлэх явдалд дэмжлэг үзүүлэх;</li> <li>• олон улсын иргэний агаарын тээврийн асуудлыг судалж олон улсын дүрэм журам, хэм хэмжээ тогтоох;</li> <li>• гааль, цагаачлал, эрүүл ахуйн дүрэм журмыг хялбарчлах;</li> <li>• олон улсын агаарын конвенцуудын төсөл бэлдэх.</li> </ul> <p>ИАТА нь анх Куба Улсын Гавана хотноо 1945 онд байгуулагдсан бөгөөд авиа компаниудын олон улсын худалдааны байгууллага (trade organization for airlines) болно. Түүнээс өмнө 1919 онд Гаага хотноо байгуулагдсан Олон улсын агаарын хөдөлгөөний нийгэмлэг (the International Air Traffic Association) гэж байсан. ИАТА-д зорчигч болон ачаа тээврийн 230 авиа компани нэгдэн орсон байдаг. Энэ байгууллага түүний гишүүн авиа компаниудыг төлөөлж, манлайлж, тэдэнд үйлчилж ажилладаг.</p> <p>Олон улсын агаарын тээврийн салбарт мөрддөг зарим баримт бичгээс дурдвал:</p> <ul style="list-style-type: none"> <li>• Олон улсын иргэний нисэхийн тухай Конвенц (1944 оны 12 дугаар сарын 7-нд батлагдсан. Чигагогийн Конвенц гэдэг. 1947 оны 4 дүгээр сарын 4-нд хүчин төгөлдөр болсон) (the Convention on International Civil Aviation) (Монгол Улс 1989 онд нэгдэн орсон);</li> <li>• Олон улсын агаарын тээвэрт хамааралтай зарим дүрэм журмыг нэг мөр болгох тухай Конвенц (Варшав хот, 1929) (the Convention for the unification of certain rules relating to international carriage by air - Конвенция для унификации некоторых правил, касающихся международных воздушных перевозок), түүнд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай 1933 оны Гаагын Протокол;</li> <li>• Гэрээт тээвэрлэгчээс бусад этгээдийн үйлдсэн олон улсын агаарын тээвэрт хамааралтай зарим дүрэм журмыг нэг мөр болгох тухай Конвенц (Варшавын Конвенцийн нэмэлт Конвенц) (Guadalajara, 1961-918) (Convention, supplementary to the Warsaw Convention, for the unification of certain rules relating to international carriage by air performed by a person other than the contracting carrier).</li> </ul> <p>1999 оны 1 дүгээр сарын 21-ний өдөр батлагдсан Иргэний нисэхийн тухай Монгол Улсын хуулиар ИАТУГ-ыг Иргэний нисэхийн ерөнхий газар {ИНЕГ} болгон өөрчилсөн. Монгол Улс ИКАО-гийн Гишүүн болсноор ИНЕГ олон улсын иргэний нисэхийн байгууллагуудын өмнө нислэгийн аюулгүй байдал, иргэний нисэхийн аюулгүй байдлыг хангах талаар зохих үүргүүдийг хүлээсэн байдаг.</p>	

ОЛОН УЛСЫН АВТО ЗАМЫН ТЭЭВЭР	
	<p>Олон улсын авто тээврийн холбоо The International Road and Transport Union (IRU) Международный союз автомобильного транспорта (Швейцарь Улсын Женев хот, 1948)</p>
<p>ОУАТХ 75 улсын 181 үндэсний нийгэмлэгийг эгнээндээ багтаасан. Уг байгууллага үйл ажиллагаандаа мөрдлөг болгон ажилладаг зарим баримт бичгээс дурдвал:</p> <ul style="list-style-type: none"> <li>• Замын хөдөлгөөний тухай Конвенц (Вена, 1968) (Конвенция о дорожном движении) (1977 онд хүчин төгөлдөр болсон) (Монгол Улс 1997-7-9-ний өдрийн хуулиар соёрхон баталсан);</li> <li>• Замын дохио, тэмдгийн тухай Конвенц (Вена, 1968);</li> <li>• Замын дохио, тэмдгийн тухай Протокол (Женев, 1949) (Протокол о дорожных знаках и сигналах);</li> <li>• Ачааг олон улсын хэмжээнд тээвэрлэх тухай 1959 оны гаалийн конвенц (Таможенная конвенция о международных перевозках грузов) (1978 онд хүчин төгөлдөр болсон);</li> <li>• Ачааг олон улсын хэмжээнд автозамаар тээвэрлэх гэрээний тухай НҮБ-ын Конвенц (Женев, 1956-5-19) (Convention on the contract for the international carriage of goods by road (CMR) - Конвенция о договоре международной дорожной перевозки грузов (ЦМР)), түүнд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай 2008 оны Нэмэлт Протокол.</li> </ul> <p>Зорчигч болон тээшийг олон улсын хэмжээнд автозамаар тээвэрлэх гэрээний тухай НҮБ-ын Конвенц (Женев, 1973-03-01) (Convention on the contract for the international carriage of passengers and luggage by road (CVR)), түүнд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай 1978 оны Протокол.</p>	
ОЛОН УЛСЫН ТӨМӨР ЗАМЫН ТЭЭВЭР	
	<p>Олон улсын төмөр замын холбоо The International Union of Railways (UIC) Международный союз железных дорог (Франц Улсын Париж хот, 1922) (Засгийн газрын бус байгууллага)</p>
	<p>Төмөр замын хамтын ажиллагааны байгууллага The Organization for Cooperation of Railways (OSShD) Организация сотрудничества железных дорог (ОСЖД) (Польш Улсын Варшав хот, 1956)</p>
	<p>Олон улсын төмөр замын тээврийн засгийн газар хоорондын байгууллага The Intergovernmental Organisation for International Carriage by Rail (OTIF) Межправительственная организация по международным железнодорожным перевозкам (ОТИФ) (Швейцарь Улсын Берн хот, 1893)</p>



Францаар “Union Internationale des Chemins de fer” гэгдэх Олон улсын төмөр замын холбоо анх Япон, Хятадыг оролцуулаад 29 орны 51 компанийг эгнээндээ нэгтгэсэн байсан. Хожим нь түүнд ЗХУ, Ойрхи Дорнод, Хойд Африкийн төмөр замууд нэгдэн орсон. Одоо Европ, Ази, Африк, Америк, Австрали тивээс 199 гишүүнтэй.

Төмөр замын хамтын ажиллагааны байгууллага 1956 оны 6 дугаар сарын 28-ны өдөр Болгар Улсын Софи хотноо төмөр замын асуудал эрхэлсэн Сайд нарын зөвлөлгөөнөөр байгуулагдсан. Түүний гишүүд нь дараах 27 улсын зам тээврийн яамдууд, төмөр замын асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллагууд болно: Азербайжан, Албани, Беларусь, Болгар, Унгар, Вьетнам, Гүрж, Иран, Казахстан, Хятад, БНАСАУ, Куба, Киргиз, Латви, Литва, Молдова, Монгол, Польш, ОХУ, Румын, Словак, Тажикистан, Туркменистан, Узбекистан, Украин, Чех, Эстон.

ТЗХАБ-ын ажлын хэл нь хятад, орос хэл юм. Олон улсын харилцаанд англи, герман хэл ашиглаж болно. Уг байгууллагын үндсэн баримт бичгүүдээс дурдвал:

- ТЗХАБ-ын Дүрэм (Положение об ОСЖД): энэ нь олон улсын гэрээний шинжтэй баримт бичиг гэсэн байдаг;
- Олон улсын төмөр замын ачааны харилцааны тухай Хэлэлцээр (Соглашение о международном железнодорожном грузовом сообщении (СМГС)) (1951-11-01) (ОУТЗХАБ-ын Гишүүн Куба, Румын, Словак, Чех улсаас бусад 23 улсын төмөр замын байгууллагууд нэгдэн орсон): Энэ баримт бичиг нь засгийн газрын хэмжээнд хийгдээгүй учир олон улсын гэрээ биш байх талтай;
- Олон улсын төмөр замын зорчигчийн харилцааны тухай Хэлэлцээр (Соглашение о международном пассажирском сообщении (СМПС)) (ОУТЗХАБ-ын Гишүүн Унгар, Иран, Куба, Румын улсаас бусад 23 улсын төмөр замын байгууллагууд нэгдэн орсон): Энэ баримт бичиг нь засгийн газрын хэмжээнд хийгдээгүй учир олон улсын гэрээ биш байх талтай.

Монгол Улсын төмөр зам Монгол улсын Зам, тээвэр, аялал жуучлалын Сайдын 2008 оны 5 дугаар сарын 27-ны өдрийн 88 тоот тушаалын 1 дүгээр хавсралтаар батлагдсан “Төмөр замаар ачаа тээвэрлэх дүрэм”, мөн тушаалын 2 дугаар хавсралтаар батлагдсан “Төмөр замаар зорчигч, тээш, ачаан тээш тээвэрлэх дүрэм”-ийг мөрддөг байна.

Олон улсын төмөр замын тээврийн засгийн газар хоорондын байгууллага нь 1985 оны 5 дугаар сарын 1-нд байгуулагдсан. Түүнээс өмнө Олон улсын төмөр замын тээврийн төв байгууллага (Central Office for International Carriage by Rail) хэмээх нэртэй байсан. Өнөөдөр уг байгууллагад Европ, Хойд Америк, Ойрх Дорнодын дараах 45 Гишүүн улс байна: Albania, Algeria, Austria, Belgium, Bosnia and Herzegovina, Bulgaria, Croatia, Czech Republic, Denmark, Estonia, Finland, France, Germany, Greece, Hungary, Iran, Iraq, Ireland, Italy, Latvia, Lebanon, Liechtenstein, Lithuania, Luxembourg, the Former Yugoslav Republic of Macedonia, Monaco, Montenegro, Morocco, Netherlands, Norway, Poland, Portugal, Romania, Russia, Serbia, Slovak Republic, Slovenia, Spain, Sweden, Switzerland, Syria, Tunisia, Turkey, Ukraine and United Kingdom.

Энэ байгууллагын ажлын хэл нь франц, герман хэл болно.

Энэ байгууллагын үндсэн баримт бичгүүдээс дурдвал:

- Барааг төмөр замаар тээвэрлэх тухай олон улсын конвенц (Берн, 1970-02-07) (International Convention concerning the carriage of goods by rail (CIM) - Бернская Конвенция о железнодорожной перевозке грузов (МГК - СИМ - ЦИМ)), түүний нэмэлт Протокол (Additional Protocol);
- Зорчигч болон тээшийг төмөр замаар тээвэрлэх тухай олон улсын конвенц (Берн, 1970-02-07) (International Convention concerning the carriage of passengers and luggage by rail (CIV) - Бернская Конвенция о железнодорожной перевозке пассажиров и багажа (МПК - СИВ - ЦИВ)), түүний нэмэлт Протокол (Additional Protocol).
- Зорчигч болон тээшийг төмөр замаар тээвэрлэх тухай 1970 оны олон улсын конвенц (CIV)-ийн нэмэлт Конвенц (Зорчигчид нас барсан, эсхүл тэдэнд гэмтэл учирсан тохиолдолд төмөр замын байгууллагын хүлээх хариуцлагын тухай) (1966-02-26)

(Additional Convention to the CIV Convention relating to the liability of the railway for death of and personal injury to passengers - Дополнительное соглашение к МПК об ответственности железных дорог при перевозках пассажиров);

- Олон улсын төмөр замын тээврийн тухай Конвенц (КОТИФ) (1980-05-09, Берн. 1985-05-01-нд хүчин төгөлдөр болсон) (Convention concerning international carriage by rail (COTIF) - Конвенция о международных перевозках по железной дороге (КОТИФ));
  - Зорчигч болон тээшийг улс хооронд төмөр замаар тээвэрлэх гэрээний Нийтлэг Дүрэм (Uniform Rules concerning the contract of international carriage of passengers by rail (CIV Uniform Rules) -Appendix A to the COTIF) - Единые правила о договоре международной перевозки пассажиров и багажа по железной дороге (Единые Правила МПК - СИВ - ЦИВ));
  - Барааг улс хооронд төмөр замаар тээвэрлэх гэрээний Нийтлэг Дүрэм (Uniform Rules concerning the contract of international carriage of goods by rail (the CIM Uniform Rules - Appendix B to the COTIF) - Единые правила о договоре международной перевозки грузов по железной дороге -Единые правила МГК (СИМ - ЦИМ));
  - Аюултай барааг улс хооронд төмөр замаар тээвэрлэх журам (Regulation concerning the international carriage of dangerous goods by rail (RID - Appendix C to the Convention) - Правила РИД, РИП, рико, РИЕКС);
  - Олон улсын төмөр замын тээвэрт автомашин ашиглах гэрээний тухай Нийтлэг Дүрэм (Uniform Rules concerning contracts of use of vehicles in international rail traffic (CUV Uniform Rules - Appendix D to the COTIF));
  - Олон улсын төмөр замын тээвэрт инфраструктур ашиглах гэрээний тухай Нийтлэг Дүрэм (Uniform Rules concerning the contract of use of infrastructure in international rail traffic (CUI Uniform Rules - Appendix E to the COTIF));
  - Олон улсын хөдөлгөөнд ашиглах төмөр замын материалын техникийн стандартыг баталгаажуулах, техникийн нэгдсэн стандарт батлах тухай Нийтлэг Дүрэм (Uniform Rules concerning the validation of technical standards and the adoption of uniform technical prescriptions applicable to railway material intended to be used in international traffic (APTU Uniform Rules - Appendix F to the COTIF));
  - Олон улсын хөдөлгөөнд ашиглах төмөр замын материалыг техникийн талаас нь хүлээн зөвшөөрөх тухай Нийтлэг Дүрэм (Uniform Rules concerning the technical admission of railway material used in international traffic (ATMF Uniform Rules - Appendix G to the COTIF));

КОТИФ-ыг хувирган өөрчлөх тухай 1999 оны Вильнюсын Протокол (the Protocol for the modification of COTIF (Vilnius Protocol)).

#### ДОТООДЫН УСАН ТЭЭВЭР

- Ачааг дотоодын усан замаар тээвэрлэх гэрээний тухай НҮБ-ын Конвенц (Будапешт, 2001-6-22) (Budapest Convention on the contract for the carriage of goods by inland waterway (CMNI));
- Зорчигч болон тээшийг дотоодын усан замаар тээвэрлэх гэрээний тухай НҮБ-ын Конвенц (Женев, 1976-2-6) (Convention on the contract for the international carriage of passengers and luggage by inland waterway (CVN)).

#### ХОЛИМОГ ТЭЭВРИЙН АСУУДЛААР БАЙГУУЛСАН

##### НҮБ-ЫН БАРИМТ БИЧГҮҮД

- Холимог тээврийн бичиг баримтын Нийтлэг Дүрэм (Анх 1973 онд хэвлэгдсэн) (ICC Uniform Rules for a combined transport document);
- Холимог тээврийн бичиг баримтад мөрдөх Дүрэм (ЮНКТАД/Олон улсын худалдааны танхим) (1991) (UNCTAD/ICC Rules for multimodal transport documents);
- Барааг олон улсын хэмжээнд холимог тээврээр тээвэрлэх тухай НҮБ-ын Конвенц (Женев, 1980-5-24) (UN Convention on international multimodal transport of goods) (MT Convention).

**Б. ЧӨЛӨӨТ ХУДАЛДААНЫ  
(ХӨНГӨЛӨЛТТЭЙ ХУДАЛДААНЫ, ЭДИЙН  
ЗАСГИЙН ТҮНШЛЭЛИЙН) ХЭЛЭЛЦЭЭР**

FREE TRADE (PREFERENTIAL TRADE  
OR ECONOMIC PARTNERSHIP) AGREEMENTS

СОГЛАШЕНИЯ О СВОБОДНОЙ ТОРГОВЛИ  
(О ПРЕФЕРЕНЦИАЛЬНОЙ ТОРГОВЛИ  
ИЛИ ОБ ЭКОНОМИЧЕСКОМ ПАРТНЕРСТВЕ)



# VII БҮЛЭГ

ЧӨЛӨӨТ ХУДАЛДААНЫ ОЛОН ТАЛТ ХЭЛЭЛЦЭЭР

MULTILATERAL FREE TRADE AGREEMENTS

МНОГОСТОРОННЫЕ СОГЛАШЕНИЯ О СВОБОДНОЙ ТОРГОВЛИ



### 39. Ази, Номхон далайн худалдааны хэлэлцээр

1. Гэрээний нэр англиар:	The Asia Pacific Trade Agreement
2. Гэрээ байгуулагдсан огноо, улс, хот:	- 1975-07-31, Таиландын Вант Улсын Бангкок хот (Bangkok, Thailand)
3. Гэрээ хүчин төгөлдөр болсон огноо:	
4. Хэлэлцэн тохирогч Талын тоо:	2018 оны байдлаар: 6 + Монгол
5. Монгол Улс гэрээнд гарын үсэг зурсан, баталсан, соёрхон баталсан, нэгдэн орсон өдөр:	
6. Гэрээ баталсан баримт бичгийг хадгалагч хүлээн авсан огноо:	
7. Монгол Улсын хувьд гэрээ хүчин төгөлдөр болсон өдөр:	
8. Гэрээнд тайлбар (Reservation) хийсэн байдал:	
9. Гэрээнд нэмэлт өөрчлөлт оруулсан байдал: - Анх 1975 оны Бангокийн хэлэлцээр гэж байсан. 2005 онд Ази, Номхон далайн худалдааны хэлэлцээр болгон өөрчилсөн.	
10. Монгол Улсын холбогдох хууль тогтоомжоос:	

#### Гэрээтэй холбогдсон бусад мэдээлэл:

Ази, Номхон далайн худалдааны хэлэлцээр нь Ази, Номхон далайн эдийн засаг, нийгмийн комисс (ESCAP)-ын санаачилгаар анх 1975 оны 7 дугаар сарын 31-ний өдөр Бангокийн хэлэлцээр гэж байгуулагдсан Ази, Номхон далайн бүсийн анхны хөнгөлөлттэй худалдааны хэлэлцээр (preferential trade agreement) бөгөөд 2005 оны 11 дүгээр сарын 2-ны өдрөөс уг хэлэлцээрийг Ази, Номхон далайн худалдааны хэлэлцээр (АПТА) болгон өөрчилсөн байдаг. Уг хэлэлцээрийг байгуулсан анхны улсууд нь Бангладеш, Энэтхэг, БНСУ, Лаос, Шри Ланка Улсууд бөгөөд БНХАУ 2001 онд, Монгол Улс 2013 онд нэгдэн орсон.

Энэхүү хэлэлцээрийн зорилго нь Ази, Номхон далайн улс хоорондын худалдааг өргөжүүлэх тасралтгүй үйл явцаар дамжуулан тэдгээр улсын эдийн засгийн хөгжлийг дэмжих, түүнчлэн тэдний өнөөгийн болон ирээдүйн хөгжил, худалдааны хэрэгцээнд нийцүүлэн худалдааг харилцан ашигтай байдлаар чөлөөлснөөр олон улсын эдийн засгийн хамтын ажиллагаанд ахиц гаргахад оршино. Гишүүн орнууд өнөөг хүртэл 4 удаагийн тарифын хэлэлцээ хийж, 10 мянга гаруй барааны татварыг харилцан бууруулах үүргийг авсан.


Монгол Улсын гадаад худалдааны нийт бараа эргэлтийн 60 гаруй хувь, экспортын 90 гаруй хувь, импортын 30 гаруй хувийг АПТА-гийн гишүүн орнууд эзэлдэг бөгөөд Монгол Улс АПТА-д нэгдсэнээр манай экспортын бараа БНХАУ болон

БНСУ-ын зах зээлд дунджаар 40%-ийн хөнгөлөлт эдлэх боломжтой юм. Мөн эдгээр орнуудаас Монголд оруулах хөрөнгө оруулалтын хэмжээ нэмэгдэж, Монгол Улсын эдийн засагт эерэгээр нөлөөлөх ач холбогдолтой гэж үзэж байна. Түүнээс гадна Азийн зах зээлд Монгол Улсын экспортын бараа бүтээгдэхүүнийг хөнгөлөлттэй нөхцөлөөр нэвтрүүлэх, Хөнгөлөлтийн жагсаалтад багтсан бараа бүтээгдэхүүнийг үндэсний үйлдвэрлэгчид тухайн зах зээлд нийцүүлэн үйлдвэрлэх зэргээр зах зээлээ тэлэх орчинг бий болгох, экспортын барааны нэр төрлийг нэмэгдүүлэх ач холбогдолтой юм.

Хэлэлцээрт нэгдэн орох асуудлыг 2016 оны 10 дугаар сарын 26-ны өдрийн Засгийн газрын хуралдаанаар хэлэлцүүлж, Олон улсын гэрээний тухай хуулийн 8 дугаар зүйлийн 1-д заасны дагуу УИХ-ын Аюулгүй байдал, гадаад бодлогын байнгын хорооны 2016 оны 11 дүгээр сарын 15-ны өдрийн хуралдаанаар хэлэлцүүлж дэмжүүлсэн байдаг.

Энэхүү хэлэлцээр нь Монгол Улсын бүс нутгийн хэмжээний чөлөөт худалдааны анхны хэлэлцээр болох бөгөөд олон улс, бүс нутгийн худалдаа, эдийн засгийн интеграцид нэгдэхэд гол хөшүүрэг болох ач холбогдолтой.

Зураг 22. Ази, Номхон далайн бүсийн худалдааны хэлэлцээрт нэгдсэн орны газрын зураг



Хүснэгт 23. АПТА-гийн Хөнгөлөлтийн жагсаалт, хөнгөлөлтийн хэмжээ

### АПТА-гийн Хөнгөлөлтийн жагсаалт, хөнгөлөлтийн хэмжээ

Хөнгөлөлт үзүүлэгч улс	3 дахь үе шатны хэлэлцээний дараах байдлаар				4 дэх үе шатны хэлэлцээний дараах байдлаар (HS2012)			
	ҮХЖ-д орсон барааны тоо хэмжээ	Хөнгөлөлтийн хэмжээ (%)	Нэн буурай хөгжилтэй улсуудад үзүүлж буй хөнгөлөлтийн жагсаалт	Нэн буурай хөгжилтэй улсуудад үзүүлж буй хөнгөлөлтийн хэмжээ (%)	ҮХЖ-д орсон барааны тоо хэмжээ	Хөнгөлөлтийн хэмжээ (%)	Нэн буурай хөгжилтэй улсуудад үзүүлж буй хөнгөлөлтийн жагсаалт	Нэн буурай хөгжилтэй улсуудад үзүүлж буй хөнгөлөлтийн хэмжээ (%)
Бангладеш	209	14.1	-	-	598	21.763	4	27.5
Хятад	1,697	26.7	161	77.9	2191	33.09	181	79.58
Энэтхэг	570	23.9	48	39.7	3334	34.55	48	65.48
Солонгос	1,367	35.4	306	64.6	2796	33.36	951-BLD 941-LAOS	94.46-BLD 94.22-LAOS
Шри-Ланк	427	14.0	72	12	584	22.21	75	18.17
Лаос	-	-	-	-	999	30.17	-	-
Монгол Улс	-	-	-	-	377	24.18	-	-
<b>Нийт</b>	<b>4,270</b>	<b>27.20</b>	587	59.8	<b>10,868</b>	<b>31.83</b>	1259 1249	83.96 83.70





# VIII БҮЛЭГ

ЧӨЛӨӨТ ХУДАЛДААНЫ ХОЁР ТАЛТ ХЭЛЭЛЦЭЭР

BILATERAL FREE TRADE AGREEMENTS

ДВУХСТОРОННЫЕ СОГЛАШЕНИЯ О СВОБОДНОЙ ТОРГОВЛИ



#### 40. Эдийн засгийн түншлэлийн тухай Монгол улс, Япон улс хоорондын хэлэлцээр

1. Гэрээний нэр англиар:	Agreement between Mongolia and Japan for an Economic Partnership
2. Гэрээ байгуулагдсан огноо, улс, хот:	2015-02-10. Япон Улсын Токио хот (Tokyo, Japan)
3. Гэрээ хүчин төгөлдөр болсон огноо:	2016-06-07
4. Монгол Улс гэрээг баталсан, соёрхон баталсан өдөр:	(Үндсэн хэлэлцээр: УИХ: Хууль: 2015-02-17, Хэрэгжүүлэх хэлэлцээр: ЗГТ: 2015-05-25, №204)
5. Гэрээ баталсан баримт бичиг (дипломат нот бичиг) солилцсон өдөр:	2016 оны 5 дугаар сарын 8
6. Гэрээнд нэмэлт өөрчлөлт оруулсан байдал: -	
7. Монгол Улсын холбогдох хууль тогтоомжоос:	<ul style="list-style-type: none"> <li>- Эдийн засгийн түншлэлийн тухай хэлэлцээр соёрхон батлах тухай 2015 оны 2 дугаар сарын 17-ны өдрийн хууль.</li> <li>- Хэлэлцээр батлах тухай Засгийн газрын 2015 оны 5 дугаар сарын 25-ны өдрийн 204 дүгээр тогтоол.</li> <li>- Засгийн газар хоорондын комиссуудын Монголын хэсгийн удирдах бүрэлдэхүүний тухай Засгийн газрын 2016 оны 9 дүгээр сарын 14-ний өдрийн 88 дугаар тогтоол.</li> </ul>

#### Гэрээтэй холбогдсон бусад мэдээлэл:

#### ХЭЛЭЛЦЭЭРИЙН БҮТЭЦ, ТҮҮНД ТУСГАГДСАН АСУУДЛУУД

Үндсэн Хэлэлцээр (the Basic Agreement) дараах 17 бүлгээс бүрдэж байна:

- 1 дүгээр Бүлэг. Ерөнхий зүйл (General Provisions)
- 2 дугаар Бүлэг. Барааны худалдаа (Trade in Goods - GATT: Market Access and Rules)
- 3 дугаар Бүлэг. Гарал үүслийн дүрэм (Rules of Origin)
- 4 дүгээр Бүлэг. Гаалийн үйл ажиллагаа болон худалдааг хөнгөвчлөх (Customs Procedures and Trade Facilitation)
- 5 дугаар Бүлэг. Эрүүл ахуй, ургамлын эрүүл ахуйн арга хэмжээ (Sanitary and Phytosanitary Issues) (SPS Agreement)
- 6 дугаар Бүлэг. Техникийн зохицуулалт, стандарт болон тохирлын үнэлгээний журам (Technical Regulations, Standards and Conformity Assessment Procedures )(Худалдаан дахь техникийн хориг саад - Technical Barriers to Trade)
- 7 дугаар Бүлэг. Үйлчилгээний худалдаа (Trade in Services - GATS)
- 8 дугаар Бүлэг. Хувь хүний шилжилт хөдөлгөөн (Movement of Natural Persons)
- 9 дүгээр Бүлэг. Цахим худалдаа (e-Commerce)
- 10 дугаар Бүлэг. Хөрөнгө оруулалт (Investment)
- 11 дүгээр Бүлэг. Өрсөлдөөн (Competition)
- 12 дугаар Бүлэг. Оюуны өмч (Intellectual Property)
- 13 дугаар Бүлэг. Засгийн газрын худалдан авах ажиллагаа (Government Procurement)
- 14 дүгээр Бүлэг. Бизнесийн орчныг сайжруулах (Business Environment)
- 15 дугаар Бүлэг. Хамтын ажиллагаа (Cooperation)
- 16 дугаар Бүлэг. Маргаан шийдвэрлэх (Dispute Settlement)
- 17 дугаар Бүлэг. Төгсгөлийн заалт (Final Provisions)

Үндсэн хэлэлцээр нь дараах 10 хавсралттай байна (холбогдох бүлгүүдийг хамт дурдав):

**Барааны худалдаа (2 дугаар Бүлэг):**

Хавсралт 1: Монгол Улсын болон Япон Улсын импортын барааны тарифын жагсаалтууд (Schedule of Mongolia, Schedule of Japan)

**Гарал үүсэл (3 дугаар Бүлэг):**

Хавсралт 2: Бүтээгдэхүүний тусгай дүрэм (Product Specific Rules)

Хавсралт 3: Гарал үүслийн гэрчилгээнд тусгагдах үндсэн мэдээлэл (Minimum Data Requirement for Certificate of Origin)

**Үйлчилгээний худалдаа (7 дугаар Бүлэг):**

Хавсралт 4: Санхүүгийн үйлчилгээ (Financial Services)

Хавсралт 5: Цахилгаан холбооны үйлчилгээ (Telecommunications Services)

Хавсралт 6: Тусгай үүрэг амлалтын жагсаалт болон Нэн тааламжтай үндэстний нөхцөлөөс чөлөөлөх жагсаалт (Schedules of Specific Commitments and List of Most-Favored-Nation Treatment Exemptions)

**Хувь хүний шилжилт хөдөлгөөн (8 дугаар Бүлэг):**

Хавсралт 7: Хувь хүний шилжилт хөдөлгөөний талаарх тусгай үүрэг амлалт (Specific Commitments for the Movement of Natural Persons)

**Хөрөнгө оруулалт (10 дугаар Бүлэг):**

Хавсралт 8: 10.8 дугаар зүйлийн 1 дэх хэсэгт дурдсан хадгалах арга хэмжээ (Reservations for Measures referred to in Paragraph 1 of Article 10.8)

Хавсралт 9: 10.8 дугаар зүйлийн 3 дахь хэсэгт дурдсан хадгалах арга хэмжээ (Reservations for Measures referred to in Paragraph 3 of Article 10.8)

Хавсралт 10: Албадан хураалт (Expropriation)

Үндсэн хэлэлцээрээр Талууд Хамтарсан хороо (Joint Committee)(1.13) байгуулсан бөгөөд уг хэлэлцээр хүчин төгөлдөр үйлчилж эхлэх өдөр дараах дэд хороод (Sub-Committees)-ыг байгуулахаар заасан (1.14):

- (a) Үндсэн хэлэлцээрийн 2.19-д заасны дагуу Барааны худалдааны дэд хороо;
- (b) Үндсэн хэлэлцээрийн 3.25-д заасны дагуу Гарал үүслийн дүрмийн дэд хороо;
- (c) Үндсэн хэлэлцээрийн 4.8-д заасны дагуу Гаалийн үйл ажиллагааны болон худалдааг хөнгөвчлөх дэд хороо;
- (d) Үндсэн хэлэлцээрийн 5.6-д заасны дагуу Эрүүл ахуй, ургамлын эрүүл ахуйн арга хэмжээний дэд хороо;
- (e) Үндсэн хэлэлцээрийн 6.9-д заасны дагуу Техникийн зохицуулалт, стандарт болон тохирлын үнэлгээний журмын дэд хороо;
- (f) Үндсэн хэлэлцээрийн 7.16-д заасны дагуу Үйлчилгээний худалдааны дэд хороо;
- (g) Үндсэн хэлэлцээрийн 8.6-д заасны дагуу Хувь хүний шилжилт хөдөлгөөний дэд хороо;
- (h) Үндсэн хэлэлцээрийн 9.13-т заасны дагуу Цахим худалдааны дэд хороо;
- (i) Үндсэн хэлэлцээрийн 10.18-д заасны дагуу Хөрөнгө оруулалтын дэд хороо;
- (j) Үндсэн хэлэлцээрийн 12.18-д заасны дагуу Оюуны өмчийн дэд хороо;
- (k) Үндсэн хэлэлцээрийн 13.5-д заасны дагуу Засгийн газрын худалдан авах ажиллагааны дэд хороо;
- (l) Үндсэн хэлэлцээрийн 14.2-т заасны дагуу Бизнесийн орчныг сайжруулах дэд хороо;
- (m) Үндсэн хэлэлцээрийн 15.4-т заасны дагуу Хамтын ажиллагааны дэд хороо.

Дэд хороодын бүрэлдэхүүн, чиг үүргийг Үндсэн хэлэлцээрийн холбогдох бүлэгт, бас зарим тохиолдолд Хэрэгжүүлэх хэлэлцээрийн холбогдох бүлэгт зааж өгсөн.

Хэрэгжүүлэх Хэлэлцээр нь дараах 6 бүлгээс бүрдэж байна:

- 1 дүгээр Бүлэг. Ерөнхий зүйл (General Provisions)
- 2 дугаар Бүлэг. Гаалийн үйл ажиллагаа болон худалдааг хөнгөвчлөх (Customs Procedures and Trade Facilitation)
- 3 дугаар Бүлэг. Өрсөлдөөн (Competition)
- 4 дүгээр Бүлэг. Бизнесийн орчныг сайжруулах (Improvement of the Business Environment)
- 5 дугаар Бүлэг. Хамтын ажиллагаа (Cooperation)
- 6 дугаар Бүлэг. Төгсгөлийн заалт (Final Provisions)

Үндсэн хэлэлцээр (цаашид “ЭЗТХ” гэх)-ийн бүлгүүдээс товчхон танилцуулбал:

### Барааны худалдаа (ЭЗТХ-ийн 2 дугаар Бүлэг болон Хавсралт 1):

Хавсралт 1-д дурдсан жагсаалт Барааг тодорхойлох, кодлох уялдуулсан систем (цаашид “БТКУС”, “Уялдуулсан систем”, эсхүл “УС” гэж бичигдсэн байгаа, англиар: HS (Harmonized System or the Harmonized Commodity Description and Coding System))-ийн 2012 оны хувилбараар хийгдсэн бөгөөд цаашид Талуудын хоорондын худалдаанд хамаарах барааны ангилал БТКУСТ орох нэмэлт өөрчлөлтөд нийцсэн байна (ЭЗТХ-ийн 2.2).

Талуудын хооронд худалдаалж буй барааны гаалийн үнийг тодорхойлох зорилгоор Гаалийн үнэлгээний тухай хэлэлцээрийн I хэсгийг *mutatis mutandis* зарчмаар (хэвээр нь) мөрдөнө(ЭЗТХ-ийн 2.5).

Хоёр тал нөгөө улсын зохих гарал үүсэлтэй импортын барааны 90 хувийг дараах байдлаар гаалийн 0 тарифтай болгоно (ЭЗТХ-ийн 2.4):

ЭЗТХ-ийн Хавсралт 1 дэх тэмдэглэгээ	Тайлбар
A	• Гаалийн тарифыг ЭЗТХ хүчин төгөлдөр болсон өдрөөс эхлэн тэглэх;
B3, B5, B7, B10, B15, B20	• Гаалийн тарифыг ЭЗТХ хүчин төгөлдөр болсон өдрөөс эхлэн 4, 6, 8, 11, 16, 21 жил дараалан жил бүр ижил хэмжээгээр бууруулж, тэглэх;
B10*	• Гаалийн тарифыг ЭЗТХ хүчин төгөлдөр болсноос хойш 11 дэх жилийн эхний өдөр тэглэх;
P	• Гаалийн тарифыг хэлэлцээрийн хавсралтад заасан нөхцөлийн дагуу бууруулах;
Q	• Гаалийн тарифыг хэлэлцээрийн хавсралтад заасан нөхцөлийн дагуу ногдуулах;
R	• Гаалийн тарифыг хэлэлцээрийн хавсралтад заасан нөхцөлийн дагуу дахин хэлэлцэх;
X	• Гаалийн тарифыг бууруулах, эсхүл тэглэх аливаа үүрэг амлалт авахгүй байх.

ЭЗТХ-ийн Хавсралт 1-д зааснаар, гаалийн татварыг бууруулах, эсхүл тэглэх зорилгоор *ad valorem*(гаалийн үнээс хувиар тогтоосон) тариф 0.1-ээс бага хувиар илэрхийлэгдсэн байвал хамгийн ойр байх аравны хувиар тоймлоно (тухайлбал, 0.05 хувийг 0.1 хувь болгож тоймлоно). Биет хэмжээнд ногдуулах татвар(барааны нэгжид мөнгөн илэрхийллээр тогтоосон тариф - *specific duties*)-ын хувьд тухайн Талын мөнгөн тэмдэгтийн 0.01-ээс багаар илэрхийлэгдсэн бол хамгийн ойр

зууны хувиар тоймлоно (тухайлбал, 0.005 хувийг 0.01 хувь болгож тоймлоно)

Татварын (тарифын) эхний жилийн бууралтыг ЭЗТХ хүчин төгөлдөр болох өдрөөс эхэлнэ. Дараагийн жилийн бууралтыг жил бүрийн 4 дүгээр сарын 1-ний өдрөөс хэрэгжүүлнэ. ЭЗТХ-ийн Хавсралт 1-ийн зорилгоор “жил” гэх нэр томъёо нь эхний жилийн хувьд уг хэлэлцээр хүчин төгөлдөр болох өдөр эхэлж, дараагийн 3 дугаар сарын 31-ний өдөр хүртэлх хугацааг, дараагийн жилийн

хувьд тухайн жилийн 4 дүгээр сарын 1-ний өдрөөс эхлэн 12 сар үргэлжлэх хугацааг хэлнэ.

Дээрх байдлаар тэглэх гаалийн тариф нь импортын бараанд өнөөдөр мөрдөж буй нэн тааламжтай тариф (applied MFN rates) (Хавсралт 1-ийн 3 дугаар баганад заасан суурь татвар (Base rate)) байна. ЭЗТХ-т ердийн тариф (basic rate) болон ДХБ-д элсэн орохдоо үүрэг амлалт болгон хүлээсэн тарифын дээд хязгаар (bound rates), мөн экспортын гаалийн албан татвар хамаарахгүй.

ЭЗТХ-ийн 2.3-т зааснаар Хэлэлцээрийн нэг Тал нөгөө Талын бараанд ТХЕХ-ийн III зүйл (GATT Article III: National Treatment on Internal Taxation and Regulation)-ийн дагуу үндэсний нөхцөл олгоно. Өөрөөр хэлбэл, ТХЕХ-ийн III зүйлийн дагуу, ДХБ-ын бүх гишүүн улс (холбоо) бусад гишүүн улсаас оруулсан барааг дотоодын борлуулалт болон дотоодын татвар (internal sale and internal taxes)-ын хувьд дотоодын үйлдвэрийн бараатай нэгэн адилаар авч үзнэ. Тухайлбал, дотоодын үйлдвэрлэлийг хамгаалах зорилгоор дотоодын татвар (НӨАТ (VAT), онцгой албан татвар (Excise Duties), г.м.)-ыг ДХБ-ын гишүүн улсын импортын бараанд дотоодын үйлдвэрлэлийн бараанаас өндрөөр тогтоож болохгүй.

ЭЗТХ-т шаардлагатай тохиолдолд хамгаалалтын хоёр талт арга хэмжээ (Bilateral Safeguard Measures) авч хэрэгжүүлж, эсхүл аль нэг тал нь ДХБ-ын холбогдох хэлэлцээрт заасан хамгаалалтын, демпингийн эсрэг буюу саармагжуулах арга хэмжээ (Safeguard Measures, Anti-Dumping Duties or Countervailing Duties under the WTO Agreement) авч хэрэгжүүлж болохоор байгаа (ЭЗТХ-ийн 2.8, 2.17).

Аль нэг Тал нөгөө Талын аливаа барааг импортлох, эсхүл нөгөө Талд экспортлох, эсхүл экспортлох зорилгоор худалдахад гаалийн татвараас өөр, ДХБ-ын тухай хэлэлцээрийн холбогдох заалтын дагуу хүлээсэн үүрэгт үл нийцэх аливаа хориг, хязгаарлалт тогтоохгүй (not to introduce or maintain any prohibition or restriction other than customs duties) (ЭЗТХ-ийн 2.7).

### **Гарал үүслийн дүрэм (ЭЗТХ-ийн 3 дугаар Бүлэг болон 2, 3 дугаар хавсралт):**

Гаалийн татварын дээр заасан хөнгөлөлттэй хувь хэмжээг бусад улсын гарал үүсэлтэй бараанд хамруулж буруугаар ашиглах явдлыг гаргуулахгүй байх зорилгоор ЭЗТХ-т "зохих гарал үүсэлтэй бараа" (Originating Goods)-ны тодорхойлолтыг өгч, бүрэн гарал үүсэлтэй байх (Wholly Obtained or Produced), зохих гарал үүсэлтэй материалаар

үйлдвэрлэсэн байх (produced entirely in the Party exclusively from originating materials of the Party) тохиолдлыг зааж, бүтээгдэхүүний тусгай дүрэм (the Product Specific Rules), түүний дотор оёмол, сүлжмэл, нэхмэл бүтээгдэхүүний тусгай дүрэм (БТКУС-ийн Бүлэг 50-63-т хамаарах барааны тусгай дүрэм) -ийг зааж өгсөн. ЭЗТХ-ийн 3 дугаар Бүлэгт бас гарал үүслийн дүрэм, түүнийг хэрэгжүүлэхтэй холбоотой олон асуудал тусгагдсан бөгөөд тэдгээрийг гарал үүслийн ерөнхий дүрэм (General Rules of Origin) гэнэ. Харин бүтээгдэхүүний тусгай дүрмийг ЭЗТХ-ийн 2, 3 дугаар хавсралтад БТКУС-ийн ангиллын дагуу задлан зааж өгсөн байгаа.

### **Гаалийн үйл ажиллагаа болон худалдааг хөнгөвчлөх (ЭЗТХ-ийн 4 дүгээр Бүлэг болон Хэрэгжүүлэх хэлэлцээрийн 2 дугаар Бүлэг):**

Гаалийн үйл ажиллагаа болон худалдааг хөнгөвчлөх асуудлын хүрээнд Талууд ЭЗТХ-ээр дараах үүрэг хүлээсэн:

- Гаалийн хууль тогтоомжийн нийтээр дагаж мөрдөх заалт, нэмэлт өөрчлөлтүүд нийтэд ил тод, нээлттэй байх (readily available) явдлыг хангах, мэдээлэл, лавлагааны нэг буюу хэд хэдэн төв (one or more enquiry points) ажиллуулах (ЭЗТХ-ийн 4.3);
- гаалийн үйл ажиллагааг урьдчилан таамаглахуйц, тогтвортой, ил тод байдлаар (in a predictable, consistent and transparent manner) явуулах (ЭЗТХ-ийн 4.4);
- Талуудын хооронд худалдаалсан барааны гаалийн бүрдүүлэлтийг шуурхай хийх үүднээс мэдээлэл, харилцаа холбооны технологийг ашиглах, өөрсдийн гаалийн үйл ажиллагааг хялбарчилах, өөрсдийн гаалийн үйл ажиллагааг аль болох Гаалийн хамтын ажиллагааны зөвлөл (ДГБ)-ийн хүрээнд гаргасан болон бусад олон улсын холбогдох стандарт заалт болон практик зөвлөмжтэй уялдуулах, өөрсдийн гаалийн байгууллага болон төрийн бусад байгууллага, худалдааны нийгэмлэг хоорондын, мөн бусад улсын гаалийн байгууллага хоорондын хамтын ажиллагааг зохистой үед хөхүүлэн дэмжих (ЭЗТХ-ийн 4.4);
- гаалийн асуудлаар аль нэг Талын гаргасан тодорхой нэг шийдвэрийг шүүхийн, эсхүл захиргааны журмаар хянан үзэх ажиллагаанд ашиг сонирхол нь хөндөгдсөн тал оролцоход хялбар дөхөм байх явдлыг хангах, ийнхүү хянан үзэх ажиллагаа тухайн

шийдвэрийн хэрэгжилтийг хариуцсан байгууллагаас хараат бус байхын зэрэгцээ алагчилалгүй, шударга байдлаар (in an impartial and fair manner) явагдах нөхцлийг хангах (ЭЗТХ-ийн 4.4);

- Талуудын хооронд худалдаалсан барааг түр хугацаагаар оруулах (the temporary admission of goods traded between the Parties) болон нөгөө Талаас орж ирсэн, эсхүл нөгөө Тал руу чиглэсэн дамжин өнгөрөх бараа (goods in transit from or to the other Party)-ны гаалийн бүрдүүлэлтийг хууль тогтоомжийнхоо хүрээнд хөнгөвчлөх, энэ үйл ажиллагааг сургалт, семинар зэрэг арга хэмжээ зохион байгуулах замаар дэмжихийг эрмэлзэх (ЭЗТХ-ийн 4.5);
- тарифын ангилал (the Tariff Classification), гаалийн үнэлгээ (the Customs Valuation) болон бараа экспортлогч Талын зохих гарал үүсэлтэй гэж үзэх шаардлагад нийцсэн байдал (the qualification of the good as an originating good of the exporting Party)-ыг бичгээр урьдчилан шийдвэрлэхийг эрмэлзэх (ЭЗТХ-ийн 4.6);
- гаалийн үйл ажиллагааны чиглэлээр, түүний дотор хориглосонбараа худалдаалах болон оюуны өмчийн эрх зөрчигдсөн байх сэжиг бүхий бараа оруулах, гаргах явдалтай тэмцэх асуудлаар хамтран ажиллаж, харилцан мэдээлэл солилцох (ЭЗТХ-ийн 4.7).

Мөн дээрх асуудлын хүрээнд Хэрэгжүүлэх хэлэлцээрт дараах зүйлс тусгагдсан байна:

- гаалийн хууль тогтоомжийг зөв мөрдөх, мөн гаалийн хууль тогтоомжийг зөрчих буюу зөрчихийг завдсан үйлдэл гарахаас урьдчилан сэргийлэх, гаалийн зөрчлийг мөрдөн шалгах, таслан зогсоох явдлыг хангах үүднээс гаалийн байгууллагаар дамжуулан харилцан туслалцаа үзүүлэхийг эрмэлзэх (Хэрэгжүүлэх хэлэлцээрийн 2.1);
- шаардлагатай бол гаалийн байгууллагын шугамаар гаалийн шинэ горим журам, хууль сахиулах шинэ хэрэгсэл болон арга ажиллагаа судлах, боловсруулах болон турших, гаалийн ажилтан бэлтгэх, мөн боловсон хүчин солилцох замаар хамтран ажиллахыг эрмэлзэх (Хэрэгжүүлэх хэлэлцээрийн 2.1);
- гаалийн эрх бүхий байгууллагууд тэдгээрийн гаалийн үйл ажиллагааг

боловсронгуй болгох зорилгоор тэдгээрийн гаалийн үйл ажиллагаанд мэдээлэл, харилцаа холбооны технологи ашиглах, түүний дотор тэргүүн туршлага солилцох явдлыг дэмжих үүднээс хамтын хүчин чармайлт гарган ажиллах (Хэрэгжүүлэх хэлэлцээрийн 2.2);

- Талуудын хооронд худалдаалсан барааны гаалийн бүрдүүлэлтийг хөнгөвчлөх үүднээс Талуудын гаалийн байгууллагууд хяналт шалгалтын үйл ажиллагаагаа өндөр эрсдэлтэй бараанд төвлөрүүлж, бага эрсдэлтэй барааны бүрдүүлэлт болон хөдөлгөөнийг хялбарчлах боломж бүрдүүлэх эрсдэлийн удирдлагын тогтолцоог хэрэгжүүлэх, энэ ажлыг семинар болон сургалт зэрэг арга хэмжээ зохион байгуулах замаар дэмжихийг эрмэлзэх, Талуудын гаалийн байгууллагууд эрсдэлийн удирдлагын арга ажиллагаа болон хууль сахиулах бусад арга ажиллагааны талаар тэргүүн туршлагаасаа солилцох (Хэрэгжүүлэх хэлэлцээрийн 2.3);
- Талуудын гаалийн байгууллагууд барааны хууль бус худалдаатай тэмцэх чиглэлээр хамтран ажиллах, энэ чиглэлээр ДГБ-ын хүрээнд явуулж буй бүс нутгийн хамтын ажиллагааг дэмжихийг эрмэлзэх (Хэрэгжүүлэх хэлэлцээрийн 2.4);
- Талуудын гаалийн байгууллагууд оюуны өмчийн эрхийг зөрчсөн байх сэжиг бүхий барааг оруулах болон гаргахтай тэмцэх чиглэлээр хамтран ажиллахыг эрмэлзэх (Хэрэгжүүлэх хэлэлцээрийн 2.5);
- Үндсэн хэлэлцээрийн 4.7-д заасны дагуу нөгөө Талаас гаргаж өгсөн мэдээллийг гаалийн байгууллага зөвхөн хууль тогтоомжид заасан үүргээ гүйцэтгэх зорилгоор ашиглаж, мэдээллийн нууцыг сахих (Хэрэгжүүлэх хэлэлцээрийн 2.6).

### **Эрүүл ахуй, ургамлын эрүүл ахуйн арга хэмжээ (ЭЗТХ-ийн 5 дугаар Бүлэг):**

ЭЗТХ-т амьтан, ургамлын хорио цээрийн асуудалтай холбогдуулан дараах арга хэмжээ тусгагдсан:

- Талууд ДХБ-ын Эрүүл ахуй, ургамлын эрүүл ахуйн арга хэмжээний тухай Хэлэлцээр (SPS-ийн Хэлэлцээр)-ийн дагуу аль болох өргөн хүрээнд хамтран ажиллах;
- хүн, амьтан, ургамлын амь амьдрал, эрүүл мэндийг хамгаалах явдал SPS-ийн

Хэлэлцээрийн 5 дугаар зүйлийн дагуу тогтоосон түвшинд хүрсэн бол нөгөө Тал түүнийг өөрчлөхийг шаардахгүй байх;

- экспортлогч Талын авч хэрэгжүүлсэн арга хэмжээ импортлогч Талын зохих түвшинд хүрсэн бол импортлогч Тал түүнийг өөрийнхтэйгөө адилтган үзэж, хүлээн зөвшөөрөх;
- мэдээлэл, лавлагааны төв ажиллуулах.

### **Техникийн зохицуулалт, стандарт болон тохирлын үнэлгээний журам (ЭЗТХ-ийн 6 дугаар Бүлэг):**

Худалдаан дахь техникийн саад тотгор (Technical Barriers to Trade - ТВТ)-ыг арилгах талаар ЭЗТХ-т дараах асуудлууд тусгагдсан:

- ДХБ-ын Худалдаан дахь техникийн саад тотгорын тухай хэлэлцээр (ТВТ-ийн Хэлэлцээр)-т тусгагдсан олон улсын стандарт, заавар, зөвлөмжийг өөрийн техникийн зохицуулалт болон тохирлын үнэлгээний журмын (үйл ажиллагааны) үндэс болгон мөрдөж ажиллах;
- үндэсний стандартчиллын байгууллага хоорондын хамтын ажиллагааг хөхүүлэн дэмжих;
- нэг Тал нь нөгөө Талын техникийн зохицуулалттай адил техникийн зохицуулалт боловсруулах сонирхолтой байгаагаар илэрхийлсэн бол нөгөө Тал судалгааны материал, бичиг баримт зэрэг холбогдох бүх мэдээ материалыг боломжоороо гаргаж өгөх;
- Тал бүр өөрийнхөөс нь өөр боловч өөрийнх нь техникийн зохицуулалтын зорилгыг бүрэн хангаж буй нөгөө Талын техникийн зохицуулалтыг өөрийнхтэйгөө адилтган үзэж, хүлээн зөвшөөрөх асуудлыг нааштайгаар авч үзэх;
- Талууд тохирлын үнэлгээний дүгнэлтийг харилцан хүлээн зөвшөөрөх арга хэмжээ авах;
- Талууд боломжтой бол нөгөө Талын тохирлын үнэлгээний байгууллагад өөрийн нутаг дэвсгэрт үйлчилдэг нөхцлөөр итгэмжлэл олгох, мөн тийм нөхцлөөр түүнийг томилон ажиллуулах, эсхүл хүлээн зөвшөөрөх;
- мэдээлэл, лавлагааны төв ажиллуулах.

Худалдааны элдэв саад тотгороос дурдвал:

- төрөөс албан ёсоор үзүүлдэг янз бүрийн дэмжлэг - татаас (Official support (subsidies));
- төрийн байгууллагын худалдан авалтад тавигддаг шаардлагууд (Requirements for Public Procurement);
- валютын хязгаарлалт, хяналт, зохицуулалт (Currency Restrictions);
- оюуны өмчийн эрхийн хамгаалалт (Intellectual property protection);
- тоо хэмжээний хязгаарлалт - импортын квот г.м. (Quantitative restrictions (import quotas) and Others);
- техникийн дүрэм журам, стандартууд болон тохирлын үнэлгээний журмууд (Technical regulations, standards and procedures for conformity assessment);
- татварууд (Taxes);
- гаалийн үйл ажиллагаа (Customs Procedures).

Эдгээр бүх саад тотгор нь “Худалдаан дахь техникийн шинжтэй саад тотгор” (ТВТ - Technical Barriers to Trade) гэдэгт, өөрөөр хэлбэл ЭЗТХ-ийн 6 дугаар бүлэгт хамаарахгүй. ЭЗТХ-ийн 6 дугаар бүлэгт зөвхөн “техникийн дүрэм журам, стандартууд болон тохирлын үнэлгээний журмууд (үйл ажиллагаа)” хамаарна (ДХБ-ын ТВТ-ийн Хэлэлцээрийн тодорхойлолт). Эдгээр нь өөр хоорондоо ялгаатай байх нь олон улсын худалдаанд саад болдог. Эдгээр дүрэм журам нь аюулгүй ажиллагааг хангах, байгаль орчин, эрүүл мэндэд учруулах хор хөнөөлийг багасгах зэрэг хууль ёсны зорилготой боловч тэдгээрийн үйлчлэх нөлөө нь худалдаанд саад болдог.

Харин худалдаан дахь тарифын бус саад тотгор (Non-Tariff Barriers to Trade) гэдэг нь ТВТ-гээс өргөн хүрээтэй асуудал бөгөөд түүнд гарал үүслийн дүрэм, импортын зөвшөөрөл/лиценз, төрийн байгууллагын худалдан авалт зэрэг асуудлууд хамаарна.

### **Үйлчилгээний худалдаа (ЭЗТХ-ийн 7 дугаар Бүлэг болон 4, 5, 6 дугаар хавсралт):**

Үйлчилгээний худалдаа нь ДХБ-ын Үйлчилгээний худалдааны хэлэлцээр байгуулагдсанаас хойш чөлөөт худалдааны сүүлийн үеийн хэлэлцээрүүдэд шинээр тусгагдаж байгаа, эсхүл түүнээс өмнө байгуулагдсан чөлөөт худалдааны хэлэлцүүрүүдэд нэмэлт өөрчлөлт

оруулах замаар шинээр тусгагдаж байгаа бүлгүүдийн нэг юм.

“Үйлчилгээний худалдаа” гэдэгт дараахь зүйлс багтана (ДХБ-ын Үйлчилгээний худалдааны хэлэлцээрийн томъёолол болон жишээг италик шрифтээр оруулав) (ЭЗТХ-ийн 7.2(m)):

- хил дамнасан худалдаа/нийлүүлэлт (cross-border supply mode)(*Mode 1 - Cross Border Trade*):

Жишээ: “А” улс дахь хэрэглэгч цахилгаан холбооны хэрэгсэл, шуудангийн үйлчилгээ ашиглан гадаадаас үйлчилгээ авах, тухайлбал, зөвлөгөө авах, зах зээлийн судалгаа авах, телевизээр эмчилгээний зөвлөгөө авах, зайн сургалтад хамрагдах, уран барилгын схем зураг авах;

- хилийн чанад дахь үйлчилгээ (consumption abroad mode)(*Mode 2 - Consumption abroad*):

Жишээ: “А” улсын иргэд аялахаар, суралцахаар, эсхүл эмчлүүлэхээр гадаад явах;

- арилжааны төлөөлөл (commercial presence mode) (*Mode 3 - Commercial presence*):

Жишээ: “А” улсад байгаа хэрэглэгч нь гадаад этгээдийн эзэмшил (өмчлөл)-д буюу хяналтанд байгаа гадаад дахь компаний “А” улсад байгуулсан салбар байгууллага буюу төлөөлөгчийн газраас үйлчилгээ авах;

- хувь хүний оролцоо (presence of natural persons mode)(*Mode 4 - Presence of natural persons*):

Жишээ: Гадаадын иргэн “А” улсад байгаа зөвлөгөө өгдөг пүүс (*consultancy firms*), эмнэлэг, зам, барилгын компани зэрэгт бие даасан байдлаар үйлчилгээ үзүүлэх.

“Үйлчилгээний худалдаа” гэдэгт ЭЗТХ-ийн хавсралт 4-т тодорхойлсон “санхүүгийн үйлчилгээ” (Financial Services) (үүнд даатгал, давхар даатгал, г.м. үйлчилгээ багтана), мөн хавсралт 5-д тодорхойлсон “цахилгаан холбооны үйлчилгээ” (Telecommunications Services) хамаарна.

“Үйлчилгээ үзүүлэх” гэдэгт үйлдвэрлэх, түгээх, маркетинг хийх, худалдан борлуулах, үйлчилгээ хүргэх үйл ажиллагаа багтана (ЭЗТХ-ийн 7.2(k)).

ЭЗТХ-т зааснаар, Талууд түүний 6 дугаар хавсралтад заасан тусгай үүрэг амлалтын жагсаалтад тусгасан салбар болон түүнд тусгасан аливаа нөхцөл, шаардлагын дагуу үйлчилгээ үзүүлэхэд нөлөөлөхүйц бүх арга хэмжээний хувьд

нөгөө Талын үйлчилгээ, үйлчилгээ үзүүлэгчдэд өөрийн ижил төрлийн үйлчилгээ, үйлчилгээ үзүүлэгчдэд олгосноос дутуугүй тааламжтай нөхцөл буюу үндэсний нөхцөл олгоно (ЭЗТХ-ийн 7.3).

### **Хувь хүний шилжилт хөдөлгөөн (ЭЗТХ-ийн 8 дугаар Бүлэг болон 7 дугаар хавсралт):**

ЭЗТХ-ийн 8 дугаар Бүлэг нь нөгөө Талын дор дурдсан хувь хүн (тухайн улсын иргэн) өөрийн Талын нутаг дэвсгэрт нэвтрэн орох, тэнд түр оршин суух асуудлыг аль нэг Тал хэрхэн зохицуулж буй арга хэмжээнд хамаарна (ЭЗТХ-ийн 8.2.1 болон 8.4.1):

- (a) богино хугацаагаар зорчин ирэх нөгөө Талын бизнес эрхлэгч;
- (b) нэг корпораци (нэг компани) дотроо шилжин ажиллах нөгөө Талын ажилтан;
- (c) нөгөө Талын хөрөнгө оруулагч;
- (d) нөгөө Талын мэргэжлийн үйлчилгээ үзүүлэгч хувь хүн;
- (e) төрийн, эсхүл хувийн байгууллагатай хийсэн гэрээний дагуу ахисан түвшний технологи, эсхүл мэдлэг шаардсан үйлчилгээг тухайн Талд үзүүлдэг нөгөө Талын хувь хүн;
- (f) дээрх хүмүүсийг дагалдан яваа эхнэр, нөхөр, хүүхэд.

ЭЗТХ-ийн 8 дугаар Бүлгийн заалттай үл зөрчилдөх цагаачлалын хууль дүрмийг дээрх хүмүүс сахиж мөрдөх тохиолдолд, Талууд тэдэнд хилээр нэвтрэх, түр оршин суух зөвшөөрлийг ЭЗТХ-ийн 7 дугаар хавсралтад заасан нөхцөл, болзлын дагуу, хүний тоог үл харгалзан олгоно (ЭЗТХ-ийн 8.4.2 болон 8.4.3).

ЭЗТХ-ийн 8 дугаар Бүлэг нь нөгөө Талын хөдөлмөрийн зах зээлд нэвтрэх боломж хайж буй аль нэг Талын хувь хүний асуудлыг зохицуулсан арга хэмжээ, түүнчлэн иргэншил хүсэх, эсхүл байнга оршин суух буюу байнгын хөдөлмөр эрхлэх асуудлыг зохицуулсан арга хэмжээнд хамаарахгүй (ЭЗТХ-ийн 8.2.2).

Талууд тэдгээрийн нутаг дэвсгэртнөгөө Талын дээр дурдсан хүмүүс нэвтрэн орох, тэнд анх удаа түр оршин суух, түр оршин суух зөвшөөрлөө шинэчлэх, зохистой тохиолдолд хөдөлмөр эрхлэх зөвшөөрөл хүсэх, түр оршин суух статусаа өөрчлөхөд тавигдах шаардлага, мөрдөх дүрэм журмаа ЭЗТХ хүчин төгөлдөр болсон өдөр нөгөө Талдаа нээлттэй болгож, шинэ дүрэм журам, нэмэлт өөрчлөлтийн талаар нөгөө Талдаа нэн



даруй мэдэгдэх, мөн дээрх хүмүүсийн хүсэлтээр тэдэнд холбогдох мэдээлэл өгөх, дээрх дүрэм, журмаа хялбарчлахыг эрмэлзэнэ (ЭЗТХ-ийн 8.5). Хураамжийн хэмжээ нь дээрх иргэд холбогдох Талын нутаг дэвсгэрт ЭЗТХ-ийн 8 дугаар Бүлгийн дагуу нэвтрэн орох, тэнд түр оршин суухад саад болохооргүй байна (ЭЗТХ-ийн 8.5.4).

### **Цахим худалдаа (ЭЗТХ-ийн 9 дүгээр Бүлэг):**

ЭЗТХ-ийн 9 дүгээр Бүлгийн зорилго нь цахим худалдааг ашиглахад найдвартайболон итгэлтэй орчин (trust and confidence in the use of electronic commerce) бий болгох, мөн Талуудын хооронд цахим худалдаа хийх болон цахим худалдааг дэлхий дахинд өргөнөөр ашиглах явдалд дэмжлэг үзүүлэхэд оршино (ЭЗТХ-ийн 9.1.2).

Энэ Бүлэгт “тоон бүтээгдэхүүн”, “цахим гэрчилгээ”, “цахим гарын үсэг” гэсэн нэр томъёог уг Бүлгийн зорилгоор тодогтон тодорхойлж, холбогдох зохицуулалтыг тусгасан. “Тоон бүтээгдэхүүн” гэдэг нь “тээгч хэрэгсэлд суулгасан, эсхүл цахим хэлбэрээр дамжуулсан эсэхээс үл хамааран, тоон хувиргалт хийгдсэн компьютерийн програм хангамж, текст, дүрс бичлэг, зураг, дуу бичлэг болон бусад бүтээгдэхүүн” болно (ЭЗТХ-ийн 9.2).

Талууд цахим худалдаанд технологиос үл хамаарах зарчим (the principle of technological neutrality) мөрдөнө.

ЭЗТХ-т Талуудын хоорондын цахим дамжуулалт (electronic transmissions between the Parties)-д гаалийн татвар ногдуулдахгүй байхаар заасан (ЭЗТХ-ийн 9.3).

ЭЗТХ-ийн 9 дүгээр Бүлэгт дээр дурдсанаас гадна нөгөө Талын тоон бүтээгдэхүүнийг (өөрийн Талын болон гуравдагч Талын тоон бүтээгдэхүүнээс) үл ялгаварлах нөхцөл (Non-Discriminatory Treatment of Digital Products - ЭЗТХ-ийн 9.4), хэрэглэгчийг хамгаалах (Consumer Protection - ЭЗТХ-ийн 9.6), сурталчилгааны зорилготой худалдааны сайн дурын цахим шуудан (Unsolicited Commercial E-mail - ЭЗТХ-ийн 9.7)-г зохицуулахыг эрмэлзэх, цаасгүй худалдаа удирдан явуулах (Paperless Trade Administration - ЭЗТХ-ийн 9.8), тодруулбал, Талууд цахим хэлбэрээр илгээсэн худалдааны мэдээлэл хөтлөх бичиг баримт (trade administration documents)-ыг эрх зүйн хувьд тийм бичиг баримтын цаасан хувилбартай адил хүчин чадалтай гэж хүлээн зөвшөөрөхийг эрмэлзэх, аль нэг Тал зөвхөн өөрийн Талын нутаг дэвсгэр дэх тооцооллын хэрэгсэл ашиглахыг, эсхүл нөгөө Талын тооцооллын хэрэгслийг өөрийн Талын нутаг дэвсгэрт байршуулахыг үйлчилгээ үзүүлэх,

эсхүл хөрөнгө оруулах болзол нөхцөл болгон шаардахгүй байх (Тооцооллын хэрэгслийн байршилд хамаарах шаардлагад хориглох зүйл-Prohibition on Requirement concerning the Location of Computing Facilities - ЭЗТХ-ийн 9.10), онц чухал дэд бүтцийн зориулалттай програм хангамж (software used for critical infrastructure)-аас өөр бусад нийтийн хэрэглээний програм хангамж, эсхүл тийм програм хангамж агуулсан бүтээгдэхүүн (mass-market software or products containing such software)-ий эх код (Source Code)-ыг тэдгээрийг өөрийн нутаг дэвсгэрт оруулах, түгээх, борлуулах, эсхүл ашиглах нөхцөл болгон шилжүүлэн өгөх, эсхүл түүнд нэвтрэх шаардлага тавихгүй байх (ЭЗТХ-ийн 9.11), мөн хамтын ажиллагаа (ЭЗТХ-ийн 9.12) гэсэн заалтууд тусгагдсан.

### **Хөрөнгө оруулалт (ЭЗТХ-ийн 10 дугаар Бүлэг болон 8, 9, 10 дугаар хавсралт):**

ЭЗТХ-ийн Хөрөнгө оруулалтын Бүлэг нь аль нэг Талаас дараах зүйлийг зохицуулж буй арга хэмжээнд хамаарна:

- нөгөө Талын хөрөнгө оруулагч;
- нөгөө Талын хөрөнгө оруулагчаас өөрийн Талд оруулж буй хөрөнгө оруулалт;
- 10.7 болон 10.17 дугаар зүйлийн хувьд аль нэг Талын нутагдэвсгэр дэх бүх (улсын) хөрөнгө оруулалт.

Талууд нөгөө Талын хөрөнгө оруулагчболон нөгөө Талын хөрөнгө оруулагчаас өөрийн Талд оруулж буй хөрөнгө оруулалтад үндэсний нөхцөл олгоно (ЭЗТХ-ийн 10.3). Мөн нөгөө Талын хөрөнгө оруулагчаас өөрийн Талд оруулж буй хөрөнгө оруулалтад нэн тааламжтай нөхцөл олгоно (ЭЗТХ-ийн 10.4).

ЭЗТХ-ийн 10 дугаар Бүлэгт дээр дурдсанаас гадна дараах зүйлс тусгагдсан:

- ерөнхий нөхцөл (General Treatment): Талууд нөгөө Талын хөрөнгө оруулагчаас өөрийн Талд оруулж буй хөрөнгө оруулалтын хувьд олон улсын эрх зүйд нийцсэн нөхцөл, түүний дотор шударга, эрх тэгш хандах нөхцөл (fair and equitable treatment), мөн бүрэн хамгаалалт болон аюулгүй байдлын нөхцөл (full protection and security)-ийг олгоно (ЭЗТХ-ийн 10.5);
- шүүхэд хандах боломж (Access to the Courts) (ЭЗТХ-ийн 10.6);
- үйл ажиллагааны шаардлагад тавигдах хориг (Prohibition of Performance Requirements) (ЭЗТХ-ийн 10.7);
- үл нийцэх арга хэмжээ (Non-Conforming

Measures) (ЭЗТХ-ийн 10.8);

- албадан хураах болон нөхөн төлбөр олгох (Expropriation and Compensation) (ЭЗТХ-ийн 10.9);
- зэвсэгт мөргөлдөөн, хувьсгал, бослого, иргэний үймээн самуун дэгдвэл нөгөө Талын хөрөнгө оруулагчаас оруулсан хөрөнгө оруулалтыг өөрийн болон гуравдагч Талынхтай адил авч үзэх (Мөргөлдөөнөөс хамгаалах - Protection from Strife) (ЭЗТХ-ийн 10.10);
- ашиг, орлого, хөдөлмөрийн хөлс зэргийг гадагш гуйвуулах/шилжүүлэх (Transfers) (ЭЗТХ-ийн 10.11);
- хохирол барагдуулах үүрэг амлалт (indemnity), баталгаа (guarantee), даатгалын гэрээ (insurance contract) г.м. баримт бичгийн дагуу хөрөнгө оруулагчид нөхөн төлбөр олгогдсон бол уг төлбөрийг гэм буруутай этгээдээс нэхэмжлэх эрх шилжих (Даатгагдсан төлөөлөл - Subrogation) (ЭЗТХ-ийн 10.12);
- аль нэг Тал болон нөгөө Талын хөрөнгө оруулагч хоорондын хөрөнгө оруулалтын маргааныг шийдвэрлэх (Settlement of Investment Disputes between a Party and an Investor of the Other Party) (ЭЗТХ-ийн 10.13);
- хамгаалалтын түр арга хэмжээ (Temporary Safeguard Measures) (ЭЗТХ-ийн 10.14);
- урьдчилан сэргийлэх арга хэмжээ (Prudential Measures) (ЭЗТХ-ийн 10.15);
- ашгаас татгалзах (Denial of Benefits) (ЭЗТХ-ийн 10.16);
- эрүүл мэнд, аюулгүй байдал, хүрээлэн буй орчны арга хэмжээ болон хөдөлмөрийн стандарт (Health, Safety and Environmental Measures and Labor Standards)-ыг сулруулах замаар хөрөнгө оруулалтыг хөхиүлэн дэмжих явдлаас зайлсхийх (ЭЗТХ-ийн 10.17).

ЭЗТХ хүчин төгөлдөр болсноор 2001 оны 2 дугаар сарын 15-ны өдөр Токио хотод гарын үсэг зурсан “Монгол Улс, Япон Улс хоорондын хөрөнгө оруулалтыг хөхиүлэн дэмжих, харилцан хамгаалах тухай хэлэлцээр” цуцлагдана. Харин түүний 17 дугаар зүйлийн 3 дугаар хэсэгт заасны дагуу уг хоёр талт хөрөнгө оруулалтын хэлэлцээр цуцлагдах өдрөөс өмнөх хөрөнгө оруулалт болон олсон ашгийн хувьд уг хэлэлцээрийн 1-16 дугаар зүйл 15 жилийн хугацаанд хэвээр мөрдөгдөнө (ЭЗТХ-ийн 10.19).

ЭЗТХ цуцлагдвал, түүнээс өмнө хийсэн хөрөнгө оруулалтын хувьд ЭЗТХ-ийн 10 дугаар Бүлгийн заалтууд болон уг Бүлэгтэй шууд холбоотой бусад заалтууд тийнхүү цуцлагдсанаас хойш 10 жилийн хугацаанд хүчинтэй байна (ЭЗТХ-ийн 10.20).

### **Өрсөлдөөн (ЭЗТХ-ийн 11 дүгээр Бүлэг болон Хэрэгжүүлэх хэлэлцээрийн 3 дугаар Бүлэг):**

ЭЗТХ болон Хэрэгжүүлэх хэлэлцээрт дараах зүйлс тусгагдсан:

- Талууд өөр хоорондын худалдаа, хөрөнгө оруулалтын урсгалыг хөнгөвчлөх зорилгоор өрсөлдөөний эсрэг үйлажиллагаа (энэ нь Талуудын өрсөлдөөний хууль тогтоомжийн дагуу торгууль ногдуулах, эсхүл хөнгөлөлт үзүүлэх аливаа үйлдэл буюухэлцэл болно)-ны эсрэг (against anticompetitive activities) зохистой арга хэмжээ авах (ЭЗТХ-ийн 11.1 болон 11.2);
- өрсөлдөөний эсрэг үйл ажиллагаанд хяналт тавих зорилгоор Талууд хоорондоо хамтран ажиллаж, харилцан туслах (ЭЗТХ-ийн 11.2);
- Талууд өрсөлдөөний тухай өөрсдийн хууль тогтоомжийг хэрэгжүүлэхдээ ижил нөхцөл байдалд байгаа этгээдүүдийг харьяаллаар нь ялгаварлахгүй байх (ЭЗТХ-ийн 11.3);
- Талууд өрсөлдөөний эсрэгүйл ажиллагааг хянах үүднээс захиргааны болон шүүхийн шүүн таслах үйл ажиллагааг өөрсдийн холбогдох хууль тогтоомжийн дагуу шударгаар явуулах (ЭЗТХ-ийн 11.4);
- Талууд өөрсдийн өрсөлдөөний хууль тогтоомж болон өрсөлдөөний бодлогын хэрэгжилтийг ил тод байлгах явдлыг эрхэмлэн (дэмжин) ажиллах (ЭЗТХ-ийн 11.5);
- Талуудын эрх бүхий байгууллагууд (Монгол Улсын хувьд - Шударга өрсөлдөөн, хэрэглэгчийн төлөө газар, Япон Улсын хувьд - Шударга худалдааны комисс) өөрсдийн өрсөлдөөний хууль тогтоомжийн дагуу явуулж буй бөгөөд нөгөө Талын үндсэн ашиг сонирхол (язгуур эрх ашиг)-ыг хөндөж болзошгүй хууль сахиулах үйл ажиллагаа (enforcement activities)-ны талаар харилцан мэдээлэх (Хэрэгжүүлэх хэлэлцээрийн 3.3);
- Талуудын эрх бүхий байгууллагууд нөгөө Талд хууль сахиулах үйл ажиллагаа явуулахад өөрсдийн хууль тогтоомж,

үндсэн ашиг сонирхол (язгуур эрх ашиг)-ыг зөрчилгүйгээр, өөрсдийн нөөц бололцооны хүрээнд харилцан туслах, харилцан мэдээлэл солилцох, хууль сахиулах үйл ажиллагаагаа харилцан уялдуулж явуулах (Хэрэгжүүлэх хэлэлцээрийн 3.4 - 3.6);

- аль нэг Талд хэрэгжүүлж буй өрсөлдөөний эсрэг үйл ажиллагаа нөгөө Талын эрх ашигт сөргөөр нөлөөлөх тохиолдолд эвдрэлцэх (сөргөлдөх, маргаан гарах)-ээс зайлсхийхийг эрхэмлэн, Талууд болон/эсхүл түүний эрх бүхий байгууллагууд энэ чиглэлээр хамтран ажиллах (Хэрэгжүүлэх хэлэлцээрийн 3.7 болон 3.8);
- Талууд өрсөлдөөний бодлогоо бататгах (чангатгах), өрсөлдөөний хууль тогтоомжийн хэрэгжилтээ сайжруулах зорилгоор техникийн туслалцаа үзүүлэх хэлбэрээр хамтран ажиллах (Хэрэгжүүлэх хэлэлцээрийн 3.9);
- Талуудын эрх бүхий байгууллагууд өрсөлдөөний хууль тогтоомж, түүнд оруулсан нэмэлт өөрчлөлт, өрсөлдөөний бодлогын чиглэл, бодлогын тунхаглал, жил бүрийн тайлан мэдээ, нийтэд тараасан өөр бусад хэвлэмэл материалыг нөгөө Талын эрх бүхий байгууллагад гаргаж өгөх (Хэрэгжүүлэх хэлэлцээрийн 3.10), аливаа асуудлаар зөвлөлдөх (Хэрэгжүүлэх хэлэлцээрийн 3.11);
- нөгөө Талын гаргаж өгсөн мэдээллийн нууцыг хадгалах, дипломат шугамаар, эсхүл хууль тогтоомжид заасан өөр бусад шугамаар харилцан тохиролцоогүй тохиолдолд уг мэдээллийг эрүүгийн хэргийн шүүн таслах үйл ажилагаанд ашиглахгүй байх (Хэрэгжүүлэх хэлэлцээрийн 3.12 болон 3.13).

### **Оюуны өмч (ЭЗТХ-ийн 12 дугаар Бүлэг):**

ЭЗТХ-т оюуны өмчийн эрхийн хамгаалах, оюуны өмчийн эрхийн зөрчилтэй тэмцэх талаар дараах зүйлс тусгагдав:

- ЭЗТХ-ийн 12 дугаар Бүлэгт дурдсан “оюуны өмч” гэх нэр томъёонд ДХБ-ын Худалдаанд хамаарах оюуны өмчийн эрхийн тухай хэлэлцээр (TRIPS-ийн хэлэлцээр)-т заасан оюуны өмчийн бүх төрлийг ойлгох (ЭЗТХ-ийн 12.2);
- Талууд ЭЗТХ-ийн 12-р Бүлэг болон хоёр Талын нэгдэн орсон оюуны өмчид хамаарах олон улсын хэлэлцээрийн дагуу

оюуны өмчийн зохистой, үр дүнтэй болон үл ялгаварласан хамгаалалт (adequate, effective and non-discriminatory protection of intellectual property) олгож, оюуны өмчийн эрхийн зөрчил (infringement of intellectual property rights)-тэй тэмцэх арга хэмжээ авч хэрэгжүүлэх (ЭЗТХ-ийн 12.1.1);

- Талууд оюуны өмчийн тогтолцооны удирдлагын үр ашиг болон илтөд байдал (efficiency and transparency in the administration of intellectual property system)-ыг хөхүүлэн дэмжих (ЭЗТХ-ийн 12.1.2);
- оюуны өмчийн хамгаалалт (үүнд оюуны өмчийн эрхийг хүртээмжтэй байлгах, олж авах, хүчинтэй байлгах, хэрэгжилтийг нь хангах, түүний хүрээ болон ЭЗТХ-ийн 12 дугаар Бүлэгт тусгайлан заасан оюуны өмч (патент - Patents, бүтээгдэхүүний загвар - Industrial Designs, барааны тэмдэг - Trademark, зохиогчийн эрх ба түүнд хамаарах эрх - Copyright and Related Rights, газар зүйн заалт - Geographic Indications)-ийн эрхийг ашиглахад нөлөөлөх асуудлууд, мөн ЭЗТХ-ийн 12.12-т заасан шударга бус өрсөлдөөн (Unfair Competition)-ийг хориглох асуудал хамаарна)-ын хувьд үндэсний нөхцөл олгох (ЭЗТХ-ийн 12.3, 12.7-12.12);
- Тал бүр оюуны өмчийн эрхэд хамаарах захиргааны журам болон патентын зуучлагч (patent attorney), эсхүл бүртгэгдсэн оюуны өмчийн нитгэмжлэгдсэн төлөөлөгчийн тогтолцоо (registered intellectual property rights authorized representative system)-г боловсронгуй болгох, барааны тэмдэг, бүтээгдэхүүний загвар, патентын бүртгэлийн тогтолцоотой байх арга хэмжээ авах (ЭЗТХ-ийн 12.4.1, 12.4.5, 12.4.7);
- Талууд оюуны өмчийг ашиглах болон оюуны өмчийн эрхийг хэрэгжүүлэх талаар боловсролын болон мэдээлэл түгээх төсөл хэрэгжүүлэх зэргээр оюуны өмчийг хамгаалах тухай олон нийтийн мэдлэгийн түвинг дээшлүүлэхэд чиглэсэн шаардлагатай арга хэмжээ авах (ЭЗТХ-ийн 12.6);
- хаалттай мэдээллийг хамгаалах (Protection of Undisclosed Information) (ЭЗТХ-ийн 12.13);
- хууль сахиулах ажиллагаа - хилийн хяналтын арга хэмжээ (Enforcement - Border Measures): Тал бүр импортын ачилтын

хувьд гаалийн байгууллага нь өөрийн санаачилгаар, эсхүл эрх эзэмшигч (a right holder)-ээс эрх бүхий байгууллагад гаргасан хүсэлтийг үндэслэн сэжигтэй бараа (барааны тэмдэг болон/эсхүл зохиогчийн эрх ба түүнд хамаарах эрхийн зөрчилтэй байж болзошгүй бараа)-г эзэнд нь олгохоос түр татгалзаж (тийм импортын барааг саатуулж) болох журам тогтоох, мөн эрх бүхий байгууллага уг сэжигтэй барааны хувьд барааны тэмдэг болон/эсхүлзохиогчийн эрх болон түүнд хамаарах эрх зөрчигдсөн эсэхийг нэн даруй тогтоож болох журам гаргах, сэжигтэй барааг саатуулсан тохиолдолд энэ тухай импортлогч болон эрх эзэмшигчид нэн даруй мэдэгдэж, тэдэнд сэжигтэй барааны талаарх бүх мэдээллийг өгөх (ЭЗТХ-ийн 12.14);

- хууль сахиулах ажиллагаа - иргэний шүүхийн арга хэрэгсэл (Enforcement - Civil Remedies): эрх эзэмшигч өөрт учирсан хохирлоо нөхөн төлүүлэх үүднээс эрх зөрчигчийн эсрэг нэхэмжлэл гаргах эрхтэй байх (ЭЗТХ-ийн 12.15);
- хууль сахиулах ажиллагаа - эрүүгийн шүүхийн арга хэрэгсэл (Enforcement - Civil Remedies): барааны тэмдгийг хууль бусаар ашиглан, хуурамчбараагарилжааны тоо хэмжээгээр үйлдвэрлэсэн, эсхүл зохиогчийн эрх зөрчсөн хэргийг санаатайгаар үйлдсэн тохиолдолд Худалдаанд хамаарах оюуны өмчийн эрхийн тухай хэлэлцээрийн 61 дүгээр зүйлийн дагуу эрүүгийн хэргийн шүүн таслах үйл ажиллагаа явуулах болон торгууль ногдуулах, мөн эрх бүхий байгууллага нь зөрчилтэй барааг хураан авах, эсхүл устгах эрхтэй байх (ЭЗТХ-ийн 12.16);
- хууль сахиулах ажиллагаа - тоон системийн орчинд (Enforcement - In the Digital Environment): Талуудаас хэрэгжүүлж буй хууль сахиулах ажиллагаа нь тоон системийн сүлжээ (digital networks) ашиглан зохиогчийн эрх буюу түүнд хамаарах эрх зөрчсөн үйлдэлд хамаарна. Энэ тохиолдолд хууль сахиулах ажиллагааг цахим худалдаа зэрэг хууль ёсны үйл ажиллагаанд саад болохооргүй, тухайн Талын хууль тогтоомжид нийцсэн, өөрийгөө илэрхийлэх эрх чөлөө, шударга ёс болон хувийн нууцыг хамгаалах зэрэг суурь зарчмыг хадгалсан байдлаар хэрэгжүүлнэ. Тоон системийн сүлжээ гэдэгт

олон нийтийн мэдээллийн хэрэгсэл (means of widespread distribution) багтана (ЭЗТХ-ийн 12.17);

- ЭЗТХ-ийн 12 дугаар Бүлгийн зорилгоор, аюулгүй байдлыг хамгаалах үүднээс Худалдаанд хамаарах оюуны өмчийн эрхийн тухай хэлэлцээрийн 73 дугаар зүйлийг хэвээр нь мөрдөх.

### **Засгийн газрын худалдан авах ажиллагаа (ЭЗТХ-ийн 13 дугаар Бүлэг):**

Монгол Улс Засгийн газрын худалдан авах ажиллагааны тухай ДХБ-ын хэлэлцээрийн Хэлэлцэн тохирогч Тал биш учир эл асуудлаар ЭЗТХ-т нарийвчилсан зүйл заалт тусгагдаагүй байна. Гэвч ЭЗТХ-т зааснаар Талууд Засгийн газрын худалдан авах ажиллагаатай холбоотой арга хэмжээний ил тод байдлыг өөрсдийн хууль тогтоомжийн дагуу хангаж, уг арга хэмжээг шударга, үр дүнтэй хэрэгжүүлэх нөхцлийг бүрдүүлэн, Засгийн газрын худалдан авах ажиллагааны хууль тогтоомж, бодлого, туршлага, мөн түүнчлэн одоо мөрдөж буй Засгийн газрын худалдан авах ажиллагааны тогтолцоонд хийх аливаа шинэчлэлт өөрчлөлтийн талаар Засгийн газрын түвшинд мэдээлэл солилцохоор болжээ (ЭЗТХ-ийн 13.1 болон 13.2).

ЭЗТХ-т Монгол Улс Засгийн газрын худалдан авах ажиллагааны тухай ДХБ-ын хэлэлцээрт нэгдэн орох хүсэлтээ илэрхийлсний дараа ЭЗТХ-ийн 13 дугаар Бүлгийг дахин хэлэлцэхээр заасан байна (ЭЗТХ-ийн 13.3). Тийм хэлэлцээ явуулахдаа нөгөө Тал болон гуравдагч Талыг үл ялгаварлах, харилцан адил байх зарчим баримтална (ЭЗТХ-ийн 13.4).

### **Бизнесийн орчныг сайжруулах (ЭЗТХ-ийн 14 дүгээр Бүлэг болон Хэрэгжүүлэх хэлэлцээрийн 4 дүгээр Бүлэг):**

ЭЗТХ-т Талууд өөрийн Талд бизнесийн үйл ажиллагаа явуулж байгаа нөгөө Талын этгээдэд зориулан бизнесийн орчноо өөрсдийн хууль тогтоомжийн дагуу илүү сайжруулах арга хэмжээ авч, хамтран ажиллахаар заасан байна (ЭЗТХ-ийн 14.1).

Хэрэгжүүлэх хэлэлцээрийн 4 дүгээр Бүлэгт Бизнесийн орчныг сайжруулах дэд хороогоор хэлэлцэж болох асуудал, мөн Талуудын өөрийн Талд байгуулах Холбоо тогтоох байгууллага (Liaison Office)-ын гүйцэтгэх үүргийг заасан байна. Талууд бас өөрийн Талын үйлдвэрийн газрыг нөгөө Талын Холбоо тогтоох байгууллагатай холбох үүрэг бүхий нэгжийг нөгөө Талд байгуулан ажиллуулж болох юм байна.

**В. ГААЛИЙН ХОЛБОГДОЛТОЙ  
БУСАД ГЭРЭЭ**

OTHER CUSTOMS RELATED TREATIES

ДРУГИЕ МЕЖДУНАРОДНЫЕ ДОГОВОРЫ



# IX БҮЛЭГ

ГААЛИЙН ХОЛБОГДОЛТОЙ ХОЁР ТАЛТ  
ГЭРЭЭНИЙ ЖАГСААЛТ

№	Утга	Гэрээ байгуулсан монголын талын этгээд	Гэрээ байгуулсан хот	Гэрээ байгуулсан огноо	Нэмэлт өөрчлөлт орсон байдал
<b>I. Гаалийн хүрээнд хамтран ажиллах, харилцан туслах тухай асуудлаар</b>					
1.	Гаалийн асуудлаар хамтран ажиллах тухай Монгол Улсын Засгийн газар, ОХУ-ын Засгийн газар хоорондын Хэлэлцээр	Г.Сэсээр (ГЕГ-ын дарга)	Москва	1993-01-20	
2.	Гаалийн асуудлаар хамтран ажиллах, харилцан туслах тухай Монгол Улсын Засгийн газар, БНХАУ-ын Засгийн газар хоорондын Хэлэлцээр	Г.Сэсээр (ГЕГ-ын дарга)	Улаанбаатар	1993-09-07	
3.	Гаалийн асуудлаар хамтран ажиллах, харилцан туслах тухай Монгол Улсын Засгийн газар, БН Солонгос Улсын Засгийн газар хоорондын Хэлэлцээр	Г.Сэсээр (ГЕГ-ын дарга)	Улаанбаатар	1993-07-28	
4.	Гаалийн асуудлаар хамтран ажиллах, харилцан туслах тухай Монгол Улсын Засгийн газар, БН Унгар Улсын Засгийн газар хоорондын Хэлэлцээр	Б.Шаравсамбуу (ГЕГ-ын дарга)	Будапешт	1995-09-22	Энэ Хэлэлцээрт нэмэлт өөрчлөлт оруулах тухай Хэлэлцээр 2010-1-13, Улаанбаатар
5.	Гаалийн асуудлаар хамтран ажиллах, харилцан туслах тухай Монгол Улсын Засгийн газар, АНУ-ын Засгийн газар хоорондын Хэлэлцээр	Б.Шаравсамбуу (ГЕГ-ын дарга)	Хонконг	1996-06-19	
6.	Гаалийн асуудлаар хамтран ажиллах, харилцан туслах тухай Монгол Улсын Засгийн газар, БН Польш Улсын Засгийн газар хоорондын Хэлэлцээр	Д.Цэнд (ГЕГ-ын дарга)	Улаанбаатар	1997-05-13	
7.	Гаалийн байгууллага хооронд захиргааны шугамаар харилцан туслах тухай Монгол Улсын Засгийн газар, Их Британи ба Умард Ирландын Нэгдсэн Вант Улсын Засгийн газар хоорондын харилцан ойлголцлын Меморандум	Ц.Сүхбаатар (Монгол Улсаас ИБУИНВУ-д суугаа онц бөгөөд бүрэн эрхт элчин сайд)	Лондон	1998-01-20	
8.	Гаалийн асуудлаар хамтран ажиллах, харилцан туслах тухай Монгол Улсын Засгийн газар, БН Казахстан Улсын Засгийн газар хоорондын Хэлэлцээр	З.Мөнхбат (ГЕГ-ын дарга)	Алма-Ата	1998-03-12	
9.	Гаалийн асуудлаар хамтран ажиллах, харилцан туслах тухай Монгол Улсын Засгийн газар, БН Чех Улсын Засгийн газар хоорондын Хэлэлцээр	З.Мөнхбат (ГЕГ-ын дарга)	Прага	1998-11-13	
10.	Гаалийн асуудлаар хамтран ажиллах, харилцан туслах тухай Монгол Улсын Засгийн газар, БН Болгар Улсын Засгийн газар хоорондын Хэлэлцээр	Т.Лхагваа (ГЕГ-ын дарга)	Софи	1999-05-20	
11.	Гаалийн асуудлаар хамтран ажиллах, харилцан туслах тухай Монгол Улсын Засгийн газар, БН Турк Улсын Засгийн газар хоорондын Хэлэлцээр	Т.Лхагваа (ГЕГ-ын дарга)	Улаанбаатар	1999-09-28	



№	Утга	Гэрээ байгуулсан монголын талын этгээд	Гэрээ байгуулсан хот	Гэрээ байгуулсан огноо	Нэмэлт өөрчлөлт орсон байдал
12.	Гаалийн асуудлаар хамтран ажиллах, харилцан туслах тухай Монгол Улсын Засгийн газар, БНС Вьетнам Улсын Засгийн газар хоорондын Хэлэлцээр	Х.Баатар (ГЕГ-ын дарга)	Ханой	2002-10-03	
13.	Гаалийн асуудлаар хамтран ажиллах, харилцан туслах тухай Монгол Улсын Засгийн газар, БН Украин Улсын Засгийн газар хоорондын Хэлэлцээр	Х.Баатар (ГЕГ-ын дарга)	Улаанбаатар	2002-10-10	
14.	Гаалийн асуудлаар хамтран ажиллах, харилцан туслах тухай Монгол Улсын Засгийн газар, БН Кыргыз Улсын Засгийн газар хоорондын Хэлэлцээр	Х.Баатар (ГЕГ-ын дарга)	Бишкек	2004-03-01	
15.	Гаалийн асуудлаар хамтран ажиллах, харилцан туслах тухай Монгол Улсын Засгийн газар, БН Энэтхэг Улсын Засгийн газар хоорондын Хэлэлцээр	Д.Цэвээнжав (ГЕГ-ын дарга)	Улаанбаатар	2012-04-13	
16.	Гаалийн асуудлаар хамтран ажиллах, харилцан туслах тухай Монгол Улсын Засгийн газар, БН Беларусь Улсын Засгийн газар хоорондын хэлэлцээр	С.Пүрэв (Сангийн сайд) О.Ганбат (ГЕГ-ын дарга)	Улаанбаатар	2013-09-04	
<b>II. Хил, хилийн боомтын асуудлаар</b>					
17.	Хилийн боомт болон Монгол-Оросын улсын хилийг хялбарчилсан журмаар нэвтрэх тухай Монгол Улсын Засгийн газар, ОХУ-ын Засгийн газар хоорондын Хэлэлцээр	ОХУ	Улаанбаатар	1994-08-10	
18.	Монгол, Хятадын хилийн боомт, тэдгээрийн дэглэмийн тухай Монгол Улсын засгийн газар, БНХАУ-ын Засгийн газар хоорондын Хэлэлцээр	БНХАУ	Бээжин	2004-07-05	
19.	Монгол-Оросын улсын хилийн дэглэмийн тухай Монгол Улс, ОХУ хоорондын гэрээ	ОХУ	Москва	2006-12-08	
20.	Монгол, Хятадын хилийн дэглэмийн тухай Монгол Улсын засгийн газар, БНХАУ-ын Засгийн газар хоорондын гэрээ	БНХАУ	Улаанбаатар	2010-06-01	
<b>III. Бусад асуудлаар</b>					
21.	БНМАУ, БНХАУ-ын хоорондын консулын Конвенц	БНХАУ	Улаанбаатар	1986-08-09	
22.	Монгол Улс, ОХУ-ын нутгаар дамжин тээвэр хийж, далайд гарах тухай Монгол Улсын Засгийн газар, ОХУ-ын Засгийн газар хоорондын Хэлэлцээр	ОХУ	Москва	1992-10-19	



# Х БҮЛЭГ

ГААЛИЙН ХОЛБОГДОЛТОЙ ГУРВАН ТАЛТ ГЭРЭЭ

Энэ хэсэгт дурдсан гурван талт хамтын ажиллагааны хүрээнд гаалийн байгууллага хооронд байгуулагдсан гэрээ (хэлэлцээр) нь Олон улсын гэрээний тухай Монгол Улсын 2016 оны хуулийн 4.2-т зааснаар байгууллага хоорондын гэрээ (өөрөөр хэлбэл, Монгол Улсын олон улсын гэрээ биш) болно.

## 2015 ОН

**I.** Монгол Улсын Ерөнхийлөгч Ц.Элбэгдоржийн санаачилгаар Шанхайн хамтын ажиллагааны байгууллага (ШХАБ)-ын форумын үеэр Тажикистан Улсын нийслэл Душанбе хотноо Монгол Улс, ОХУ, БНХАУ-ын төрийн тэргүүн нарын анхны уулзалт 2014 оны 9 дүгээр сарын 12-ны өдөр зохион байгуулагдсан.

Тус уулзалтаар Монгол Улсын Ерөнхийлөгч Ц.Элбэгдоржийн санаачилсан “Талын зам” төсөл (одоо “Хөгжлийн зам” төсөл гэгдэх болсон), ОХУ-ын Ерөнхийлөгч В.В.Путины “Евразийн эдийн засгийн холбоо” байгуулах санал, БНХАУ-ын дарга Си Зинь Пиний дэвшүүлсэн “Нэг бүс-нэг зам” санаачилгыг хэрэгжүүлэх хүрээнд монгол-хятад-оросын гаалийн болон хилийн бүтээн байгуулалтын байгууллагуудын хооронд гурван талт хамтын ажиллагааны баримт бичиг байгуулахыг хөрш орнуудын гаалийн байгууллагуудад хандан уриалсан билээ. Энэхүү санаачилгыг 2015 оны 3-р сард Бээжин хотноо болсон Монгол, Орос, Хятадын Гадаад Хэргийн дэд сайд нарын уулзалтын үеэр сайшаан дэмжиж, төрийн холбогдох байгууллагуудад баримт бичиг боловсруулж гарын үсэг зурахад бэлэн болгохыг даалгасан. Энэ шийдвэрийг хэрэгжүүлэх зорилгоор гаалийн бүрдүүлэлтийг хялбарчлах болон хилийн боомтын хөгжлийг дэмжих чиглэлээр боловсруулсан гурван талт хамтын ажиллагааны баримт бичгүүдийн төслийг эцэслэн зөвшилцөх зорилгоор монгол-орос-хятадын гаалийн байгууллагын шинжээч мэргэжилтнүүдийн уулзалтыг 2015 оны 6-р сарын 10-12-ны өдрүүдэд Улаанбаатар хотноо амжилттай зохион байгуулсан.

**II.** Гурван талт бичиг баримтуудад гарын үсэг зурах ёслолын үйл ажиллагаа ОХУ-ын Уфа хотноо 2015 оны 7 дугаар сарын 9-ны өдөр болж, тус арга хэмжээний үеэр:

- “Монгол Улс, ОХУ болон БНХАУ-ын хооронд худалдааны хөгжлийг дэмжихийн тулд таатай нөхцөл бүрдүүлэх хүрээнд хамтран ажиллах тухай Монгол Улсын ГЕГ, ОХУ-ын ХГА болон БНХАУ-ын ГЕГ

хоорондын Санамж бичиг”

- “Монгол, орос, хятадын хилийн боомтын хөгжлийн салбарт хамтран ажиллах тухай МУ-ын ГЕГ, ОХУ-ын Хилийн бүтээн байгуулалтын холбооны агентлаг болон БНХАУ-ын ГЕГ хоорондын Ерөнхий хэлэлцээр” тус тус гарын үсэг зурсан.

**III.** Хятадын талын санаачилгаар дээрх Санамж бичгийг хэрэгжүүлэх зорилгоор Монгол-Орос-Хятадын гаалийн байгууллагын дарга нарын “Гурван талт” анхны уулзалтыг 2015 оны 12-р сарын 17-ны өдөр Бээжин хотноо зохион байгуулсан.

Тус уулзалтаар Гурван талт хамтын ажиллагааны Нарийн бичгийн дарга нарын газрыг Монгол Улсад байгуулж, гурван талт ажлын хэсгийн анхдугаар хуралдааныг 2016 онд Монгол Улсад зохион байгуулахаар тус тус тохиролцсон юм.

## 2016 ОН

**Гурван талт ажлын хэсгийн Анхдугаар хуралдаан:** Улаанбаатар хотноо 2016 оны 5 дугаар сарын 10-12-ны өдрүүдэд болсон хуралдаанаар “Худалдааг дэмжихийн тулд таатай нөхцөл бүрдүүлэх хүрээнд хамтран ажиллах тухай Монгол Улсын ГЕГ, ОХУ-ын ХГА болон БНХАУ-ын ГЕГ-ын хоорондын Санамж бичиг”-ийг хэрэгжүүлэх зорилгоор гурван талт хамтын ажиллагааны хүрээнд нэн тэргүүнд хийх ажлын талаар Талууд санал солилцож, “Зарим нэр төрлийн бараанд хийсэн гаалийн хяналтын үр дүнг харилцан хүлээн зөвшөөрөх тухай МУ-ын ГТЕГ, БНХАУ-ын ГЕГ болон ОХУ-ын ХГА хоорондын Хэлэлцээр”-ийг ойрын үед байгуулахыг санал нэгтэй дэмжсэн. Тус Хэлэлцээрийн төслийн зүйл заалт бүрийг нэг бүрчлэн хэлэлцсэний үр дүнд Хэлэлцээрийн төслийг Талууд эцэслэн зөвшилцсөн.

Улмаар БНУзУын нийслэл Ташкент хотноо 2016 оны 6-р сарын 22-24-ны өдрүүдэд болсон ШХАБ-ын форумын хүрээнд болсон Монгол Улс, ОХУ, БНХАУ-ын Ерөнхийлөгч нарын уулзалтын дараа “Зарим нэр төрлийн бараанд хийсэн гаалийн хяналтын үр дүнг харилцан хүлээн зөвшөөрөх тухай Монгол Улсын Гааль, татварын ерөнхий газар, Оросын Холбооны Улсын Холбооны гаалийн алба болон Бүгд Найрамдах Хятад Ард Улсын Гаалийн ерөнхий газар хоорондын Хэлэлцээр”-т Монгол Улсын ГТЕГ-ын дарга асан С.Пүрэв, ОХУ-ын ХГА-ны дарга асан А.Ю.Бельянинов, БНХАУ-ын ГЕГ-ын дарга асан Юй Гуанжоу нар 2016 оны 6 дугаар сарын сарын 23-ны өдөр гарын үсэг зурсан.

**2017 ОН**

**Гурван талт ажлын хэсгийн Хоёрдугаар хуралдаан:** БНХАУ-ын Харбин хотод 2017 оны 6 дугаар сарын 13-16-ны өдрүүдэд ажлын хэсгийн Хоёрдугаар хуралдаан зохион байгуулагдсан бөгөөд тус хуралдаанд МУ-ын ГЕГ-ын дэд дарга Ё.Бат-Эрдэнэ тэргүүтэй төлөөлөгчид оролцсон. Тус хуралдаанаар ажлын хэсгийн анхдугаар хуралдаанаас хойш Монгол, Орос, Хятадын гаалийн байгууллага хоорондын хамтын ажиллагааны чиглэлээр хийсэн ажлыг дүгнэн, цаашид хийх ажлын талаар санал солилцсон.

Тус хуралдаанаар Монгол-Орос-Хятадын гаалийн байгууллагын гурван талт хамтын ажиллагааны механизм, үйл ажиллагааны зарчим, хамрах хүрээ, чиглэл зэрэг асуудлыг зохицуулсан “Монгол Улсын Гаалийн ерөнхий газар, Оросын Холбооны Улсын Холбооны гаалийн алба болон Бүгд Найрамдах Хятад Ард Улсын Гаалийн ерөнхий газрын хамтын ажиллагааны тухай дүрэм”-ийн төслийг эцэслэн зөвшилцсөн.

Улмаар Гурван орны төрийн тэргүүн нарын ээлжит 4 дэх уулзалтын хүрээнд зохион байгуулагдах Монгол-Орос-Хятадын гаалийн байгууллагын дарга нарын Хоёрдугаар уулзалтын үеэр “Монгол Улсын Гаалийн ерөнхий газар, Оросын Холбооны Улсын Холбооны гаалийн алба болон Бүгд Найрамдах Хятад Ард Улсын Гаалийн ерөнхий газрын хамтын ажиллагааны тухай дүрэм”-д гарын үсэг зурахаар Талууд тохиролцсон.

**2018 ОН**

ОХУ-ын Москва хотноо 2018 оны 4 дүгээр сарын 26-29-ний өдрүүдэд зохион байгуулагдсан Монгол-Орос-Хятадын гаалийн байгууллагуудын шинжээч нарын уулзалтад ГЕГ-ын ГХШГ-ын ГУАБ С.Отгонпүрэв тэргүүтэй төлөөлөгчид амжилттай оролцсон. “Зарим нэр төрлийн бараанд хийсэн гаалийн хяналтын үр дүнг харилцан хүлээн зөвшөөрөх тухай Монгол Улсын Гааль, татварын ерөнхий газар, Оросын Холбооны Улсын Холбооны гаалийн алба болон Бүгд Найрамдах Хятад Ард Улсын Гаалийн ерөнхий газар хоорондын Хэлэлцээр”-ийн хэрэгжилтийн техникийн бэлтгэл хангах, түүнчлэн оросын талын хариуцан зохион байгуулах ажлын хэсгийн Гуравдугаар хуралдааны бэлтгэл хангах хүрээнд тус хуралдааны үеэр холбогдох бичиг баримтын төслүүдийг эцэслэн зөвшилцөх зэрэг асуудлуудыг хэлэлцэн шийдвэрлэсэн.

Гурван талт ажлын хэсгийн Гуравдугаар хуралдааныг ОХУ-ын Москва хотноо 2018 оны

12 дугаар сард зохион байгуулахаар төлөвлөж байгаа тухай оросын талаас мэдэгдсэн.

**2019 ОН:**

**Гурван талтын ажлын хэсгийн Гуравдугаар хуралдаан:** Москва хотноо 2019 оны 2 дугаар сарын 26-27-ны өдрүүдэд болсон гурван талт ажлын хэсгийн Гуравдугаар хуралдааныг ОХУ-ын ХГА-ны Гадаад хамтын ажиллагааны газрын орлогч дарга А.Ю.Краснопояс даргалсан бөгөөд тус хуралдаанд монголын талаас ГЕГ-ын ГХШГ-ын ГУАБ С.Отгонпүрэв тэргүүтэй төлөөлөгчид оролцсон. Тус хуралдаанаар Талууд доорх асуудлуудаар санал солилцож, хэлэлцэн шийдвэрлэв. Үүнд:

1. Москва хотноо 2018 оны 4 дүгээр сарын 26-ны өдөр болсон Монгол Улс, ОХУ, БНХАУ-ын гаалийн байгууллагын шинжээч нарын ажлын уулзалтаар хэлэлцсэн 7 асуудлаас 4 асуудлыг Талууд эцэслэн зөвшилцөв. Бусад 3 асуудлыг техникийн мэргэжилтнүүд дахин нягтлан ярилцаж, гурван талтын хооронд мэдээлэл солилцох Техникийн нөхцөл боловсруулах шаардлагатай хэмээн үзэж, МТ-ийн шинжээч нарын ажлын Хоёрдугаар уулзалтыг 2019 оны 6 дугаар сард Москва хотноо зохион байгуулахаар шийдвэрлэв;
2. 2016 оны 6 дугаар сарын 23-ны өдөр байгуулсан “Зарим нэр төрлийн бараанд хийсэн гаалийн хяналтын үр дүнг харилцан хүлээн зөвшөөрөх тухай Монгол Улсын Гааль, татварын ерөнхий газар, Оросын Холбооны Улсын Холбооны гаалийн алба болон Бүгд Найрамдах Хятад Ард Улсын Гаалийн ерөнхий газар хоорондын Хэлэлцээр” (цаашид “Хэлэлцээр” гэх)-ийн хэрэгжилтийг хангах асуудлаар Талууд санал солилцож, Хэлэлцээрийн туршилтыг хэрэгжүүлэх “хилийн боомт”-ыг, “тээврийн хэрэгслийн төрөл”-ийг, “барааны нэр төрөл” гэсэн мэдээллийг эцэслэн тохиров.
3. “Монгол Улсын ГЕГ, ОХУ-ын ХГА болон БНХАУ-ын ГЕГ-ын хамтын ажиллагааны дүрэм”-ийн төслийг эцэслэн зөвшилцөж, ойрын үед зохион байгуулагдах Талууд дарга нарын уулзалтын үеэр гарын үсэг зурахаар тохиролцов.
4. Монгол Улс, Оросын Холбооны Улс болон Бүгд Найрамдах Хятад Ард Улсын гаалийн байгууллагын ажлын хэсгийн Дөрөвдүгээр хуралдааныг 2019 оны 9 дүгээр сард Монгол Улсын Улаанбаатар хотноо зохион байгуулахаар Талууд тохиролцов.

## АШИГЛАСАН МАТЕРИАЛЫН ЖАГСААЛТ

1. Олон улсын гэрээний эрх зүйн тухай 1969 оны Венийн Конвенц;
2. Олон улсын гэрээний тухай Монгол Улсын хууль (2016 он);
3. Дэлхийн худалдааны байгууллага, Олон талт худалдааны хэлэлцээний үе шатны дүнд байгуулсан эрх зүйн баримт бичгүүд, Улаанбаатар, 2000 он;
4. Энэтхэг Улсын Гадаад худалдааны институтын ДХБ-ын судалгааны төвийн профессор Мукеш Бхатнагар, дэд профессор Доктор Сачин Шарма нарын презентейшнүүд, Улаанбаатар, 2018 он;
5. Alfred Cellami & Leon Retami & Ledia Balla, *The General Agreement on Tariffs and Trade (GATT)*;
6. Хууль тогтоомж, шүүх эрх мэдлийн эрдэм шинжилгээ, сургалт мэдээлэл, сурталчилгааны үндэсний төв, Олон улсын хувийн эрх зүй: Баримт бичгийн эмхтгэл, Улаанбаатар, 2004 он;
7. CITES-ийг хэрэгжүүлэх Монголын үндэсний зөвлөл, Зэрлэг амьтан ба ургамлын аймгийн ховордсон зүйлийг олон улсын хэмжээнд худалдаалах тухай Конвенц: Лавлах, Улаанбаатар, 2001 он;
8. Монгол Улсын CITES-ын Удирдан зохицуулах зөвлөлийн товхимол, №8, 2001 он;
9. НҮБ-ын БОХ, "Озоны давхрагыг хамгаалах" асуудлаар Гаалийн ажилтнуудад зориулан зохион байгуулсан семинарын гарын авлага: Хөгжиж буй орнуудад озон задлагч бодисуудыг үе шаттайгаар устгах нь, 2001 он;
10. С.Энхтуяа, Гаалийн ажилтанд зориулсан гарын авлага: Озон задалдаг бодист тавих хяналт, хууль бус худалдаа, Улаанбаатар, 2007 он;
11. ДХБ-ын Нарийн бичгийн дарга нарын газрын илтгэл: Монгол Улсын худалдааны бодлогыг хянан үзэх нь (WT/TPR/S/145), 2005;
12. <http://atuya.blogmn.net/62595/>;
13. [https://www.quora.com/What-are-green-blue-and-amber-box-subsidies-in-layman-terms](https://www.quora.com/What-are-green-blue-and-amber-box-subsidies-in-layman-terms;);
14. <http://www.mfa.gov.mn/wp-content/uploads/2016/09/%D1%82%D0%B0%D0%B-D%D0%B8%D0%B-V%D1%86%D1%83%D1%83%D0%B-V%D0%B3%D0%B0-2017-05-04.pdf>;
15. <https://www.mongolchamber.mn/mn/newsDetail/186>;
16. Холбогдох олон улсын байгууллагын болон бусад сайтууд.